

Монгол Улс
Онцгой Байдлын Ерөнхий Газар (ОБЕГ)

**МОНГОЛ УЛСЫН ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН
ГАМШГААС ХАМГААЛАХ ЧАДАВХЫГ
БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ**

ТӨСЛИЙН ТӨГСГӨЛИЙН ТАЙЛАН

2020 оны 1-р сар

**ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
БАЙГУУЛЛАГА (ЖАЙКА)**

**ОРИЕНТАЛ КОНСАЛТАНЦ ГЛОБАЛ ХК
КОКУСАЙ КОГЁО ХК**

**ОЁО ИНТЕРНАШНЛ КОРПОРАЦИ
ХОТЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ХҮРЭЭЛЭН**

GE
JR
19-078

Монгол Улс
Онцгой Байдлын Ерөнхий Газар (ОБЕГ)

**МОНГОЛ УЛСЫН ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН
ГАМШГААС ХАМГААЛАХ ЧАДАВХЫГ
БЭХЖҮҮЛЭХ ТӨСӨЛ**

ТӨСЛИЙН ТӨГСГӨЛИЙН ТАЙЛАН

2020 оны 1-р сар

**ЯПОНЫ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
БАЙГУУЛЛАГА (ЖАЙКА)**

**ОРИЕНТАЛ КОНСАЛТАНЦ ГЛОБАЛ ХК
КОКУСАЙ КОГЁО ХК**

**ОЁО ИНТЕРНАШНЛ КОРПОРАЦИ
ХОТЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ХҮРЭЭЛЭН**

Гадаад валютын ханш

Валютын төрөл	Ханш
Америк доллар (USD1=₮)	109.485
Монгол төгрөг(MNT1 = ¥)	0.04179

(2019 оны 12-р сарын ЖАЙКА-ын тооцох ханш)

Гарчиг

I.	Төслийн ерөнхий мэдээлэл.....	1
I.1	Төсөл хэрэгжүүлэх улс, орон	1
I.2	Төслийн нэр.....	1
I.3	Төслийн үргэлжлэх хугацаа (төлөвлөсөн ба бодит)	1
I.4	Угтвар нөхцөл (Хэлэлцүүлгийн тэмдэглэлийн (Х/Т) дагуу)	1
I.5	Ерөнхий зорилго ба төслийн зорилт (Хэлэлцүүлгийн тэмдэглэлийн (Х/Т) дагуу)	2
I.6	Төслийг хэрэгжүүлэх агентлаг.....	3
I.6.1	Төслийн ерөнхий бүтэц.....	3
I.6.2	Төслийн удирдлагын бүтэц.....	3
II.	Төслийн үр дүн	7
II.1	Төслийн үр дүн.....	7
II.1.1	Японы талаас оруулсан хувь нэмэр (төлөвлөсөн ба бодит дүн) ...	7
II.1.2	Монголын талаас оруулсан хувь нэмэр (төлөвлөсөн ба бодит дүн)	10
II.1.3	Үйл ажиллагаа (төлөвлөсөн ба бодит дүн).....	11
II.2	Төслийн зорилтын хүрээнд хүрсэн үр дүн	64
II.2.1	Үр дүн ба шалгуур үзүүлэлтүүд	64
II.2.2	Төслийн зорилт ба шалгуур үзүүлэлтүүд	71
II.3	Төслийн төлөвлөлтийн матрицад (ТТМ) орсон өөрчлөлтүүд	72
II.4	Бусад	72
II.4.1	Байгаль орчны болон нийгмийн асуудлууд (байх тохиолдолд).....	72
II.4.2	Жендерийн эрх тэгш байдал/Энхийг дэмжих/Ядуурлыг бууруулахтай холбоотой асуудлууд (байх тохиолдолд).....	72
III.	Хамтарсан хяналтын үр дүн.....	73
III.1	DAC үнэлгээний үзүүлэлтүүдэд суурилсан хяналтын үр дүн.....	73
III.2	Хэрэгжүүлэлт болон үр дүнд нөлөөлөх гол хүчин зүйлс	79
III.3	Төслийн эрсдэлийн удирдлагын үнэлгээний үр дүн	84
III.4	Сургамж.....	84
IV.	Төсөл хэрэгжиж дууссаны дараа ерөнхий зорилгод хүрэх	86
IV.1	Ерөнхий зорилгод хүрэх ирээдүйн төлөв байдал	86
IV.2	Ерөнхий зорилгод хүрэх Монголын талын үйл ажиллагааны төлөвлөгөө болон түүний хэрэгжилтийн бүтэц	89
IV.3	Монголын талд өгөх санал зөвлөмж.....	90

IV.4 Төслийн төгсгөлөөс Төслийн дараах үнэлгээ хүртэлх хугацааны хяналтын төлөвлөгөө.....	91
--	----

Зургийн жагсаалт

Зураг I.6.1	Төслийн удирдлагын бүтэц	4
Зураг II.1.1	Газар хөдлөлтийн гамшгийн үед авах арга хэмжээнд санамж бичгийн эзлэх байр суурь, ач холбогдлын талаарх сургалтын байдал	19
Зураг II.1.2	Туршилтын аймаг болох Өмнөговь аймгийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах сургалт	22
Зураг II.1.3	Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд орон зайн мэдээллийн санг ашиглах 2 өдрийн сургалтын дадлага ажил	25
Зураг II.1.4	2019 оны 10-р сарын 24, 25-нд зохион байгуулсан Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд орон зайн мэдээллийн санг ашиглах ахисан түвшний сургалт	26
Зураг II.1.5	Барилгын дүрэм боловсруулах дараалал	30
Зураг II.1.6	Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлалын тухай сургалт	31
Зураг II.1.7	Хэмжилтийн багаж, төхөөрөмж ашиглах тухай сургалт ..	32
Зураг II.1.8	Холбогдох байгууллагуудын сургагч багш бэлдэх сургалт	33
Зураг II.1.9	МБИХ-ны газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээний сургалт	33
Зураг II.1.10	Хүчитгэлийн зураг төсөл боловсруулахаар сонгогдсон барилгуудын байршил болон гадаад байдал.....	35
Зураг II.1.11	Цутгамал төмөр бетон барилгыг нэмэлт ханаар хүчитгэсэн жишээ	36
Зураг II.1.12	Барилгын хүчитгэлийн сургалт.....	37
Зураг II.1.13	Батлагдсан сургалтын хөтөлбөр	39
Зураг II.1.14	Сургагч багшийн сургалт дээрх лекц ба воркшоп (1 дэх сургалт).....	45
Зураг II.1.15	Сургагч багшийн сургалт дээрх лекц ба воркшоп (2 дахь сургалт)	46
Зураг II.1.16	Асуулга судалгааны үр дүн.....	47
Зураг II.1.17	Загвар сургууль, цэцэрлэг дээрх үйл ажиллагаа	49
Зураг II.1.18	ОБЕГ-ын даргын тушаалаар батлагдсан үйл	

	ажиллагааны дүрэм	49
Зураг II.1.19	Нэгдсэн график төлөвлөгөөний веб хуудас, сургалт явуулсан байдал	52
Зураг II.1.20	“Бэлэн бай!” хэрэглэгдэхүүний багцын хүрээнд боловсруулсан зорилтот гамшиг ба хэрэглэгдэхүүний төрлүүд	53
Зураг II.1.21	Сургалтын хэрэглэгдэхүүний агуулга	55
Зураг II.1.22	Туршилтын орон нутагт хэрэгжүүлсэн сургагч багшийн сургалт	57
Зураг II.1.23	Туршилтын орон нутаг дахь иргэдэд чиглэсэн гамшигаас хамгаалах сургалт	58
Зураг II.1.24	НИГХСАЗТ-ийн сургалтын хөтөлбөртэй танилцсан байдал	60
Зураг II.1.25	Газар хөдлөлтийг биеэр мэдрэх танхимд байрлуулсан үзүүлэн самбар, макетуудын байрлал	62
Зураг II.1.26	Газар хөдлөлтийг биеэр мэдрэх танхимд байрлуулсан үзүүлэн самбар, макетууд	63
Зураг II.1.27	Барилгын макет (зүүн: тоосгон хийц/ баруун: угсармал хийц)	63
Зураг II.1.28	Хүүхдийн өрөөний ширээний театр	64

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт I.5.1	Ерөнхий зорилго, төслийн зорилт, үр дүн болон үйл ажиллагааны хураангуй.....	2
Хүснэгт I.6.1	ХЗХ-ны хурлын агуулга.....	5
Хүснэгт II.1.1	ЖАЙКА-ын мэргэжилтнүүдийн томилолт	7
Хүснэгт II.1.2	Сургалтын агуулга	9
Хүснэгт II.1.3	Нийлүүлсэн тоног төхөөрөмжийн жагсаалт.....	10
Хүснэгт II.1.4	Үйл ажиллагааны зардал	10
Хүснэгт II.1.5	Х/Х талуудын албан тушаалтнуудын томилгоо	10
Хүснэгт II.1.6	Зааврын агуулга, хавсралт	15
Хүснэгт II.1.7	Төсөлтэй холбоотой дүрэм, журам	16
Хүснэгт II.1.8	Санамж бичиг байгуулах ажлын явц.....	17
Хүснэгт II.1.9	Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах туршилтын үйл ажиллагаа	20
Хүснэгт II.1.10	Цагаан номын агуулга.....	27
Хүснэгт II.1.11	Хүчитгэлийн жишээ зураг төсөл боловсруулахаар сонгогдсон барилгууд.....	34
Хүснэгт II.1.12	Гарын авлагын агуулга (Бага, суурь, бүрэн дунд боловсрол).....	41
Хүснэгт II.1.13	Гарын авлагын агуулга (Сургуулийн өмнөх боловсрол) ..	42
Хүснэгт II.1.14	Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт	43
Хүснэгт II.1.15	Загвар сургууль цэцэрлэг дээрх үйл ажиллагаа	48
Хүснэгт II.1.16	Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны багийн зорилго ба удирдах зөвлөлийн гишүүд.....	51
Хүснэгт II.1.17	Сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулахад.....	54
Хүснэгт II.1.18	ЖАЙКА Мэргэжилтний баг ба холбогдох байгууллагуудын сургалтын материал боловсруулахад хариуцах хэсэг.....	55
Хүснэгт II.1.19	Орон нутгийн гамшгаас хамгаалах сургалт явуулах санал болгосон туршилтын орон нутаг.....	57
Хүснэгт II.1.20	Зохион байгуулсан буухиа тэмцээн болон хэрэглэгдэхүүний тоо	59
Хүснэгт II.1.21	Самбарын агуулга	61
Хүснэгт II.2.1	69

Хүснэгт II.2.2	Төслийн үр дүн ба шалгуур үзүүлэлт.....	69
Хүснэгт II.2.3	Төслийн зорилт, үр дүн ба үзүүлэлтүүд.....	71
Хүснэгт II.3.1	ТТМ-д орсон өөрчлөлтүүд.....	72
Хүснэгт III.1.1	Нэмэлт төсвийн агуулга.....	74
Хүснэгт III.1.2	Ерөнхий зорилго, Бодит үзүүлэлтүүд ба хэтийн төлөв....	75

Монгол Улсын Газар Хөдлөлтийн Гамшгаас
Хамгаалах Чадавхыг Бэхжүүлэх төсөл
Төслийн Төгсгөлийн Тайлан

【Товчилсон нэр】

ADB	Asian Development Bank	Азийн хөгжлийн банк
ADPC	Asian Disaster Preparedness Center	Азийн гамшгийн бэлэн байдлын төв
ALAGaC	Administration of Land Affairs, Geodesy, and Cartography of Mongolia	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар
AMCDRR	Asian Ministerial Conference on Disaster Risk Reduction	Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын бага хурал
CBDRM CBDRR	Community Based Disaster Risk Management/ Community Based Disaster Risk Reduction	Олон нийтийн оролцоонд суурилсан гамшгийн эрсдэлийн менежмент/ Олон нийтийн оролцоонд суурилсан гамшгийн эрсдэлийг бууруулах
CCM	Construction Code of Mongolia	Монгол Улсын барилгын норм
CR	Construction Regulation	Барилгын дүрэм
DB	Database	Мэдээллийн сан
DRM	Disaster Risk Management	Гамшгийн эрсдэлийн менежмент
DRR	Disaster Risk Reduction	Гамшгийн эрсдэлийг бууруулах
EMDC	Emergency Management Department of the Capital City	Нийслэлийн онцгой байдлын газар
FAO	Food and Agriculture Organization of the United Nations	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага
GIS	Geographic Information System	Газар зүйн мэдээллийн систем
IAG	Institute of Astronomy and Geophysics	Одон орон, геофизикийн хүрээлэн
JICA	Japan International Cooperation Agency	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага
MAS	Mongolian Academy of Sciences	Монгол Улсын Шинжлэх ухааны академи
MECSS	Mongolian Ministry of Education, Culture, Science and Sports	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам
M	Magnitudes	Магнитуд
MCUD	Ministry of Construction and Urban Development	Барилга, хот байгуулалтын яам
MNT	Mongolian tögrög	Монгол төгрөг
MP	Master Plan	Мастер төлөвлөгөө
MRCSS	Mongolian Red Cross Society	Монголын улаан загалмайн нийгэмлэг
MSK	Medvedev-Sponheuer-Karnik intensity scale	MSK газар хөдлөлийн шаталбар
MUST	Mongolian University of Science and Technology	Шинжлэх ухаан, технологийн их сургууль
NDC	Mongolian National Data Center	Монголын үндэсний дата төв
NEMA	National Emergency Management Agency	Онцгой байдлын ерөнхий газар

*Монгол Улсын Газар Хөдлөлтийн Гамшгаас
Хамгаалах Чадаврыг Бэхжүүлэх төсөл
Төслийн Төгсгөлийн Тайлан*

NGO	Non-Governmental Organization	Төрийн бус байгууллага
NIED	National Research Institute for Earth Science and Disaster Resilience	Гамшгаас хамгаалах шинжлэх ухаан, технологийн судалгааны үндэсний хүрээлэн
PDM	Project Design Matrix	Төсөл төлөвлөлтийн матриц
RC	Reinforced Concrete	Хүчитгэсэн бетон
SDGs	Sustainable Development Goals	Тогтвортой хөгжлийн зорилтууд
SFDRR	Sendai Framework for DRR	Сендайн үйл ажиллагааны хүрээ
SMS	Short Message Service	Гар утасны мессеж шуудан
SISDRR	Spatial Information System for Disaster Risk Reduction	Гамшгийн эрсдэлийг бууруулах орон зайн мэдээллийн систем
UB	Ulaanbaatar	Улаанбаатар
TOT	Training of Trainers	Сургагч багш бэлтгэх сургалт
UBMPS	The Study on City Master Plan and Urban Development Program of Ulaanbaatar City	Улаанбаатар хотын Хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөө, Хот байгуулалтын хөтөлбөрийн судалгаа
UNICEF	United Nations Children's Fund	НҮБ-ын Хүүхдийн сан
UNDP	United Nations Development Programme	НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр
UNDRR	United Nations Office for Disaster Risk Reduction	НҮБ-ын Гамшгийн эрсдэлийг бууруулах газар
USD	United States Dollar	Америк доллар
WB	World Bank	Дэлхийн банк
WG	Working Group	Ажлын хэсэг
WHO	World Health Organization	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

Төслийн төгсгөлийн тайлан

I. Төслийн ерөнхий мэдээлэл

I.1 Төсөл хэрэгжүүлэх улс, орон

Монгол улс

I.2 Төслийн нэр

Монгол Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл

I.3 Төслийн үргэлжлэх хугацаа (төлөвлөсөн ба бодит)

Бэлтгэл ажлыг хангах үүднээс төслийг эрт эхлүүлсэн болно.

Төлөвлөсөн (ажлын төлөвлөгөө): 2016 оны 12-р сар – 2019 оны 12-р сар

Бодит: 2016 оны 11-р сар – 2019 оны 12-р сар

I.4 Угтвар нөхцөл (Хэлэлцүүлгийн тэмдэглэлийн (Х/Т) дагуу)

Монгол улсад, ялангуяа улсын баруун хэсэгт, Рихтерийн шаталбарын дагуу магнитуд 8-ын газар хөдлөлтийн тохиолдлууд 20-р зуунд бүртгэгдсэн байдаг бөгөөд өнөөг хүртэл газар хөдлөлтийн эрсдэл нэмэгдсээр иржээ. Улмаар, Монгол улсын хүн амын тал нь оршин суудаг нийслэл Улаанбаатар хотын ойролцоо хэд хэдэн хагарлууд олдсон учир хүнд мэдрэгдэх болон мэдрэгдэхгүй газар хөдлөлтийн тохиолдлууд ихэссэн байна.

Өнөөгийн энэ нөхцөлд ЖАЙКА хөгжлийн төлөвлөлтийн хүрээнд техникийн туслалцаа үзүүлэх “Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийг Нийслэлийн онцгой байдлын газартай (НОБГ) хамтран 2012 оны 2-р сараас 2013 оны 10-р сар хүртэл дор дурдсан агуулгатайгаар хэрэгжүүлсэн байна:

- (1) Барилгын аюул, эрсдэлийн үнэлгээн дээр суурилсан газар хөдлөлтийн эрсдэлийн цогц газрын зургийг боловсруулах
- (2) Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах
- (3) Газар хөдлөлт тэсвэрлэх чадвартай дунд, өндөр давхарын барилга барих заавар боловсруулах
- (4) Хүний нөөц хөгжүүлэх (Япон улсад сургалтанд явуулах; сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа зохион байгуулах)

Энэхүү техникийн туслалцааны дараа Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ)

техникийн нэмэлт туслалцааг “Монгол улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх төсөл”-өөр дамжуулан үзүүлэх хүсэлтийг Японы Засгийн Газарт хүргүүлсэн байна. Монгол улс болон Японд хэд хэдэн удаа ОБЕГ, ЖАЙКА-ын төлөөлөгчдийн хоорондын уулзалт зохион байгуулж төслийн хамрах хүрээ, үйл ажиллагааны талаар хэлэлцсэний эцэст, ОБЕГ-ын чадавхыг бэхжүүлэх дээр анхаарч энэхүү төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэжээ.

I.5 Ерөнхий зорилго ба төслийн зорилт (Хэлэлцүүлгийн тэмдэглэлийн (Х/Т) дагуу)

Төслийг эхлүүлэх үед гаргасан ерөнхий зорилго, төслийн зорилт, хүлээгдэж буй үр дүнгүүд болон тэдгээрийн холбогдох үйл ажиллагаануудыг Хүснэгт Хүснэгт I.5.1.-д хураангуйлан харуулав.

Хүснэгт I.5.1 Ерөнхий зорилго, төслийн зорилт, үр дүн болон үйл ажиллагааны хураангуй

Ерөнхий зорилго	Газар хөдлөлтийн эрсдэлийг бууруулах	
Төслийн зорилт	Газар хөдлөлтийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаагаар дамжуулан Онцгой байдлын ерөнхий газрын чадавхыг бэхжүүлэх.	
	Үр дүн	Үйл ажиллагаа
Үр дүн1	Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хэрэглэгдэх мэдээлэл цуглуулах чадавхыг бэхжүүлж, холбогдох байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах.	1.1 Шинэчлэн баталсан Гамшгаас хамгаалах тухай хуулийн заалтуудыг тусгаж гамшгаас хамгаалах тогтолцоог сайжруулах 1.2 Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх 1.3 Улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахад хэрэгжүүлэх хяналтын болон мэдээлэл цуглуулах аргачлалыг сайжруулах
Үр дүн2	Төрийн захиргааны албан хаагчдын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ, барилгын хүчитгэл хийх чадварыг бэхжүүлэх.	2.1 Барилга, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлалыг боловсруулж, үнэлгээний сургалт зохион байгуулах 2.2 Барилгын хүчитгэлийн зааврыг боловсруулж, хүчитгэлийн сургалт зохион байгуулах

Үр дүн3	Гамшгаас хамгаалах боловсрол, сургалт, сурталчилгааны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх.	3.1 Сургууль, цэцэрлэгийн гамшгаас хамгаалах боловсрол, сургалтын материалын зааврыг боловсруулж, сургагч багш нарыг бэлтгэх сургалт зохион байгуулах 3.2 Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны материалыг боловсруулж иргэд болон зорилтот бүлгийнхэнд сургалт зохион байгуулах
---------	---	--

I.6 Төслийг хэрэгжүүлэх агентлаг

I.6.1 Төслийн ерөнхий бүтэц


Төслийг хамтран хэрэгжүүлж буй (Х/Х) тал нь Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ) байхаар төслийн зорилтонд заасан байна. ОБЕГ төслийн зорилтуудыг биелүүлэхэд дараах Х/Х талуудтай хамтран ажилласан, үүнд:

- Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ)
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам (БССШУЯ)-
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ)
- Нийслэлийн онцгой байдлын газар (НОБГ)
- Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газрын Барилгын чанар, аюулгүй байдлын хэлтэс

I.6.2 Төслийн удирдлагын бүтэц

Төслийн хэрэгжүүлэлтийн бүтцийг Зураг I.6.1.-д үзүүлэв.

Үр дүн бүрийн үйл ажиллагаанд хэд хэдэн оролцогч талууд оролцох тул Төслийн үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх үүднээс гамшгаас хамгаалах төлөвлөгөө, газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ, гамшгаас хамгаалах боловсрол зэрэг 3 Үр дүн тус бүрт Ажлын хэсэг (А/Х) байгуулав.



Зураг I.6.1 Төслийн удирдлагын бүтэц

ОБЕГ-ын Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын даргыг Төслийн захирлаар томилсон бөгөөд Төслийн захирал (ТЗ) нь Төслийн удирдлага, хэрэгжүүлэлтийг хариуцах ерөнхий үүрэгтэй.

ОБЕГ-ын Бодлого зохицуулалт, хамтын ажиллагааны газрын даргыг Төслийн менежерээр томилсон бөгөөд Төслийн менежер (ТМ) нь зохион байгуулалтын асуудлыг хариуцана.

ЖАЙКА-гийн мэргэжилтний баг (ЖМБ) нь ОБЕГ болон бусад Х/Х талуудад Төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай техникийн зөвлөгөө, санал гаргаж өгнө.

Байгууллага хоорондын уялдаа холбоог сайжруулах үүднээс Хамтарсан зохицуулах хороог (ХЗХ) байгуулсан. ХЗХ-ны хурал нь улиралд нэг удаа эсвэл шаардлагатай гэж үзвэл аль ч үед зохион байгуулагддаг. Удирдах хорооны (У/Х) хурал нь ХЗХ-ны хурлын өмнө зохион байгуулагддаг бөгөөд уг хурлын үеэр төслийн үйл явцын талаар хэлэлцэж шаардлагатай мэдээллийг хуваалцдаг.

Төслийн үргэлжлэх хугацаанд нийт есөн (9) ХЗХ-ны хурал зохион байгуулагдаж, арван (10) У/Х-ны хурал зохион байгуулагджээ. Хүснэгт I.6.1-т ХЗХ-ны хурлуудын зохион байгуулагдсан огноо болон хэлэлцсэн асуудлыг хураангуйлан тусгав.

Хүснэгт I.6.1 ХЗХ-ны хурлын агуулга

Но.	Огноо	Оролцогчид	Хэлэлцсэн асуудал
1.	2016 оны 12-р сарын 7	ОБЕГ, БХБЯ, БСШУСЯ, МХЕГ, Барилгын чанар, аюулгүй байдлын хэлтэс; Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар (НХТЕТГ), г.м. Нийт: 28 оролцогчид	ХЗХ-ны гишүүд Ажлын төлөвлөгөө Хяналтын хуудас I & II “Хувилбар. 1” А/Х-ийн гишүүдийг томилгох Монгол улсын холбогдох захиргааны байгууллагуудад орсон өөрчлөлтүүд
2.	2017 оны 4-р сарын 14	ОБЕГ, БХБЯ, БСШУСЯ, МХЕГ, Барилгын чанар, аюулгүй байдлын хэлтэс; НХТЕТГ, г.м. Нийт: 37 оролцогчид	Япон дахь сургалтаас сурсан зүйлс А/Х тус бүрийн үйл ажиллагааны явц А/Х тус бүрийн гишүүдийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтүүд Монгол улсын холбогдох захиргааны байгууллагуудад орсон өөрчлөлтүүд Тоног төхөөрөмжийн нийлүүлэлт Япон улс эсвэл өөр гуравдагч улсад зохион байгуулах сургалт
3.	2017 оны 6-р сарын 29	ОБЕГ, БХБЯ, БСШУСЯ, МХЕГ, Барилгын чанар, аюулгүй байдлын хэлтэс; НХТЕТГ, г.м. Нийт: 42 оролцогчид	Хяналтын хуудас I & II “Хувилбар. 2” А/Х тус бүрийн үйл ажиллагааны явц Япон дахь 2-р сургалт Тоног төхөөрөмжийн нийлүүлэлт
4	2017 оны 12-р сарын 1	ОБЕГ, БХБЯ, БСШУСЯ, МХЕГ, Барилгын чанар, аюулгүй байдлын хэлтэс; НХТЕТГ, г.м. Нийт: 32 оролцогчид	- А/Х тус бүрийн үйл ажиллагааны явц - А/Х тус бүрийн гишүүдийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтүүд - Тоног төхөөрөмжийн нийлүүлэлт - Орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах туршилтын аймгууд
5	2018 оны 4-р сарын 23	ОБЕГ, БХБЯ, БСШУСЯ, МХЕГ, Барилгын чанар, аюулгүй байдлын хэлтэс; НХТЕТГ, г.м. Нийт: 35 оролцогчид	- А/Х тус бүрийн үйл ажиллагааны явц - А/Х тус бүрийн гишүүдийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтүүд - Тоног төхөөрөмж суурилуулах цаг хугацааны хуваарь - Гамшгаас хамгаалах боловсрол, сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа хэрэгжүүлэх туршилтын бүс нутаг - Дараагийн ХЗХ-ны хурлын тов
6	2018 оны 9-р сарын 21	ОБЕГ, БХБЯ, БСШУСЯ, МХЕГ, Барилгын чанар, аюулгүй байдлын хэлтэс; НХТЕТГ, г.м. Нийт: 34 оролцогчид	- А/Х тус бүрийн үйл ажиллагааны явц - А/Х тус бүрийн гишүүдийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтүүд - Тоног төхөөрөмжийн суурилуулалтын үйл явц - Дараагийн ХЗХ-ны хурлын тов
7	2018 оны 11-р сарын 1	ОБЕГ, БХБЯ, БСШУСЯ, МХЕГ, Барилгын чанар, аюулгүй байдлын хэлтэс; НХТЕТГ, г.м. Нийт: 36 оролцогчид	- А/Х тус бүрийн үйл ажиллагааны явц - А/Х тус бүрийн гишүүдийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтүүд - Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвд суурилуулах газар хөдлөлтийн чичирхийллийг биеэр мэдрэх тоног төхөөрөмжийн нийлүүлэлтийн үйл явц - Цагаан номыг нийтлэх цаашдын төлөвлөгөө - Дараагийн ХЗХ-ны хурлын тов

*Монгол Улсын Газар Хөдлөлтийн Гамшгаас
Хамгаалах Чадавхыг Бэхжүүлэх төсөл
Төслийн Төгсгөлийн Тайлан*

Но.	Огноо	Оролцогчид	Хэлэлцсэн асуудал
8	2019 оны 6-р сарын 5	ОБЕГ, БХБЯ, БСШУСЯ, МХЕГ, Барилгын чанар, аюулгүй байдлын хэлтэс; НХТЕТГ, г.м. Нийт: 29 оролцогчид	<ul style="list-style-type: none"> - А/Х тус бүрийн үйл ажиллагааны явц - А/Х тус бүрийн гишүүдийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлтүүд - Төслийн үзүүлэлтүүд дээр үндэслэн төслийн зорилтууд биелсэн эсэхийг баталгаажуулах - Төслийн ерөнхий зорилго биелсэн эсэхийг хэрхэн үнэлэх, холбогдох үзүүлэлтүүдийг хэрхэн тодорхойлох - Дараагийн ХЗХ-ны хурлын тов
9	2019 оны 11-р сарын 5	ОБЕГ, БХБЯ, БСШУСЯ, МХЕГ, Барилгын чанар, аюулгүй байдлын хэлтэс; НХТЕТГ, г.м.	<ul style="list-style-type: none"> - А/Х тус бүрийн үйл ажиллагааны явц - Төслийн төгсгөлийн тайланг батлах - ОБЕГ-ын цаашдын үйл ажиллагаа

II. Төслийн үр дүн

II.1 Төслийн үр дүн

II.1.1 Японы талаас оруулсан хувь нэмэр (төлөвлөсөн ба бодит дүн)

(1) Мэргэжилтэн томилох

Ажлын төлөвлөгөөн дахь Үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу нийт арван найман (18) Японы мэргэжилтнүүдийг Төсөлд томилон ажиллуулсан байна. Томилогдсон мэргэжилтэн бүрийн ажилласан хугацааг төлөвлөсөн болон бодит байдлаар Хүснэгт II.1.1.-т харуулав.

Хүснэгт II.1.1 ЖАЙКА-ын мэргэжилтнүүдийн томилолт

Үүрэг, хариуцлага		Томилолтын тоо		Хүн-сар (ХС)	
		Төлөвлөсөн	Бодит	Төлөвлөсөн	Бодит
Төслийн удирдлагын бүрэлдэхүүн	Багийн ахлагч / Нэгдсэн Гамшгийн эрсдэлийн удирдлага I	13	18	11.83	12.67
	Багийн дэд ахлагч / Нэгдсэн Гамшгийн эрсдэлийн удирдлага II	8*1	12*1	7.00	7.00
Үр дүн 1: Гамшгаас хамгаалах төлөвлөгөө	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө I	9	11	8.00	8.00
	Гамшгаас хамгаалах төлөвлөгөө II	4	4	3.50	3.50
	Гамшгаас хамгаалах тогтолцоо I	3	3	2.00	2.00
	Гамшгаас хамгаалах тогтолцоо II	3	3	2.00	2.00
	Гамшгаас хамгаалах мэдээлэл I	4	4	1.50	1.50
	Гамшгаас хамгаалах мэдээлэл II	3*1	3*1	0.5	0.5
Үр дүн 2: Газар хөдлөлт тэсвэрлэлт	Газар хөдлөлт тэсвэрлэлт	12	12	10.83	10.00
	Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ	5	5	3.00	3.00

Монгол Улсын Газар Хөдлөлтийн Гамшгаас
Хамгаалах Чадаврыг Бэхжүүлэх төсөл
Төслийн Төгсгөлийн Тайлан

	Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ / хүчитгэл I (Цутгамал төмөр бетон, угсармал том хавтгаалжин)	5	6	3.67	4.00
	Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ / хүчитгэл II (Өрөгт бүтээц)	3	3	1.20	1.20
	Барилгын хүчитгэлийн зураг төсөл	6	6	4.00	3.67
Үр дүн 3: Гамшгаас хамгаалах боловсрол	Гамшгаас хамгаалах боловсрол I	9	15	5.50	6.70
	Гамшгаас хамгаалах боловсрол II	8	9	5.50	※ 24.23
	Бүх нийтийн оролцоотой гамшгаас хамгаалах үйл ажиллагаа / Төслийн зохицуулалт I	10	9	6.17	6.00
	Гамшгаас хамгаалах сургалтын материал боловсруулах I	5	6	3.00	3.17
	Гамшгаас хамгаалах сургалтын материал боловсруулах II / Төслийн зохицуулалт II	※3_	※3_	※3	※3
			107	117	78.70

※1: Багийн дэд ахлагч нь Гамшгаас хамгаалах мэдээлэл II-т давхар томилогдсон тул үүний томилолтын тоог Багийн дэд ахлагчийн үүргийн томилолтын тоон дээр нэмэв.

※2: Гамшгаас хамгаалах боловсрол II-т хуваарилсан 1.2 ХС-ыг Гамшгаас хамгаалах боловсрол I-рүү шилжүүлж, 0.6 ХС-ыг Японд гүйцэтгэсэн ажил руу шилжүүлэв.

※3: Дотоодын мэргэжилтэн.

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний баг

(2) Сургалтын оролцогчдыг хүлээн авах

Монголын тал нь Японы мэдлэг, туршлага, техникийн аргачлалаас илүү нарийн суралцаж, олж авсан мэдлэгээ А/Х тус бүрийн хүрээнд боловсруулах заавар, сургалтын хөтөлбөрүүдэд шууд тусгах үүднээс 2-р сургалтыг гуравдагч улсад зохион байгуулахын оронд Японд зохион байгуулах хүсэлт гаргасан. Хамгийн тохиромжтой сургалтын хөтөлбөрийг хэлэлцсэний дараа, Япон дахь сургалтын хөтөлбөрийг дор дурдсан байдлаар А/Х-үүдийн үйл ажиллагааг харгалзан үзэж гурван (3) хэсэгт хуваасан байна.

Хүснэгт II.1.2 Сургалтын агуулга

Төлөвлөсөн			
Япон дахь 1-р сургалт		10 хүн	
Бодит			
Сургалт	Сэдэв	Оролцогчид (хүн)	
Япон дахь 1-р сургалт	Гамшгийн эрсдэлийг бууруулах ба удирдах	12	Нийт::44
Япон дахь 2-р сургалт	Үр дүн 1: Гамшгаас хамгаалах төлөвлөлтийн чадавхыг бэхжүүлэх	13	
	Үр дүн 2: Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ болон барилгын хүчитгэл хийх чадавхыг бэхжүүлэх	9	
	Үр дүн 3: Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх	10	

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

(3) Тоног төхөөрөмжийн нийлүүлэлт

Тоног төхөөрөмжийг үр ашигтай ашиглах зохион байгуулалтын талаар хэлэлцсэний эцэст нийт таван (5) газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний тоног төхөөрөмжийг Японы талаас нийлүүлсэн. Уг тоног төхөөрөмжүүдийг Төслийн зохион байгуулсан Газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээний сургалт болон БХБЯ-ны өдөрлөгийн үеэр тус тус танилцуулсан.

Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг дэмжих үүднээс Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвд газар хөдлөлтийн чичирхийллийг биеэр мэдрэх тоног төхөөрөмжийг мөн нийлүүлсэн байна.

Хүснэгт II.1.3 Нийлүүлсэн тоног төхөөрөмжийн жагсаалт

Тоног төхөөрөмжийн нэр	Тоо, ширхэг	
	Төлөвлөсөн	Бодит
Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний багаж, таван (5) төрөл	3	5
Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг дэмжих газар хөдлөлтийн чичирхийллийг биеэр мэдрэх тоног төхөөрөмж	1	1
Нийт өртөг (сая япон иен)	80	80

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

(4) Гадаад дахь үйл ажиллагааны зардал

Үйл ажиллагааны зардлын жагсалтыг Хүснэгт II.1.4.-т харуулав.

Хүснэгт II.1.4 Үйл ажиллагааны зардал

Зардлын нэр	Зардлын дүн (сая япон иен)
Оффисын хэрэгсэл	1.65
Сургалт зохион байгуулах	5.26
Сургалтын материал	0.44
Орчуулга	0.92
Төслийн туслах ажилтнууд	44.91
Нийт	53.18

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

II.1.2 Монголын талаас оруулсан хувь нэмэр (төлөвлөсөн ба бодит дүн)

(1) Төсөл хамтран хэрэгжүүлэгч талаас хийсэн томилгоо

ОБЕГ нь ТЗ, ТМ болон Төслийн Зохицуулагчийг томилж үүрэг гүйцэтгэсэн бөгөөд БХБЯ, БСШУСЯ, МХЕГ, НОБГ, Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газар зэрэг Х/Х талуудаас албан тушаалтнуудыг А/Х бүрт томилсон.

Хүснэгт II.1.5 Х/Х талуудын албан тушаалтнуудын томилгоо

Албан тушаалтан	Хүний тоо	
	Төлөвлөсөн	Бодит
Төслийн Захирал	1	1
Төслийн Менежер	1	1
Төслийн Зохицуулагч	1	1
Ажлын хэсэг	Үр дүн 1	11
	Үр дүн 2	6
	Үр дүн 3	4
Нийт	24	43

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

(2) Ажлын байраар хангах

ОБЕГ өөрийн төв байрандаа үйл ажиллагаа явуулахад хангалттай ажлын байр, хурлын өрөө, холбогдох мэдээ, мэдээлэл зэргийг гаргаж өгсөн. Х/Х талуудын орон нутгийн томилолтын зардал гэх мэт Төслийн үйл ажиллагааны зардлыг ОБЕГ бараг бүхэлд нь хариуцсан.

(3) Х/Х талын Засгийн газраас хариуцсан бусад зардал

Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвд газар хөдлөлтийн чичирхийллийг биеэр мэдрэх тоног төхөөрөмжийг суурилуулахад шаардлагатай засвар ажлын зардлыг ОБЕГ хариуцсан байна.

II.1.3 Үйл ажиллагаа (төлөвлөсөн ба бодит дүн)

(1) Үр Дүн 1

Үйл ажиллагаа 1.1.1 Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжүүлэлтэд тулгарч буй асуудлуудыг тодорхойлох

Төсөл эхлэх үед Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн агуулга дээр үндэслэн шинээр боловсруулах болон шинэчлэн сайжруулах шаардлагатай заавар журмын талаар Ажлын хэсэг 1 дээр хэлэлцэж Үр Дүн 1-ийн үйл ажиллагааны хүрээнд “Эрсдэлийн үнэлгээний заавар”, “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”, “Гамшгийн бэлэн байдлын заавар”, “Гамшгаас хамгаалах хяналтын заавар”, ба “Гамшгийн мэдээллийн сангийн заавар” гэсэн таван (5) төрлийн заавар журам боловсруулахаар төлөвлөсөн.

“Гамшгийн бэлэн байдлын заавар” нь гамшгийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, бэлэн байдлын зэргийн урьдчилсан арга хэмжээг зохицуулах, “Гамшгийн хяналтын заавар” нь газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтын асуудлыг зохицуулах заавар журам байна гэж тооцсон. Гэвч, албан ёсоор батлагдсан Гамшгаас хамгаалах тухай хуулинд “Гамшгийн бэлэн байдлын заавар” болон “Гамшгийн хяналтын заавар” боловсруулах талаарх заалтыг өөрчилсөн эсвэл хассан байна.

Тухайлбал, хуулийн 10.2, 10.8 болон 11.1 гэсэн заалтууд нь “Гамшгийн бэлэн байдлын заавар”-тай хамаарна гэж тооцогдож байсан. Гэвч, эдгээр заалтууд шинэчлэгдэж цагдаа, тагнуулын байгууллага болон зэвсэгт хүчний жанжин

штабын талаар эдгээр заалтуудад илүүтэйгээр тусгагдсан байна. Тус байгууллагуудын чиг үүрэг болон зарим мэдээлэл нь нууцын зэрэглэлд хамаардаг учраас “Гамшгийн бэлэн байдлын заавар”-ыг тусад нь боловсруулахгүй боловч бэлэн байдлыг хангах зарим арга хэмжээний талаар “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”-т тусгахаар шийдвэрлэсэн.

Мөн, хуулийн 12.2 дугаар зүйл нь “Гамшгийн хяналтын заавар”-тай хамаарах заалт гэж тооцогдож байсан. Гэвч, гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтын хэсгийг уг заалтаас хассан бөгөөд “Гамшгийн хяналт”-ыг хэрэгжүүлэх тухай гамшгаас хамгаалах хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтэд гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч хяналт тавина гэж шинээр заасан байна. Иймээс, Монголын тал нь хяналтын ажил нь нууцын зэрэглэлтэй мэдээллийг агуулах бөгөөд улсын хяналтын заавар боловсруулахад ЖМБ-ийн дэмжлэг шаардлагагүй гэж дурдсан.

Дээр дурдсаны дагуу, Төслийн Үр дүн 1-ийн хүрээнд “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний заавар”, дөрвөн (4) төрлийн “Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар” болон “Гамшгийн мэдээллийн сангийн заавар” гэсэн зургаан (6) зааврыг боловсруулахаар болсон.

Үйл ажиллагаа 1.1.2 Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомж, төлөвлөлт, төлөвлөгөөний уялдаа холбоог сайжруулах, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, гамшгийн мэдээллийн сангийн журам заавар боловсруулах

1) Газар Хөдлөлтийн Гамшгийн Эрсдэлийн Үнэлгээний Заавар

А/Х 1-ийн гишүүд “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний заавар”, “Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний техникийн зааварчилгаа” болон төв, орон нутгийн засаг захиргааны байгууллагын албан тушаалтнуудад зориулсан газар хөдлөлтийн эрсдэлийн хялбаршуулсан үнэлгээний програм хангамжийг боловсруулав. Төслийн эхэн үед төв, орон нутгийн засаг захиргааны байгууллагын албан тушаалтнуудад зориулсан “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний заавар” ба мэргэжилтэн болон судлаач нарт зориулсан “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний заавар” гэх хоёр (2) зааврыг боловсруулахаар төлөвлөж байв. Гэвч, заавруудыг боловсруулах явцад тус

хоёр зааврыг нэгтгэхээр А/Х 1-ийн гишүүд шийдсэн байна. Учир нь дээрх 2 зааварт эрсдэлийг үнэлэх болон шинжлэх аргачлалаас бусад агуулгын хооронд том ялгаа байхгүй юм. Эрсдэлийн үнэлгээний зорилго, хамрах хүрээ, хугацаа, зөвлөмж боловсруулах, эрсдэлийн үнэлгээний үр дүнг гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тусгах болон газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний тайлан боловсруулах бүлэг нь агуулгын хувьд ижил юм. Нарийвчилсан үнэлгээний аргачлал нь “Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний техникийн зааварчилгаа”-нд тусгагдсан. Нэгтгэсэн зааврыг 2019 оны 9-р сард батлуулсан.

Эдгээр заавар болон дагалдах програм хангамж нь Гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх журам (Засгийн газрын 2006 оны 176-р тогтоолын хавсралт)-ын хавсралтын нэг хэсэг нь болохоор төлөвлөгдөж байна.

А/Х 1-ийн гишүүд нь туршилтын аймгуудад дагалдах програм хангамжийг танилцуулж, тухайн аймгуудын газар хөдлөлтийн гамшгийн үүсч болзошгүй хохирлын төсөөллийг тооцоолж гаргав.

2) Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар

А/Х 1-ийн гишүүд дараах дөрвөн (4) зааврын төслийг боловсруулав. Үүнд: Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах улсын албадын төлөвлөгөө боловсруулах заавар, Аймаг/сумын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар ба Нийслэл/дүүргийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар юм.

А/Х 1-ийн гишүүд 2017 оны 12-р сард зохион байгуулагдсан Япон дахь сургалтаар орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний бүтэц ба үндсэн агуулгатай танилцсан. Сургалтаар сурч эзэмшсэн үр дүнг шинээр боловсруулсан заавруудын агуулгад тусгаж оруулсан. Ялангуяа, эрсдэлийн үнэлгээний үр дүнг газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд зохистойгоор ашиглахын тулд А/Х 1-ийн гишүүд газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах зорилт дэвшүүлэх шинэ ойлголтыг нэвтрүүлэв. Цаашид гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахад ажлын хэсэг байгуулах шаардлага хэрэгцээний талаар болон төлөвлөгөө боловсруулах ажлын шат дарааллыг заавруудад тодорхой зааж өгөв.

Үйл ажиллагаа 1.3.2.-ын хүрээнд туршилтын аймаг болон дүүргүүдэд Газар

Хөдлөлтийн Гамшгаас Хамгаалах төлөвлөгөө боловсруулах, шинэчлэн сайжруулах ажил явагдав. Туршилтын бүс нутаг дахь үйл ажиллагааны үр дүнд тухайн орон нутгийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтнүүдээс Зааврын агуулгын талаар санал авч Заавруудад нэмэлт өөрчлөлт оруулж тодотгон сайжруулсан.

“Аймаг/сумын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар” болон “Нийслэл/дүүргийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”-ыг 2019 оны 9-р сард боловсруулж дууссаны дараа, ОБЕГ-ын Даргын зөвлөлөөс эдгээр заавруудыг “Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”-ын бүтэцтэй уялдуулан нэгтгэх шаардлагатай гэсэн санал гарсан. Иймээс, А/Х 1 нь энэхүү хоёр зааврыг “Орон нутгийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар” болгон нэгтгэсэн. Тус “Орон нутгийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар” нь 2019 оны 11-р сард албан ёсоор батлагдах төлөвтэй байна.

Мөн, “Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар” болон “Гамшгаас хамгаалах улсын албадын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах нийтлэг заавар”-ыг 2019 оны 11-р сард албан ёсоор батлуулахаар ажиллаж байна.

3) Гамшгийн мэдээллийн сангийн заавар

Үйл ажиллагаа 1.3.3-ын хүрээнд дэд А/Х 1-5 нь “E-Comi map” системийн загварыг Монгол улсын онцлог, нөхцөл байдалд тулгуурлан интернетэд суурилсан гамшгийн орон зайн мэдээллийн системийг хөгжүүлж Монгол улсын онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр ажиллав. “E-Comi map” систем нь Японы Гамшгаас хамгаалах шинжлэх ухаан, технологийн хүрээлэнгийн боловсруулсан, интернэтэд суурилсан газар зүйн мэдээллийн системд зориулсан нээлттэй программ хангамж бөгөөд Япон улсад гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшигтай тэмцэх үйл ажиллагааны орон зайн мэдээллийг солилцоход амжилттай ашиглагдаж байна. Үүний зэрэгцээ, Гамшгаас хамгаалах мэдээллийн удирдлагын шинэ систем дээр тулгуурласан гамшгийн мэдээллийн санг удирдаж ажиллуулах баг байгуулах шаардлага хэрэгцээний талаар гамшгийн мэдээллийн сангийн дэд А/Х 1-5 дээр үргэлжлүүлэн хэлэлцэж ирсэн. Үүний үр дүнд 2018 оны 5-р сарын сүүлээр ОБЕГ-ын Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв дээр

“Гамшгийн орон зайн мэдээлэл, технологийн хэлтэс” (цаашид “ГОЗМТХ” гэх) 4 орон тоотойгоор шинээр байгуулагдсан.

Гамшгийн орон зайн мэдээллийн сангийн удирдлага, ашиглалтын зааврыг боловсруулах ажлыг шинээр байгуулагдсан ГОЗМТХ-ийн ажлын нарийвчилсан горим болон чиг үүргийн талаар хэлэлцэх үйл ажиллагаатай зэрэг эхлүүлжээ. ГОЗМТХ-ийн гишүүдтэй хэд хэдэн удаа зааврын агуулгыг тодорхойлох эрчимжүүлсэн уулзалтуудыг зохион байгуулсаны үндсэн дээр зааврын төслийг дагалдах бичиг баримттай нь 2018 оны 10-р сарын сүүлээр боловсруулж дууссан.

ОБЕГ-ын Даргын зөвлөл болон ХЗХ-ны гишүүдээс ирүүлсэн саналын дагуу өөрчлөлт оруулсны дараа Гамшгийн орон зайн мэдээллийн сангийн удирдлага, ашиглалтын зааврыг 2019 оны 2-р сарын 20-нд ОБЕГ-ын даргын А/47 дугаар тушаалаар батлав. Тус заавар нь “Гамшгийн кодчилол”, “Орон зайн мэдээллийн сангийн загвар” хэмээх 2 хавсралттай бөгөөд доорх хүснэгтэнд жагсаасан байдлаар 9 бүлэг агуулна:

Хүснэгт II.1.6 Зааврын агуулга, хавсралт

<p>Гамшгийн орон зайн мэдээллийн сангийн удирдлага, ашиглалтын заавар</p> <ul style="list-style-type: none"> • 1- бүлэг: Оршил • 2-р бүлэг: Нэр, томъёоны тодорхойлолт • 3-р бүлэг: ГОЗМС-ийн бүрдүүлэлт ба түүнд тавигдах шаардлагууд • 4-р бүлэг: ГОЗМС-ийн удирдлага • 5-р бүлэг: ГОЗМС-ийн ашиглалт • 6-р бүлэг: ГОЗМС-ийн хэрэглэгчдийн чиг үүрэг • 7-р бүлэг: ГОЗМС-ийн аюулгүй байдал • 8-р бүлэг: Хориглох зүйлс • 9-р бүлэг: Хууль, эрх зүйн арга хэмжээ 	<p>Хавсралт 1: Гамшгаас хамгаалах орон зайн мэдээллийн сангийн кодчилол</p> <ul style="list-style-type: none"> • 1. Кодчиллын систем боловсруулахын зорилго, • 2. Сэдэвчилсэн давхаргын кодчилол /гамшгийн код/ • 3. Суурь давхаргын кодчилол /байршлын код/ <p>Хавсралт 2: Гамшгаас хамгаалах орон зайн мэдээллийн сангийн загвар</p> <ul style="list-style-type: none"> • 1. ГОЗМС-ийн загварын танилцуулга • 2. Хазайсан давхарга болон газрын зурагт тавигдах шаардлага • 3. Суурь болон сэдэвчилсэн давхаргад шинэ багана үүсгэх, текстэнд өөрчлөлт оруулах • 4. ГОЗМС-ийн загварчлалд ашигалгдах ерөнхий нэр томъёо • 5. Суурь давхаргын загварчлал • 6. Сэдэвчилсэн давхаргын загварчлал
---	--

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Зааврын төслийг боловсруулах үе шатанд тус зааврын нэр нь Интернетэд суурилсан гамшгийн орон зайн мэдээллийн системийг ашигласан гамшгаас хамгаалах мэдээллийн сангийн удирдлага, ашиглалтын заавар байсан боловч зааврын нэрийг дээр дурдсан байдлаар албан ёсоор өөрчилсөн.

Үйл ажиллагаа 1.1.3 Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжүүлэлттэй холбоотой шинээр боловсруулах болон шинэчлэн сайжруулах журмын төслийг боловсруулах

А/Х 1-ийн гишүүд шинэчлэн найруулсан Гамшгаас хамгаалах тухай хуулийн эрсдэлийн үнэлгээ болон гамшгаас хамгаалах агуулгыг голчлон нягталж үзээд шинэ дүрэм, журам боловсруулах эсвэл одоогийн дүрэм, журамд өөрчлөлт оруулах шаардлага байгаа эсэх талаар судалсан байна. Хүснэгт II.1.7-д Төслийн хүрээнд авч үзэх холбогдох дүрэм, журмыг үзүүлэв. Үүнд, Эрсдэлийн Үнэлгээний Заавартай холбоотой нэг (1), Гамшгаас Хамгаалах Төлөвлөгөө Боловсруулах Заавартай холбоотой зургаан (6) журмыг шинээр боловсруулах болон шинэчлэн сайжруулах шаардлагатай гэж дүгнэв.

Хүснэгт II.1.7 Төсөлтэй холбоотой дүрэм, журам

Шинэчлэн баталсан Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан журам	Төслийн хүрээнд шинээр боловсруулах болон шинэчлэн сайжруулах журам
7.4 Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх журам	Гамшгийн эмзэг байдал болон эрсдэлийн үнэлгээ хийх журмыг шинэчилсэн байна. 1) Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний заавар болон 2) Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээний зааврыг шинэчилсэн журмын хавсралтаар батална.
8.3 Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар	Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар нь энэхүү зааврын газар хөдлөлтийн тухай хэсэгтэй дүйцдэг.
10.2 Гамшгийн бэлэн байдлыг хангах үзлэг, шалгалт явуулах журам	Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах зааварт "гамшгийн бэлэн байдлыг хангах" тай холбоотой агуулгыг оруулна.
10.8 Ажлын тусгай горимоор ажиллах журам	
11.1 Өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх албан шийдвэр	
12.2 Гамшгаас хамгаалах хяналтыг хэрэгжүүлэх журам	Энэхүү ажил төслийн хүрээнд тусгагдаагүй болно. Үүнийг ОБЕГ боловсруулна.
15.3 Эрэн хайх, аврах үйл ажиллагааг зохион байгуулах нийтлэг журам	Эдгээр журмуудын газар хөдлөлтийн тухай хэсгүүд нь төслийн хүрээнд боловсруулагдаж буй Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, Улсын албадын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар, Аймаг/сумын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар ба УБ хот/дүүргийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар зэрэгтэй ижил байна.
16.5 Гамшгийн зарлан мэдээлэл, түүнийг дамжуулах журам	
18.2 Шуурхай бүлгийн тухай дүрэм, журам	
19.2 Хүч хэрэгсэл дайчлан гаргах, нүүлгэн шилжүүлэх журам	
20.3 Гамшгийн хохирол, хэрэгцээний үнэлгээ хийх журам	
20.4 Гамшгийн хор уршгийг арилгах үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг хуулийн этгээдэд нөхөн олгох журам	

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Үйл ажиллагаа 1.1.2-т дурдсан Гамшгийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ хийх журам (Засгийн газрын 2006 оны 176-р тогтоолын хавсралт)-ыг ОБЕГ шинэчлэн боловсруулсан бөгөөд Төслийн хүрээнд боловсруулсан газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний заавар нь энэхүү журмын хавсралт болно. Одоогийн байдлаар бусад хавсралтуудыг боловсруулах шатанд явж байна.

Үйл ажиллагаа 1.2.1 ОБЕГ болон гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцогч байгууллагын харилцан ажиллагааг хангах гэрээ, санамж бичгийн төсөл боловсруулах

Хүснэгт II.1.8.-д тухайн салбаруудын санамж бичиг байгуулах ажлын явцыг тоймлон үзүүлэв. Санамж бичгийн төсөл боловсруулах үйл ажиллагааны явцад А/Х 1-ийн гишүүд “Санамж бичиг боловсруулах гарын авлага”-ыг боловсруулав.

Хүснэгт II.1.8 Санамж бичиг байгуулах ажлын явц

Салбар	Агуулга	Байгууллага	Явц
1.Хүнс	Түр хоргодох байр, түр сууцанд байрлах гамшигт нэрвэгдэгсдэд ундны цэвэр ус, хүнсний хангалтыг зохион байгуулах	ОБЕГ-ХХААХҮЯ	Санамж бичгийг 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан.
2.Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	Гамшигт нэрвэгдсэн бүс нутагт эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэхэд шаардлагатай эм бэлдмэлийн хангалт	ЭМЯ-Эм үйлдвэрлэгч, импортлогч 3 том ААН	Санамж бичгийг 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр байгуулсан.
3.Барилгын материал, түр сууц	Барилга байгууламжийг хойшлуулшгүй сэргээн босгоход шаардлагатай барилгын материалын хангалт, түр сууц барьж байгуулах ажил	БХБЯ-БМҮХ, БНХ	Санамж бичгийг 2019 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан.
4.Цэвэр ус	Гамшигт нэрвэгдсэн бүс нутаг дахь цэвэр усны хангалтыг зохион байгуулах	ОБЕГ-УСУГ	Санамж бичгийг 2019 оны 12/30-нд байгуулна.
5.Зам тээвэр	Гамшигт нэрвэгдсэн бүс нутаг дахь аврах, эрэн хайх, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг саадгүй зохион байгуулахад шаардалагтай тээвэр болон замын хөдөлгөөнийг хангах	ОБЕГ-ЗТХЯ	Санамж бичгийг 2019 оны 10 дүгээр сарын 29-ний өдөр байгуулсан.
6.Түлш шатахуун	Гамшигт нэрвэгдсэн бүс нутаг дахь аврах, эрэн хайх, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагааг саадгүй зохион байгуулахад шаардалагтай түлш шатахууны хангалтыг зохион байгуулах	ОБЕГ-АМГТГ	Санамж бичгийн төслийг боловсруулж дууссан.

*Монгол Улсын Газар Хөдлөлтийн Гамшгаас
Хамгаалах Чадавхыг Бэхжүүлэх төсөл
Төслийн Төгсгөлийн Тайлан*

7.Харилцаа холбоо	Гамшгийн үед тэргүүн ээлжинд холбогдох телефон утасны үйлчилгээ, энгийн хэрэглэгчдийн үүрэн телефоны үйлчилгээг хязгаарлах	Үүрэн телефоны оператор, ОБЕГ, Харилцаа холбооны зохицуулах хороо	Санамж бичгийн төслийг боловсруулж дууссан.
8.Түр хоргодох байр	Сургуулийн барилгыг түр хоргодох байр болгож ашиглах (Япон улсын буцалтгүй тусламжаар баригдах сургуулийн байгууламж)	ОБЕГ (НОБГ)-Нийслэлийн боловсролын газар	Санамж бичгийг 2019 оны 10 дугаар сард байгуулсан.
9.Бохир ус	Түр цугларах талбай, түр хоргодох байр болон түр сууц баригдах газар олон нийтийн бие засах түр газар байршуулах, бохирын шугам сүлжээний хойшлуулшгүй сэргээн босголт	НОБГ-Нийслэлийн Хот тохижилтын газар, УСУГ	Санамж бичгийг 2019 оны 10 дугаар сард байгуулсан.

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Үйл ажиллагаа 1.2.2 Үйл ажиллагаа 1.2.1-т заасан санамж бичгүүдийг олон нийтэд мэдээлэх болон гамшгаас хамгаалах байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог бэхжүүлэх сургалт зохион байгуулах

Газар хөдлөлтийн гамшгийн үед авах арга хэмжээнд санамж бичгийн эзлэх байр суурь, ач холбогдлын талаар ойлгуулах, эрүүл мэнд болон бусад салбарт санамж бичиг байгуулах сайн туршлагыг дэмжих зорилгоор 2018 оны 4-р сарын 9-ний өдөр хамтарсан сургалтыг УБ хотод зохион байгуулав. Холбогдох салбарын нийт 38 мэргэжилтэн, алба хаагч энэхүү сургалтанд оролцсон байна.

Япон Улсад хэрэгжүүлж буй санамж бичигтэй холбоотой шилдэг туршлага, Монгол Улсад санамж бичиг байгуулах ажлын үйл явц, ЭМЯ-тай байгуулах санамж бичгийн төсөл зэргийг ОБЕГ болон ЖМБ танилцуулсан байна. Үүний дараа, УБ хотод 8 баллын хүчтэй газар хөдлөлт болсон цагийн байдал үүсгэж, санамж бичгийн төслийн дагуу эмнэлгийн байгууллагын ажилтнууд болон эм бэлдмэлийг гамшгийн дараах 6-72 цагийн хугацаанд хэрхэн тараан байршуулах тухай танхимын дадлага сургуулийг 1/50,000 масштабтай газрын зураг ашиглан хийсэн байна.



Сургалтын үеэр танилцуулга хийж байгаа
байдал



Танхимын дадлага сургууль

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Зураг II.1.1 Газар хөдлөлтийн гамшгийн үед авах арга хэмжээнд санамж бичгийн эзлэх байр суурь, ач холбогдлын талаарх сургалтын байдал

Үйл ажиллагаа 1.3.1 Улс болон орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хяналт, тайлан, үнэлгээ хийх болон нийтлэхтэй холбоотой асуудлыг тодорхойлох

Одоо мөрдөгдөж байгаа Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд гамшгийн төрлөөр нь гамшгийн үеийн хариу арга хэмжээ, шуурхай удирдлагын талаар голлон дурдсан бөгөөд гамшгаас урьдчилан сэргийлэх болон бэлэн байдлын талаар бага дурдсан байдаг. Иймээс, ЖМБ нь Японы гамшгаас хамгаалах үндсэн төлөвлөгөөний “Гамшгийн төрөл тус бүрийн нийтлэг арга хэмжээ”-ний тухай баримт бичгийг А/Х 1-ийн гишүүдэд хүлээлгэн өгсөн.

Нийслэл, аймаг болон сумын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг “Гамшгаас хамгаалах төлөвлөгөөний загварыг ашиглах заавар” (2013 оны ОБЕГ-ын даргын тушаал)-т үндэслэн боловсруулдаг байсан. Үйл ажиллагаа 1.1.2-т дурдсаны дагуу газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах шинэ зааврын төслийг А/Х 1 дээр боловсруулсан бөгөөд орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг энэхүү зааврын дагуу шинэчлэн боловсруулах тухай чиглэлийг тодорхой болгов.

Үйл ажиллагаа 1.3.2 1.3.1-д дурдсан төлөвлөгөөг шинэчлэн сайжруулах, гарын авлага боловсруулах

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах/шинээр боловсруулах туршилтын үйл ажиллагааг туршилтын орон нутаг болох Дархан-Уул, Өмнөговь аймгууд болон УБ хотын Баянгол, Чингэлтэй дүүргүүдэд хэрэгжүүлсэн. А/Х 1 энэхүү үйл ажиллагааны хүрээнд

хэд хэдэн сургалт-воркшоп зохион байгуулсан байна. Тус сургалтад хамрагдсан мэргэжилтнүүдийг Харилцаа холбоо, Хот байгуулалт, Эрүүл мэнд ба хүрээлэн буй орчин, Гамшгаас хамгаалах арга хэмжээ ба боловсрол гэсэн 4 бүлэгт хувааж сургалтыг зохион байгуулав. Бүлэг тус бүр дээр газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ, тэдгээр арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага, хугацаа болон шаардлагатай төсөв хөрөнгийн талаар ярилцсан байна. Эдгээрийн үр дүнг “гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүснэгт”-д нэгтгэсэн болно. Хүснэгтэд оруулсан агуулга нь газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг бүрдүүлэх юм. Сургалтын үйл ажиллагааны тоймыг Хүснэгт II.1.9-т үзүүлэв.

Хүснэгт II.1.9 Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах туршилтын үйл ажиллагаа

Туршилтын орон нутаг	Сургалтын нэр	Огноо	Оролцогчдын тоо	Сургалтын агуулга
Дархан-Уул аймаг	Сургалт 1	2018 оны 5-р сарын 24, 25	19	<ul style="list-style-type: none"> • Зааврын танилцуулга • Үндсэн мэдээллийг нягтлах • Газар хөдлөлтийн эрсдэлийн хялбаршуулсан үнэлгээ
	Сургалт 2	2018 оны 9-р сарын 18, 19	12	<ul style="list-style-type: none"> • Салбар тус бүрээр нь бүлэгт хуваах • Ажлын төлөвлөгөө гаргах • Гамшгийн цагийн байдал гаргах • Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилт дэвшүүлэх
	Сургалт 3	2018 оны 11-р сарын 15, 16	18	<ul style="list-style-type: none"> • Гамшгийн цагийн байдалд үндэслэн гамшгийн эрсдэлийг бууруулах 10 жилийн хугацаанд биелүүлэх зорилт тавих • Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилтод хүрэхэд тулгарч буй асуудлыг тодорхой болгох • Тулгарч буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг төлөвлөх
	Сургалт 4	2019 оны 1-р сарын 28	19	<ul style="list-style-type: none"> • Тулгарч буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг төлөвлөх (үргэлжлэл) • Арга хэмжээ хэрэгжүүлэх гол байгууллагуудыг тодорхой болгох • Арга хэмжээ хэрэгжүүлэх хугацааг тодорхойлох
	Сургалт 5	2019 оны 4-р сарын 19	13	<ul style="list-style-type: none"> • Хэрэгжүүлэх арга хэмжээг эрэмбэлэх • Арга хэмжээ хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг тодорхойлох
	Сургалт 6	2019 оны 7-р сарын 1	10	<ul style="list-style-type: none"> • Салбар тус бүрээр хэрэгжүүлэх гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний үндсэн чиглэлийг тодорхойлох • Шаардлагатай төсөв хөрөнгийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох

*Монгол Улсын Газар Хөдлөлтийн Гамшгаас
Хамгаалах Чадавхыг Бэхжүүлэх төсөл
Төслийн Төгсгөлийн Тайлан*

				<ul style="list-style-type: none"> • Төлөвлөгөөний хэрэгжилтийг хэрхэн хянах талаар ярилцаж тодорхой болгох
	Сургалт 7	2019 оны 8-р сарын 5	10	<ul style="list-style-type: none"> • Төлөвлөгөөг эцэслэх
Өмнөговь аймаг	Сургалт 1	2018 оны 5-р сарын 16, 17	17	<ul style="list-style-type: none"> • Зааврын танилцуулга • Үндсэн мэдээллийг нягтлах • Газар хөдлөлтийн эрсдэлийн хялбаршуулсан үнэлгээ
	Сургалт 2	2018 оны 9-р сарын 28	13	<ul style="list-style-type: none"> • Салбар тус бүрээр нь бүлэгт хуваах • Ажлын төлөвлөгөө гаргах • Гамшгийн цагийн байдал гаргах • Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилт дэвшүүлэх
	Сургалт 3	2018 оны 11-р сарын 28, 29	25	<ul style="list-style-type: none"> • Гамшгийн цагийн байдалд үндэслэн гамшгийн эрсдэлийг бууруулах 10 жилийн хугацаанд биелүүлэх зорилт тавих • Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилтод хүрэхэд тулгарч буй асуудлыг тодорхой болгох • Тулгарч буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг төлөвлөх
	Сургалт 4	2019 оны 2-р сарын 18	23	<ul style="list-style-type: none"> • Тулгарч буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг төлөвлөх (үргэлжлэл) • Арга хэмжээ хэрэгжүүлэх гол байгууллагуудыг тодорхой болгох • Арга хэмжээ хэрэгжүүлэх хугацааг тодорхойлох
	Сургалт 5	2019 оны 5-р сарын 30	20	<ul style="list-style-type: none"> • Хэрэгжүүлэх арга хэмжээг эрэмбэлэх • Арга хэмжээ хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг тодорхойлох
	Сургалт 6	2019 оны 8-р сарын 12	10	<ul style="list-style-type: none"> • Салбар тус бүрээр хэрэгжүүлэх гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний үндсэн чиглэлийг тодорхойлох • Шаардлагатай төсөв хөрөнгийг шийдвэрлэх арга замыг тодорхойлох • Төлөвлөгөөний хэрэгжилтийг хэрхэн хянах талаар ярилцаж тодорхой болгох
	Сургалт 7	2019 оны 8-р сарын 12		<ul style="list-style-type: none"> • Төлөвлөгөөг эцэслэх
Баянгол дүүрэг	Хамтарсан Сургалт 1	2018 оны 8-р сарын 28, 29	8	<ul style="list-style-type: none"> • Зааврын танилцуулга • Үндсэн мэдээллийг нягтлах • Гамшгийн цагийн байдал гаргах • Нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох
Чингэлтэй дүүрэг			8	
Баянгол дүүрэг	Хамтарсан Сургалт 2	2019 оны 1-р сарын 31	8	<ul style="list-style-type: none"> • Гамшгийн цагийн байдалд үндэслэн гамшгийн эрсдэлийг бууруулах 10 жилийн хугацаанд биелүүлэх зорилт тавих • Гамшгийн эрсдэлийг бууруулах
Чингэлтэй дүүрэг			8	

*Монгол Улсын Газар Хөдлөлтийн Гамшгаас
Хамгаалах Чадавхыг Бэхжүүлэх төсөл
Төслийн Төгсгөлийн Тайлан*

				зорилтод хүрэхэд тулгарч буй асуудлыг тодорхой болгох • Тулгарч буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг төлөвлөх
Баянгол дүүрэг	Хамтарсан Сургалт 3	2019 оны 5-р сарын 9	2	• Тулгарч буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг төлөвлөх (үргэлжлэл) • Арга хэмжээ хэрэгжүүлэх гол байгууллагуудыг тодорхой болгох • Арга хэмжээ хэрэгжүүлэх хугацааг тодорхойлох
Чингэлтэй дүүрэг			7	
Баянгол дүүрэг	Сургалт 4	2019 оны 8-р сарын 30	15	• Арга хэмжээ хэрэгжүүлэх гол байгууллагуудыг тодорхой болгох • Арга хэмжээ хэрэгжүүлэх хугацааг тодорхойлох
Чингэлтэй дүүрэг	Сургалт 4	2019 оны 9-р сарын 13	10	• Хэрэгжүүлэх арга хэмжээг эрэмбэлэх • Арга хэмжээ хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг тодорхойлох

Source: JICA Expert Team



4 бүлэг болж ажиллаж байгаа нь



Хүрсэн үр дүнг танилцуулж байгаа нь

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Зураг II.1.2 Туршилтын аймаг болох Өмнөговь аймгийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах сургалт

A/X 1 нь эдгээр үйл ажиллагааны явцад “Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах гарын авлага”-ыг боловсруулав.

Үйл ажиллагаа 1.3.3 Гамшгаас хамгаалах мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх одоогийн системийг шинэчлэн сайжруулах

Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын 14 дүгээр зүйлд заасан “Гамшгийн мэдээллийн сан бүрдүүлэх”-н дагуу ОБЕГ нь гамшгийн мэдээллийн санг шинэчлэн сайжруулах үүрэгтэй билээ. ОБЕГ-ын дээр дурьдсан хуулийн дагуу гүйцэтгэх чиг үүрэг болон "Гамшгийн эрсдэлийг

бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ"-ний тэргүүлэх чиглэлүүдийг Монгол улсад хэрэгжүүлэхэд оруулах хувь нэмэр зэрэг үйл ажиллагааны хүрээнд дэд А/Х 1-5 дээр өнөөгийн тогтолцоог шинэчлэн сайжруулах бодлогын талаар авч үзэж санал солилцсон. Үүний үр дүнд гамшгийн мэдээллийн санг шинэчилж, мэдээлэл солилцооны шинэ системийг ОБЕГ-д суурилуулах үйл ажиллагааны ерөнхий тогтолцоог ОБЕГ-ын төв, орон нутгийн газар хэлтсүүд болон Монгол улс дахь холбогдох байгууллагууд хоорондын боломжит харилцаан дээр үндэслэн тодорхойлсон. Улмаар, дэд А/Х 1-5-ын гишүүд ОБЕГ-ын гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд амин чухал дэмжлэг үзүүлэх систем болох газар зүйн мэдээллийн систем (GIS)-д суурилсан орон зайн гамшгийн мэдээллийн санг шинээр боловсруулах зорилт тавьжээ.

1) Гамшгаас хамгаалах орон зайн мэдээллийн сангийн мэдээлэл удирдлагын шинэ тогтолцоог бий болгох

Дэд А/Х 1-5 нь Японы Гамшгаас хамгаалах шинжлэх ухаан, технологийн хүрээлэн (цаашид "ГХШУТХ" гэх)-ийн боловсруулсан вэб-д суурилсан газар зүйн мэдээллийн систем (GIS)-ийн нээлттэй программ хангамж болох "E-Comi map"-ыг гамшгийн мэдээллийн сангийн шинэ систем болгож суурилуулахаар шийдсэн байна. Улмаар, системийг Монголын үндэсний дата төвд (цаашид "МҮДТ" гэх) суурилуулах ажлыг эхлүүлэхэд системийн аюулгүй байдал болон ОБЕГ-ын зүгээс үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангахад анхаарсан байна. Системийг МҮДТ-ийн серверт суурилуулах ажлыг 2017 оны 6-р сарын 1-нд дуусгасан. Үүний дараа, ГОЗМТХ-ийн шинээр боловсруулсан журам, ажлын горимын дагуу системийн ажиллагааг сайжруулан шинээр өөрчлөлт оруулж, системийн хэрэглээг сайжруулах ажлыг үргэлжлүүлсэн байна. Одоогийн байдлар, бүхий л хэрэглэгчид (<http://map.nema.gov.mn/>) холбоосоор системтэй холбогдож, мэдээллийн сан дахь мэдээллийг шалгах боломжтой.

2) Гамшгийн орон зайн мэдээллийн сангийн удирдлага, ашиглалтын зааврыг боловсруулах

ОБЕГ гамшгийн орон зайн мэдээллийн санг ашиглахад хамгийн тохиромжтой дүрэм, журмын талаар дэд А/Х-ийн гишүүд заавар боловсруулах ажлын хүрээнд орон нутгийн онцгой байдлын байгууллагын мэргэжилтнүүдийн саналыг авч хэлэлцэв. Дэд А/Х-ийн гишүүд нь 2017 оны 11-р сараас эхлэн зааврын төслийг боловсруулж эхэлсэн бөгөөд мэдээллийн менежментийн шинэ системийг нэвтрүүлсэн Гамшгийн орон зайн мэдээллийн санг удирдаж

ажиллуулах шинээр байгуулагдах удирдлагын багийн чиг үүргийг харгалзан үзэж тус зааварт тусгаж ирсэн. 2018 оны 5-р сарын эцэст мэдээллийн санг удирдах чиг үүрэг бүхий Гамшгийн орон зайн мэдээлэл, технологийн хэлтсийг (“ГОЗМТХ”) шинээр байгуулсан байна. Үүний дараа дэд А/Х-ийн гишүүд болон шинээр байгуулагдсан ГОЗМТХ-ийн гишүүд заавар боловсруулах ажлыг эрчимжүүлсэн бөгөөд зааврын төслийг 2018 оны 10-р сарын сүүлээр боловсруулж дууссан. ОБЕГ-ын Даргын зөвлөлөөс ирүүлсэн саналын дагуу зааварт нэмэлт өөрчлөлт оруулсны дараа зааврыг 2019 оны 2-р сарын 20-ны өдөр ОБЕГ-ын даргын А/47 дугаар тушаалаар баталсан.

3) Холбогдох байгууллагуудтай орон зайн мэдээлэл хамтран ашиглах гэрээ байгуулах

Дэд А/Х-ийн гишүүд Монгол Улсад хэрэгжүүлж байгаа гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хамтран ашиглах орчинг боловсронгуй болгох үүднээс ОБЕГ болон холбогдох байгууллагуудын хооронд орон зайн мэдээлэл хамтран ашиглах гэрээ байгуулах үйл ажиллагаанд анхаарал хандуулж ажилласан.

ОБЕГ болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (цаашид “ГЗБГЗЗГ” гэх)-ын хооронд орон зайн мэдээлэл хамтран ашиглах анхны албан ёсны гэрээг 2018 оны 4-р сард (өмнөх тайлант хугацаанд) байгуулав.

Мөн, ОБЕГ болон Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар (НХТЕТГ)-ын хооронд техникийн болон удирдлага, зохион байгуулалтын асуудлаар хэлэлцэж санал солилцсоны үндсэн дээр 2019 оны 5-р сарын 5-ны өдөр албан ёсоор гэрээ байгуулав.

4) ОБЕГ-т гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хүрээнд орон зайн мэдээллийн санг ашиглах сургалт зохион байгуулах

Орон зайн мэдээллийн санг удирдаж ажиллуулах шинэ бүтэц зохион байгуулалтыг бий болгох үүднээс ОБЕГ, НОБГ болон 21 аймгийн онцгой байдлын газар, хэлтсийн хүний нөөцийн чадавхыг үнэлэх болон бэхжүүлэх нь чухал арга хэмжээний нэг юм. Иймээс, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд орон зайн мэдээллийн санг ашиглах талаар ОБЕГ-ын төв, орон нутгийн газар хэлтсүүдийн нийт 150 гаруй албан хаагчдад 3 удаагийн сургалтыг зохион байгууллаа. Мөн гамшгийн орон зайн мэдээллийн системийн ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх зорилгоор шинэ албан хаагчдад зориулж системтэй ажиллах видео хичээлийг бэлтгэж интернэтэд байрлуулсан.

Тухайлбал, 2018 оны 3-р сарын 12, 13-нд зохион байгуулсан сургалтанд ОБЕГ болон орон нутгийн газар, хэлтсээс 50 мэргэжилтэн оролцсон байна. Энэхүү сургалтын гол зорилго нь гамшгийн орон зайн мэдээллийн системийг ашиглан орон зайн мэдээллийн сангийн талаар анхан шатны ойлголт олгох бөгөөд ОБЕГ-ын гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хүрээнд орон зайн мэдээллийн санг хэрхэн илүү үр дүнтэй ашиглах талаар санал солилцов. Сургалтын дадлага ажилд илүү хугацаа шаардлагатай байсан гэх олон тооны санал ирсэн байна. Оролцогчид багаар хамтран ажилласнаар практикт суурилсан мэдлэг авахад илүү дөхөм гэж үзсэн байна. Ихэнх оролцогчид газар зүйн болон мэдээллийн системийн талаар анхан шатны мэдлэгтэй байсан учир тэдэнд системийг ашиглах чадварыг эзэмшихэд бэрхшээл байгаагүй.



Source: JICA Expert Team

Зураг II.1.3 Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд орон зайн мэдээллийн санг ашиглах 2 өдрийн сургалтын дадлага ажил

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд орон зайн мэдээллийн санг ашиглах 2-р сургалтыг дэд А/Х-ийн гишүүд 2018 оны 10-р сарын 24, 25-ны өдрүүдэд зохион байгуулж, энэхүү сургалтанд орон нутгийн онцгой байдлын газар хэлтсүүдийн 30 ажилтныг оролцуулсан байна. Тус сургалтын гол зорилго нь оролцогчдод системийн талаар ахисан түвшний мэдлэгийг олгож, системийг өөрсдөө бие даан ашиглах чадвартай болгоход чиглэсэн.



Source: JICA Expert Team

Зураг II.1.4 2019 оны 10-р сарын 24, 25-нд зохион байгуулсан Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд орон зайн мэдээллийн санг ашиглах ахисан түвшний сургалт

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд орон зайн мэдээллийн санг ашиглах 3-р сургалтыг дэд А/Х-ийн гишүүд болон шинээр байгуулагдсан хэлтсийн ажилтнууд 2019 оны 4-р сарын 30-ны өдөр ОБЕГ-ын төв байранд НОБГ, 21 аймгийн онцгой байдлын газар болон Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвийн нийт 42 ажилтанд зориулан зохион байгуулжээ. Тус сургалтын гол зорилго нь орон зайн мэдээллийн санд төрөл бүрийн аюул, ослын тухай мэдээллийг хэрхэн бүртгэх талаар мэдлэг олгоход чиглэсэн бөгөөд сургалтын үеэр оролцогчид голдуу компьютер дээр дадлага ажил хийсэн.

ОБЕГ-ын даргын А/47 дугаар тушаалын үндсэн дээр Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд орон зайн мэдээллийн сангийн мэдлэг, ойлголтыг гүнзгийрүүлэх сургалтуудыг ОБЕГ-ын нэгж газрууд тус бүрт зориулж 2019 оны 5-р сарын 17-ны өдрөөс 31-ний өдөр хүртэл зохион байгуулжээ. Албан тушаалтнуудад тасралтгүй өөрсдийгөө сурган дадлагажуулах боломжийг хангах ба орон зайн мэдээллийн сангийн ашиглалтыг сайтар эзэмшсэн албан тушаалтан өөр газар томилогдох гэх зэрэг шилжилт хөдөлгөөн үүсэх байдлыг харгалзаж 2019 оны 6-р сарын 1-ний өдөр дэд А/Х-ийн гишүүд орон зайн мэдээллийн сангийн ашиглалтын талаарх сургалтын материалыг видео бичлэг хэлбэрээр бэлтгэхээр шийдсэн. Сургалтын материалыг дэд А/Х-ийн гишүүдийн хамт 2019 оны 7-р сарын турш бэлтгэж, нийт 13 төрлийн сургалтын материалыг бэлэн болгов (сургалтын материал бүр 10-15 минут үргэлжлэх бөгөөд ерөнхий хэрэглэгчдэд зориулсан 8 материал болон системийн администраторд зориулсан 5 материал боловсруулжээ). Эдгээр сургалтын материалуудыг

системийн администраторын үүргийнхээ хүрээнд ГОЗМТХ хариуцахаар шийдсэн байна.

Үйл ажиллагаа 1.3.4 Үйл ажиллагаа 1.3.1 болон 1.3.2-т заасан улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт, хяналт, үнэлгээ зэрэг үйл ажиллагааны талаар Монгол улсын иргэдэд мэдээлэх зорилго бүхий гамшгаас хамгаалах цагаан номыг боловсруулах

“Монгол Улсын Гамшгаас хамгаалах Цагаан ном 2017”-г 2018 оны 12-р сард хэвлэн нийтлэв. Гамшгаас хамгаалах Цагаан номын агуулгыг Хүснэгт II.1.10.-т үзүүлэв.

Хүснэгт II.1.10 Цагаан номын агуулга

<p>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН, ШИНЭЧЛЭЛ</p> <p>1.1. Монгол Улсын гамшгаас хамгаалах тухай хууль, тогтоомж</p> <p>1.2. Гамшгаас хамгаалах бодлогын баримт бичиг</p> <p>1.3. Гамшгаас хамгаалах тогтолцоо, бүтэц, зохион байгуулалт</p>	<p>ТАВДУГААР БҮЛЭГ. УЛСЫН НӨӨЦ, ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖ</p> <p>5.1. Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн талаарх баримт бичиг</p> <p>5.2. Улсын нөөц, хүмүүнлэгийн тусламжийн үйл ажиллагаа</p>
<p>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГАМШГААС ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</p> <p>2.1. Монгол Улсад 2017 онд тохиолдсон аюулт үзэгдэл, гамшиг осол, хэрэгжүүлсэн арга хэмжээ</p> <p>2.2. Гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа</p> <p>2.3. Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа</p> <p>2.4. Гамшгийн бэлэн байдлыг хангах арга хэмжээ</p> <p>2.5. Гамшгийн үеийн зарлан мэдээлэл, шуурхай удирдлага зохицуулалт</p> <p>2.6. Гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл</p> <p>2.7. Гамшгаас хамгаалах дадлага, сургууль</p>	<p>ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН АЮУЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА</p> <p>6.1. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөл</p> <p>6.2. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай баримт бичиг</p> <p>6.3. Улаанбаатар хотын ойр орчим дахь хагарлын судалгаа</p> <p>6.4. Улаанбаатар хотын газар хөдлөлтийн шуурхай арга хэмжээний төлөвлөгөө</p>
<p>ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГАМШГААС ХАМГААЛАХ ОЛОН ТАЛТ ХАМТЫН АЖИЛЛАГАА</p> <p>3.1. Гамшгаас хамгаалах олон улсын хамтын ажиллагаа</p> <p>3.2. Гамшгаас хамгаалах албадын харилцан ажиллагаа</p> <p>3.3. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд иргэний нийгэм, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоо</p>	<p>ДОЛООДУГААР БҮЛЭГ. ГАМШИГ СУДЛАЛ, ГАМШГААС ХАМГААЛАХ СУДАЛГААНЫ АЖИЛ</p> <p>7.1. Гамшиг судлалын хүрээлэнгийн судалгаа шинжилгээний ажлууд</p> <p>7.2. Гамшгийн мэдээллийн сан</p>
<p>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ГАЛЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ</p>	<p>НАЙМДУГААР БҮЛЭГ. ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨСӨВ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</p> <p>8.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт</p> <p>8.2. Гадаадын хөрөнгө оруулалт</p> <p>8.3. Онцгой байдлын ерөнхий газарт хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр</p> <p>8.4. Гамшигт нэрвэгдэгсдэд олгох нөхөн олговор</p>

4.1. Галын аюулгүй байдлын талаарх баримт бичиг	ХАВСРАЛТ
4.2. Гал түймэртэй тэмцэх үйл ажиллагаа	1. Гамшгаас хамгаалах эрх зүйн баримт бичгийн жагсаалт

Мөн, А/Х 1-ийн гишүүд “Цагаан ном боловсруулах гарын авлага”-ыг боловсруулав. Энэхүү гарын авлагад 2017 оны Цагаан номыг боловсруулах ажлын явцыг судалж үзсэний дараа доорх зүйлсийг тайлбарлан тусгажээ. Үүнд:

- Цагаан ном боловсруулах ажлын хэсэг байгуулах
- Цагаан номын бүтэц болон агуулгыг хэлэлцэх
- Мэдээллийн эх үүсвэрийг тодорхойлох
- Материал цуглуулах
- Цуглуулсан материалыг цэгцлэх
- Цагаан номын төслийг бэлтгэх
- Цагаан номын төслийг хянан засах
- Англи хэл рүү орчуулах ажлын зохион байгуулалт
- Хэвлэлийн компаниар хянуулах ажлын зохион байгуулалт, гэх мэт.

Уг гарын авлагад тулгуурлан Гамшгаас хамгаалах Цагаан ном 2018-ыг боловсруулах ажлын хэсэг байгуулагдаж, 2019 оны 11-р сард боловсруулахаар төлөвлөж байна.

Үйл ажиллагаа 1.3.5 Барилга, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн мэдээллийн сангийн системийг сайжруулах

Үйл ажиллагаа 1.3.3-т тайлбарласны дагуу, гамшгаас хамгаалах орон зайн мэдээллийн санг шинэчилж байгаа бөгөөд орон зайн мэдээллийн сан нь барилга, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний үр дүнг хуримтлуулж, холбогдох байгууллагууд үнэлгээ дүгнэлт хийх боломжтой байхаар зохион байгуулж байна.

НХТЕТГ-тай мэдээлэл солилцох гэрээ байгуулсны үр дүнд Нийслэлийн гүйцэтгэсэн барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний мэдээллийг ОБЕГ-тай хуваалцаж хамтран ашиглах боломж бүрдсэн.

Улмаар, А/Х 1-ийн гишүүд ЖАЙКА-гийн өмнөх төсөл буюу “Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн удирдлагын чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд тооцоолсон барилга, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээнүүдийн үр дүнг орон зайн

мэдээллийн санд байршуулах ажлын бэлтгэлийг хангаж байна. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд ашиглах орон зайн мэдээллийн сангийн агуулга нь нэмэгдсээр байгаа бөгөөд энэ нь гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх систем болох талаараа ач холбогдолтой юм.

(2) Үр дүн 2

Үйл ажиллагаа 2.1.1 Гамшгаас хамгаалах тухай хуулийн хүрээнд, барилга, бэд бүтэц, инженерийн шугам сүлжээнд газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ хийх журам, зааварт дүн шинжилгээ хийж шинэчилсэн заавар боловсруулах

А/Х 2-ын гишүүд нь одоо мөрдөгдөж байгаа барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний норм, нормативд тулгарч буй асуудал, авах арга хэмжээг судалсан бөгөөд барилгын үнэлгээний нормууд нь голчлон насжилт элэгдлийг үнэлэхэд чиглэгдсэн байв. Тиймээс энэхүү судалгаагаар тодруулсан асуудал, авах арга хэмжээг төслийн хүрээнд шинээр боловсруулсан “Барилгын дүрэм”-үүдэд тусгасан.


Мөн А/Х 2-ын гишүүд нь дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлалын тухай холбогдох байгууллагуудын мэргэжилтнүүдээс тодруулсан. Холбогдох мэргэжилтнүүдийн хэлсэнээр одоо ашиглагдаж байгаа инженерийн шугам сүлжээнүүдийн дийлэнх нь насжилт өндөртэй, элэгдэл ихтэй тул яаралтай шинэчлэх шаардлагатай бөгөөд газар хөдлөлтийн хохирлыг бууруулахад шинээр суурилуулах нь үр дүнтэй гэж үзсэн. Тиймээс АХ-2-ын зүгээс ИШС-ний газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээнд одоо ашиглагдаж буй хяналтын хуудсуудыг боловсронгуй болгоход анхаарч ажиллахаар шийдвэрлэсэн.

Үйл ажиллагаа 2.1.2 Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлал, Үнэлгээнд хэрэглэгдэх хэмжилтийн багаж төхөөрөмжийг ашиглах заавар боловсруулах

АХ-2-ын зүгээс Монгол Улсад мөрдөгдөж буй Барилгын норм, дүрэм боловсруулах дараах дарааллын дагуу үнэлгээний аргачлалуудыг боловсруулахаар шийдвэрлэсэн.

Барилгын хөгжлийн төв (БХТ)-өөс гол үүрэгтэй оролцсон техникийн даалгавар (ТД) боловсруулах, зөвлөх үйлчилгээний баг (ЗҮБ)-ийг сонгон шалгаруулах, барилгын дүрмүүдийн төслийг эцэслэх зэрэг ажлын дарааллыг Зураг II.1.5-д

үзүүлэв.



БХБЯ: Барилга хот байгуулалтын яам, БХТ: Барилгын хөгжлийн төв
ЗҮБ: Зөвлөх үйлчилгээний баг, БД: Барилгын дүрэм,
ТНБД: Төрийн нарийн бичгийн дарга

Зураг II.1.5 Барилгын дүрэм боловсруулах дараалал

2018 оны 11-р сарын 06-ны өдрийн БХБС-ын 185-р тушаалаар Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлалыг, 2018 оны 12-р сарын 28-ны өдрийн БХБС болон ЗТХС-ын 174/303-р хамтарсан тушаалаар Дэд бүтэц ИШС-ний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлалыг тус тус баталсан. (Зураг I.6.1.)

Дараах 4-н барилгын дүрэм батлагдсан гарсан.

“Цутгамал төмөр бетон бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал”

“Том хавтгаалжин угсармал бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал”

“Өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийг үнэлэх болон хүчитгэх аргачлал”

“Авто зам, гүүр, инженерийн хангамжийн сүлжээнд газар хөдлөлтийн эрсдэлийг үнэлэх аргачлал”

Үйл ажиллагаа 2.1.3: Барилга, байгууламж болон шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээг хийх мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах

1) Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлалын тухай сургалт
АХ-2 нь 2018 оны 6-р сарын 04-06-ны өдрүүдэд барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлалын тухай 3-н өдрийн сургалтыг БХТ-ийн сургалтын танхимд зохион байгуулсан бөгөөд сургалтад 110-н мэргэжилтэн, инженерүүд хамрагдсан. Мөн 6-р сарын 07-ны өдөр дэд бүтэц, ИШС-ний газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний тухай сургалтыг зохион байгуулж 70 гаран инженер, мэргэжилтэн хамрагдан анх төлөвлөснөөс олон хүн сургалтуудад хамрагдсан нь газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний дээрх аргачлалуудад холбогдох байгууллагуудын мэргэжилтнүүд өндөр ач холбогдол өгсөний илрэл байв.

Сургалтын дараах анкетаар сургалтад хамрагдагсдын дийлэнх нь сургалтын ач холбогдолыг өндрөөр үнэлж цаашид тогтмол зохион байгуулагддаг байхыг хүссэн байв.



Барилгын үнэлгээний сургалтын дасгал ажил



ИШС-ний сургалтын лекц

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Зураг II.1.6 Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлалын тухай сургалт

2) Хэмжилтийн багаж, төхөөрөмж ашиглах тухай сургалт

Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн биет судалгаанд ашиглагдах үл эвдэх аргын багажийг хүлээлгэж өгсөнтэй уялдуулан холбогдох сургалтыг 2018 оны 11-р сарын 12-13-ны өдрүүдэд БХТ-ийн лекцийн танхимд зохион байгуулсан. Сургалтад төрийн болон хувийн хэвшлээс 64 инженер, мэргэжилтэн хамрагдсан бөгөөд багажийг бодитоор ашиглаж үзсэн практик сургалт болсоноор ач холбогдолтой байв.



Бетоны шахалтын бат бэхийг хэмжигч



Арматурын байршил, диаметрийг тодорхойлогч

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Зураг II.1.7 Хэмжилтийн багаж, төхөөрөмж ашиглах тухай сургалт

3) Сургагч багш бэлдэх сургалт

Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлал, технологийг нэвтрүүлэх, түгээх, дамжуулах зорилгоор сургагч багшид зориулсан сургалтыг АХ-2-н гишүүдийн харьяалагдах байгууллагын мэргэжилтнүүдэд 2019 оны 5-р сараас 10-р сарын хооронд зохион байгуулав. Энэхүү сургалт нь байгууллага тус бүрээс цөөн тооны мэргэжилтнүүдэд илүү дэлгэрэнгүй тайлбарлах хэлбэрээр зохион байгуулагдсан болно.



ОБЕГ



МХЕГ (Барилгын байцаагчид)



МХЕГ (ИШС-ний байцаагчид)



БХБЯ болон БХТ



Нийслэлийн ХБХГ



Сургалтад ашигласан БД-үүд

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Зураг II.1.8 Холбогдох байгууллагуудын сургагч багш бэлдэх сургалт

Мөн “Монголын Барилгын инженерүүдийн холбоо” ТББ-тай хамтран хэд хэдэн удаагийн сургалтыг амжилттай зохион байгуулсан. Тус сургалт нь цаашид барилгын салбарын ажилтны давтан сургах, мэргэшлийн зэрэг олгох сургалтуудын нэг болон кредит олгож тогтмол зохион байгуулагдахаар болсон.



Өрөгт барилгын үнэлгээний
тухай лекц



Цутгамал төмөр бетон барилгын
үнэлгээний тухай



Дасгал ажил

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Зураг II.1.9 МБИХ-ны газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээний сургалт

Үйл ажиллагаа 2.2.1 Барилга байгууламжийг хүчитгэх, шинэчлэн барих тухай заавар аргачлал боловсруулах

АХ-2-ын зүгээс үнэлгээний болон хүчитгэлийн аргачлал нь хамтдаа байх нь зөв гэж үзсэн бөгөөд Дэд бүтэц ИШС-ний БД-ээс бусад БД-үүд нь үнэлэх


болон хүчитгэх аргачлал нэрээр гарсан. Тиймээс дээр дурдсан БХБС-ын 2018 оны 11-р сарын 06-ны өдрийн 185-р тушаалаар үнэлгээний аргачлалтай хамт батлагдсан.

Үйл ажиллагаа 2.2.2: Орон сууц, цэцэрлэг, сургууль, эмнэлэг, төрийн захиргааны барилгыг хүчитгэх, жишээ зураг төсөл боловсруулах

А/Х 2 нь хүчитгэлийн зураг төсөл боловсруулах барилгуудыг сонгох талаар хэлэлцэж, Хүснэгт II.1.11.-ын дагуу өөр өөр хийц бүтээц, зориулалттай таван барилгыг сонгосон. Эдгээр барилгуудын байршил болон гадаад байдлыг Хүснэгт II.1.11 болон Зураг II.1.10.-т үзүүлэв.

Хүснэгт II.1.11 Хүчитгэлийн жишээ зураг төсөл боловсруулахаар сонгогдсон барилгууд

Бүтээц	Зориулалт	Нэр	Байршил	Тайлбар
Тоосгон өрөгт бүтээц	Цэцэрлэг	105-р цэцэрлэг	Сонгинохайрхан дүүрэг	Нэг маягийн зургаар Улаанбаатар хотод хамгийн олон баригдсан цэцэрлэгийн барилга
	Сургууль	97-р сургууль	Баянзүрх дүүрэг	Нэг маягийн зургаар Улаанбаатар хотод хамгийн олон баригдсан сургуулийн барилга
	Төрийн байгууллага	ОБЕГ-ын төв байр	Сүхбаатар дүүрэг	Гамшгийн үед шуурхай арга хэмжээ авах үүрэг бүхий төрийн байгууллагын барилга
Цутгамал төмөр бетон бүтээц	Эмнэлэг	1-р төрөх эмнэлгийн өргөтгөл	Сүхбаатар дүүрэг	Цутгамал төмөр бетон бүтээцтэй барилга бүхий цөөн тооны Улсын эмнэлгийн нэг
Угсармал хавтгаалжин бүтээц	Орон сууц	9 давхар барилга	Баянгол дүүрэг	Нэг маягийн зургаар Улаанбаатар хотод хамгийн олон баригдсан угсармал хавтгаалжин орон сууцны барилга




Эх сурвалж: ООГФХ ба ЖАЙКА Мэргэжилтний Баг

Зураг II.1.10 Хүчитгэлийн зураг төсөл боловсруулахаар сонгогдсон барилгуудын байршил болон гадаад байдал

Хүчитгэлийн зураг төслийг боловсруулахад шаардлагатай тухайн барилгуудын зураг төсөл, бүтээцийн тооцоо зэрэг шаардлагатай мэдээллүүдийг АХ-2-ын гишүүд цуглуулсан.

Мэдээллүүдийг цуглуулсаны дараа шинээр боловсруулсан БД-үүд дэх аргачлалын дагуу нарийвчилсан үнэлгээг хийж шаардлагатай хүчитгэлийн хэмжээг тооцож хүчитгэлийн зураг төслийг боловсруулав. Хүчитгэлийн жишээ зураг төслийг зураг Зураг II.1.11-т үзүүлэв.



Source: JICA Expert Team

Зураг II.1.11 Цутгамал төмөр бетон барилгыг нэмэлт ханаар хүчитгэсэн жишээ

Үйл ажиллагаа 2.2.3: Барилгын хүчитгэл хийх ажилтнуудын мэдлэг чадвахийг дээшлүүлэх сургалт явуулах

АХ-2-с 2018 оны 05-р сарын 01-03-ны хооронд Барилгын хүчитгэлийн аргачлалын тухай 3-н өдрийн сургалтыг Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв болон Барилгын хөгжлийн төв дээр зохион байгуулсан бөгөөд төрийн байгууллагын мэргэжилтэнүүд болон хувийн хэвшлийн ААН-үүдээс нийт 65 хүн хамрагдав.

Сургалтын дараах анкетаар тус сургалт нь инженерүүдийн ажилтай шууд холбоотой бөгөөд цаашид Улаанбаатар хотоос гадна орон нутагт зохион байгуулах шаардлагатай байгааг онцолсон байв.

Барилгын хүчитгэлийн аргачлалын тухай сургагч багшийн сургалтыг АХ-2-н гишүүдийн харьяалагдах байгууллагууд болон хувийн хэвшлийн ААН-үүдэд зохион байгуулсан.



Хүчитгэлийн тооцооны тухай лекц



Хүчитгэлийн ажлуудын танилцуулга

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Зураг II.1.12 Барилгын хүчитгэлийн сургалт

(3) Үр дүн 3

Үр дүн 3 нь Сургуулийн гамшгаас хамгаалах боловсрол (Үйл ажиллагаа 3.1.1-3.1.4) ба Орон нутгийн гамшгаас хамгаалах боловсрол (Үйл ажиллагаа 3.2.1 – 3.2.3) гэсэн хоёр үндсэн бүрэлдэхүүнтэй.

Үйл ажиллагаа 3.1.1 Гамшгаас хамгаалах тухай хуультай уялдсан цэцэрлэг, сургуулийн гамшгаас хамгаалах боловсролын агуулга, арга зүй, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон удирдамж боловсруулах

1) Сургуулийн гамшгаас хамгаалах сургалтын хөтөлбөр боловсруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх бодлого

АХ-ийн гишүүд нарийвчлан ярилцаад, анх төлөвлөж байсан хөтөлбөр боловсруулах хороог байгуулахгүй байхаар тогтож, АХ 3-1-ийн гишүүд төслийн мэргэжилтнүүдтэй санал бодлоо солилцож, зөвлөлдсөний үндсэн дээр хөтөлбөр боловсруулах ажлыг хийхээр шийдвэрлэсэн.

Мөн энэхүү сургалтын хөтөлбөрийг зөвхөн газар хөдлөлт төдийгүй, Монгол орны хэмжээнд тохиолддог гамшгийн төрлийг бүхэлд нь хамруулж боловсруулсан.

2) Сургалтын хөтөлбөр боловсруулах үе шат

(а) Японы удирдамж болон холбогдох баримт бичгүүдтэй танилцсан

Хөтөлбөр боловсруулах ажил эхлэхийн өмнө Японы Боловсрол, Соёл, Спорт, Шинжлэх Ухаан, Технологийн Яам (цаашид “Японы Боловсролын яам” гэх)-наас боловсруулсан “Сургуулийн гамшгаас хамгаалах сургалтын удирдамж: Амьдрах чадварыг хөгжүүлэх гамшгаас хамгаалах боловсролыг

хэрэгжүүлэх нь” товхимлыг ашиглан Японы сургуулийн гамшгаас хамгаалах боловсролын үндсэн санаа болон тогтолцооны талаар танилцуулсан. Мөн Японы муж болон хотуудын боловсролын хорооноос боловсруулсан гамшгаас хамгаалах боловсролын нарийвчилсан төлөвлөгөө, гарын авлага зэргийг танилцуулсан. Түүнчлэн сургалтын удирдамж болон загвар хичээлийн төлөвлөгөөний агуулгад дурдсан сургалтын агуулгуудын хамаарлыг үзүүлж, холбогдох сурах бичгийн тодорхой хуудсуудыг зааж өгсөн хүснэгт өгсөн. Түүнээс гадна, хөтөлбөртэй холбоотой хэд хэдэн холбогдох материалыг Монгол хэлнээ орчуулж, АХЗ-1-ийн үйл ажиллагаанд ашигласан. Мөн төслийн Япон мэргэжилтний зүгээс 131-р сургуулийн 4-р ангийн сурагчдад гамшгаас хамгаалах сэдвээр үзүүлэх хичээлийг явуулсан.

(б) Монгол улсын сургуулийн гамшгаас хамгаалах боловсролын өнөөгийн байдлын талаарх шинжилгээ

Монгол улсын сургуулийн гамшгаас хамгаалах боловсролын өнөөгийн байдлыг тодорхойлохын тулд Монгол улсын СӨБ, бага боловсрол, суурь болон бүрэн дунд боловсролын хөтөлбөр дэх гамшгаас хамгаалах агуулгуудын талаар шинжилгээ хийсэн. Шинжилгээний голлох үр дүнгүүд нь дараах байдалтай байна.

- Аюулт үзэгдэл ба гамшгийн тухай агуулга нь дээд боловсрол, бүрэн дунд, суурь боловсролд хангалттай тусгагдсан байна. Харин СӨБ ба бага боловсролын агуулгад аюулт үзэгдэл ба гамшгийн тухай тодорхой хэмжээгээр орсон байна.
- Экологийн гаралтай гамшгийн тухай агуулга 48 хувийг эзэлж байна. Түүний ихэнх нь суурь боловсрол, бүрэн дунд боловсролын газарзүй, химийн хичээлийн агуулгад багтсан байна.
- Байгалийн гамшгийн агуулгыг газарзүйн хичээлийн хөтөлбөрт оруулсан байна.
- Техник технологийн гамшгийн агуулгууд нь химийн хичээлийн хөтөлбөрт химийн бодистой хэрхэн харьцах, химийн хорт бодисын нөлөө зэрэг агуулгаар туссан байна.
- Нийгмийн гаралтай болон биологийн гаралтай гамшгийн агуулгууд тэр бүр хичээлийн хөтөлбөрүүдэд багтаагүй байна.
- Ерөнхийдөө одоогийн сургалтын хөтөлбөрийн гамшгаас хамгаалах боловсролын зорилго, зорилтууд нь тодорхой бус. Мөн гамшгаас

хамгаалах боловсролтой хамааралтай агуулгууд нь газарзүй, нийгэм судлал зэрэг зарим хичээлд тусгагдсан боловч гамшгаас хамгаалах суралцахуйн системтэй байдал хангагдаагүй.


- Хувь хүний аюулгүй амьдрах ухааны агуулгууд нь СӨБ болон бага боловсролын хөтөлбөрт тусгагдаж, аюулт үзэгдэл, осол, гамшиг болон нийгмийн аюулгүй байдал зэрэг агуулгууд нь суурь болон бүрэн дунд боловсролын хөтөлбөрт туссан.

(в) Сургуулийн гамшгаас хамгаалах сургалтын хөтөлбөрийн төслийг боловсруулах

Холбогдох материал болон одоогийн сургуулийн гамшгаас хамгаалах агуулгын дүн шинжилгээний үр дүнд үндэслэн, боловсролын түвшин тус бүрийн гамшгаас хамгаалах боловсролын удирдамжийн нэр, бүтэц, зорилгыг дараах байдлаар тодорхойлсон.

- Удирдамжийн нэр: “Аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөр”
- Бичиг баримтын хэлбэр: БСШУСЯ-ны сайд болон Шадар сайд батлах сургалтын хөтөлбөр.
- Хөтөлбөрийн агуулга: Сургалтын хөтөлбөрт дан ганц байгалийн гамшиг бус аюулгүй амьдрах ухааны сургалтыг бүхэлд нь хамруулна.
- Хөтөлбөрийн бүтэц: 1) Үндэслэл, 2) Зорилго, 3) Агуулга ба 4) Заах арга зүй

Дээрх бүтцээр хөтөлбөрийн төслийг боловсруулсан. Монгол улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам (цаашид “БСШУСЯ” гэх)-наас олон нийтийн анхны хэлэлцүүлгийг 9-р сард явуулсан бөгөөд хөтөлбөрийн төслийг эцэслэхтэй холбогдуулан холбогдох мэргэжлийн байгууллага, мэргэжилтнүүдээс санал, зөвлөгөө авах уулзалтыг 10-р сарын 4-ний өдөр зохион байгуулсан. Ажлын хэсгийн гишүүд Япон дахь сургалтаар олж авсан мэдлэг болон 2018 оны 1, 2 сард хийгдсэн Ажлын хэсэг 3-1-ийн воркшоп зэргийн үр дүнд “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн төслийг эцэслэн сайжруулах ажил хийгдсэн.



Эх сурвалж: ЖАЙКА
Мэргэжилтний Баг
Зураг II.1.13
Батлагдсан
сургалтын хөтөлбөр

Хөтөлбөрийн төслийг 2018 оны 3 сард БСШУСЯ-д хүлээлгэн өгсөн ба үүний дараа БСШУСЯ-ны хөтөлбөр батлуулах журмын дагуу мэргэжлийн экспертээр уншуулж, түүнээс гарсан саналын дагуу дахин сайжруулах ажил хийгдсэн. “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөр нь 2018 оны 4 сарын 6-ны өдрийн БСШУС-ын сайдын тушаалаар батлагдсан.

Хөтөлбөр нь 1) Үндэслэл, 2) Зорилго, 3) Агуулга, 4) Арга зүй, 5) Үнэлгээ гэсэн 5 үндсэн хэсэг ба “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн агуулга, хичээл, сургалтын үйл ажиллагааны уялдааг харуулсан матрицаас бүрдэнэ. (Хавсралт: “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөр)

Үйл ажиллагаа 3.1.2: Цэцэрлэг, сургуулийн гамшгийн эрсдэлийг бууруулах сургалтад ашиглах сурах бичгийн нэмэлт материал, сургалтын материал зэргийг боловсруулах

1) Өмнө гарсан гамшгаас хамгаалах сургалтын материалтай танилцах

Сургалтын материал боловсруулахын өмнө одоо байгаа гамшгаас хамгаалах сургалтын материалыг цуглуулсан. Үүнд, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгтэй боловсруулсан сургуулийн гамшгаас хамгаалах сургалтанд ашиглах сурах бичиг бий ч улсын хэмжээний сургуулиудад ашиглахын тулд агуулгыг сайжруулах шаардлагатай. Учир нь гамшгаас хамгаалах сургалтын агуулгыг бие даасан хичээл хэлбэрээр заах зорилготой боловсруулсан, мөн сурах бичгийн зарим нэг агуулга, зургийг оросын сурах бичгээс хуулбарлан тавьсан нь зохиогчийн эрхийг асуудлыг шийдвэрлэж чадаагүй.

Дээр дурдсан НҮБХХ-ийн сурах бичгээс гадна Дэлхийн зөн Монгол ОУБ-аас гамшгийн төрлүүдээр хүүхдэд зориулан гаргасан, сургуулийн гамшгаас хамгаалах сургалтанд ашиглаж болохоор хэд хэдэн сайн сургалтын материал бий. Гэхдээ хүүхдийн насны онцлог, хичээлүүдийн агуулгад суурилсан системтэй боловсрол олгох боломжтой материал одоогоор байхгүй байна. Багш нар сургалтын төлөвлөгөөний дагуу төвөггүй ашиглах боломжтой сургалтын материал, гарын авлагаар хангах шаардлага тулгарсан.

2) “Аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх багшийн гарын авлагыг боловсруулах

Дээрх нөхцөл байдлаас “Аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөр”-ийн хавсралт материал болох “Багшийн гарын авлага”-ыг боловсруулах нь зүйтэй

гэж үзсэн. АХЗ-1-ийн хэд хэдэн уулзалтын үеэр ярилцсаны дүнд “Багшийн гарын авлага”-ын бүтцийг дараах байдлаар тогтоосон.

Удиртгал хэсэг

1. “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн агуулга
2. “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн санаа
3. Сургалтыг дэмжих үйл ажиллагааны агуулга, арга зүй

Нэр томъёоны тайлбар

Ном зүй

Гарын авлагын төсөл Ажлын хэсэг 3-1-ийн хэд хэдэн удаагийн воркшоп болон төслийн Япон мэргэжилтний явуулсан загвар хичээлийн үр дүнд дүр зураг нь тодорхойлогдож, 2018 оны 10 сараас 2019 оны 3 сар хүртэлх хугацаанд ажлын хэсгийн гишүүд хариуцсан сэдвүүд дээр ажилласан. 2019 оны 3-р сараас 5-р сарын эх хүртэлх хугацаанд гишүүд тус бүрээс ирүүлсэн эцсийн хувилбарыг ижил форматад оруулан нэгтгэж, СӨБ болон бага, суурь, бүрэн дунд боловсролын багшийн гарын авлага болгон нэгтгэн боловсруулав. Доорх хүснэгтэд үзүүлсэнчлэн 2019 оны 5 сард БСШУСЯ-д хүлээлгэн өгсөн гарын авлагын эцсийн төслийг 2019 оны 7-р сард экспертээр хянуулж, тэрхүү саналд үндэслэн сайжруулах ажлыг хийж, эцэслэсэн.

Хүснэгт II.1.12 Гарын авлагын агуулга (Бага, суурь, бүрэн дунд боловсрол)

“Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшийн гарын авлага (Бага, суурь, бүрэн дунд боловсрол)-ын гарчиг	
<p>Өмнөх үг “Аюулгүй амьдрах ухаан” хөтөлбөр</p> <p>Удиртгал</p> <ul style="list-style-type: none"> ✧ “Аюулгүй амьдрах ухаан” хөтөлбөр гаргах үндэслэл ✧ “ААУ” сургалтын хөтөлбөрийн агуулга ✧ Гарын авлагын бүтэц ба ашиглахад анхаарах зүйл <p>1-р бүлэг: Гамшгийн тухай ерөнхий ойлголт</p> <ul style="list-style-type: none"> ✧ Гамшгийн нөхцөл байдал ✧ Гамшиг, аюул, эмзэг байдал ✧ Газар хөдлөлтийн тухай ойлголт <p>2-р бүлэг: Хичээлийн арга зүйн санаа (Бага боловсрол)</p> <ul style="list-style-type: none"> ✧ Нийгмийн орчны аюулгүй байдал: Зүг чигээ зөв олж суръя 	<ul style="list-style-type: none"> ✧ Уур амьсгалын өөрчлөл, түүнийг сааруулахадбидний оруулах хувь нэмэр ✧ Байгалийн аюулт үзэгдэл: Газар хөдлөлтийн аюулаас өөрийгөө болон бусдыг хамгаалъя/ Аянга цахилгаанаас урьдчилан сэргийлье <p>4-р бүлэг:Хичээлийн арга зүйн санаа (Бүрэн дунд боловсрол)</p> <ul style="list-style-type: none"> ✧ Байгалийн аюулт үзэгдэл: Өрхийн эрсдэлийн бэлэн байдлын төлөвлөгөө хийцгээе ✧ Нийгмийн орчны аюулгүй байдал: Цахим гэмт хэргээс сэргийлье <p>5-р бүлэг Сургалтыг дэмжих үйл ажиллагааны агуулга, арга зүй</p> <ul style="list-style-type: none"> ✧ Сургуулийн үйл ажиллагааны төлөвлөлтийн жишээ ✧ Хичээлээс гадуурх үйл ажиллагааны зорилго ✧ Бага боловсрол: Хичээлээс гадуурх үйл

<ul style="list-style-type: none"> ✧ Нийгмийн орчны аюулгүй байдал: Уур амьсгалын өөрчлөлт ✧ Байгалийн аюулт үзэгдэл: Газар хөдлөлтөд тэсвэртэй байшингийн загвар бүтээцгээ ✧ Газар хөдлөлт ✧ Гал түймэр ✧ 3-р бүлэг: Хичээлийн арга зүйн санаа (Суурь боловсрол) ✧ Ахуйн орчны аюулгүй байдал: Усны бохирдлоос өөрийн эрүүл мэндийг хамгаалах аргад суралцъя ✧ Цаг уурын аюулт үзэгдэл: “Цаг уурч больё” 	<ul style="list-style-type: none"> ажиллагааны цагаар хэрэгжүүлэх агуулга ба арга зүйн санаа ✧ Суурь боловсрол: Хичээлээс гадуурх үйл ажиллагааны цагаар хэрэгжүүлэх агуулга ба арга зүйн санаа ✧ Бүрэн дунд боловсрол: Хичээлээс гадуурх үйл ажиллагааны цагаар хэрэгжүүлэх агуулга ба арга зүйн санаа ✧ Нэр томъёоны тайлбар Ном зүй
---	---

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Хүснэгт II.1.13 Гарын авлагын агуулга (Сургуулийн өмнөх боловсрол)

“Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшийн гарын авлага (Сургуулийн өмнөх боловсрол)-ын гарчиг
<p>Өмнөх үг</p> <p>“Аюулгүй амьдрах ухаан” хөтөлбөр</p> <p>Удиртгал</p> <ol style="list-style-type: none"> 1. “Аюулгүй амьдрах ухаан” хөтөлбөр гаргах үндэслэл 2. “ААУ” сургалтын хөтөлбөрийн агуулга 3. Гарын авлагын бүтэц ба ашиглахад анхаарах зүйл <p>1-р бүлэг: Гамшгийн тухай ерөнхий ойлголт</p> <ol style="list-style-type: none"> 1. Гамшгийн нөхцөл байдал 2. Гамшиг, аюул, эмзэг байдал 3. Газар хөдлөлтийн тухай ойлголт <p>2-р бүлэг: Цэцэрлэгийн сургалтын хөтөлбөрт гамшгаас хамгаалах үйл ажиллагааг тусгах нь</p> <ol style="list-style-type: none"> 1. СӨБ-ын сургалтын цөм хөтөлбөр, аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөрийн уялдаа 2. “ААУ” сургалтын хөтөлбөрийг өдөр тутмын сургалт, үйл ажиллагаагаар хэрэгжүүлэх арга зүйн санаа буюу хөгжүүлэх үйл ажиллагааны жишээ <p>Нэр томъёоны тайлбар</p> <p>Ном зүй</p>

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Багшийн гарын авлагын агуулгыг эцэслэсний дараа 2019 оны 10-р сард хэвлэж, 11-р сард төрийн өмчит сургууль, цэцэрлэгүүдэд тараагдсан.

Үйл ажиллагаа 3.1.3 3.1.1 болон 3.1.2-д боловсруулсан удирдамж болон сургалтын материалыг ашиглан Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын арга зүйчид (тайлбар 3-1), аймаг нийслэлийн боловсролын газрын мэргэжилтнүүдэд сургалт явуулах.

1) Сургагч багшийн сургалтын хөтөлбөр боловсруулах ажил

Ажлын хэсгийн үйл ажиллагааны хүрээнд, сургалтад хамрагдах хүн болон сургалт хийгдэх газар, сургалтын хөтөлбөрийн талаар хэлэлцсэн. Ажлын хэсгийн гишүүд эхлээд Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтнууд болон Багшийн Мэргэжил Дээшлүүлэх Институтын арга зүйчдэд зориулан үндэсний сургагч багшийн сургалт явуулж, орон нутгийн арга зүйчдэд

зориулсан сургалтын хөтөлбөр болон агуулгыг тогтоох нь зүйтэй гэж үзсэн. Багш, арга зүйчдийн нэг жилийн сургалтын үйл ажиллагааны хуваарь зэргийг оролцуулан хэлэлцсэний дүнд, үндэсний болон орон нутгийн сургагч багшийн сургалтыг доорх хүснэгтэд үзүүлсэнчлэн 3 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.

Хүснэгт II.1.14 Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт

	Үндэсний сургагч багшийн сургалт	Орон нутгийн сургагч багшийн сургалт (1дэх сургалт)	Орон нутгийн сургагч багшийн сургалт (2дахь сургалт)
Сургалт явагдсан газар	УБ хот	УБ хот	УБ хот
Хугацаа	2018.9.11-13	2018.9.17-21	2018.10.8-11
Сургалтад оролцогч	Боловсролын хүрээлэн, БМДИ, НИГХСАЗТ-ийн багш	Орон нутгийн бага, дунд боловсролын арга зүйч нар	Орон нутгийн СӨБ хариуцсан арга зүйч нар
Оролцогсдын тоо	Нийт 50 хүн	Аймаг, нийслэл, дүүргийн БСГ-аас тус бүр 2 хүн (Нийт 60 хүн)	Аймаг, нийслэл, дүүргийн БСГ-аас 1 хүн (Нийт 30 хүн)

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Түүнчлэн үндэсний сургалтын өмнө Нийслэлийн иргэдийн гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төв (НИГХСАЗТ)-өөс өөрийн багш нарыг тус сургалтад хамруулах хүсэлт ирсэн. Тус төвийн багш нар гол төлөв сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдтэй ажилладаг бөгөөд энэхүү нөхцөл байдлыг харгалзан, 10 багшийг тус сургалтад хамруулсан.

2) “Аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөр”-ийн сургагч багшийн үндэсний сургалт

Үндэсний сургалт нь 2018 оны 9 сарын 11-13-ны өдрүүдэд явагдсан бөгөөд, Боловсролын хүрээлэн, БМДИ-ийн эрдэм шинжилгээний ажилтан болон арга зүйч 50 хүн, НИГХСАЗТ-ийн 10 багш хамрагдсан. Сургалтад оролцогсод “ААУ” сургалтын хөтөлбөрийн агуулгын талаар ярилцаж хэлэлцсэн бөгөөд хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой хэд хэдэн чухал саналуудыг дэвшүүлсэн. Гол хэдэн санааг дор нэгтгэв.

- “Аюулгүй амьдрах ухаан”-ыг багшийн мэргэжил дээшлүүлэх судалгааны ажлын нэг болгох
- Суралцагчдад практик дадал олгохын тулд аймаг, дүүргүүдийн онцгой байдлын албатай хамтран ажиллах
- “Аюулгүй амьдрах ухаан”-ы онлайн сургалтын материалыг бэлтгэх
- Багш, арга зүйч нар хэрэглэхэд хялбар “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хэрэглэгдэхүүн, сургалтын материалыг багтаасан веб хуудсыг гаргах

- “Аюулгүй амьдрах ухаан”-ы хичээлийн сайн жишээг цуглуулж, таниулах
- НИГХСАЗТ-ийн сургалтад хамрагдах асуудлыг сургуулийн үйл ажиллагааны хөтөлбөрт тусгах
- Багш нарыг сургах үүднээс НИГХСАЗТ-тэй хамтран ажиллах
- Сургуулийн гамшгаас хамгаалах менежмент болон сургуулийн гамшгаас хамгаалах сургалтын талаарх сургуулийн дүрэм журмыг гаргах
- “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг эцэг эх, холбогдох хүмүүст танилцуулах брошурыг гаргах

Тус сургалтад НИГХСАЗТ-ийн багш нар хамрагдсанаар, гамшгаас хамгаалах албаны мэргэжлийн хүн болон боловсролын байгууллагын мэргэжилтнүүд хамтран, сургалтын хөтөлбөрөөр дамжуулан цаашдын үйл ажиллагааг сайжруулж хөгжүүлэх сүлжээг байгуулах боломжтой боллоо.

3) “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн сургалт (1 дэх сургалт)

“Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн нэг дэх сургалт нь 2018 оны 9 сарын 17-21-ний өдөр болсон ба түүнд 21 аймаг, 9 дүүргийн боловсролын газрын бага, дунд боловсрол хариуцсан 57 арга зүйч оролцсон.

Үндэсний сургалтад оролцогчидтой харьцуулахад энэ удаагийн сургалтад хамрагдагсад нь шинээр нэвтрүүлсэн сургалтын арга хэлбэр, хичээлийн интеграци, воркшоп сургалтын хэв маягийн талаарх туршлага дутмаг байсан. Тиймээс, “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн агуулгыг ойлгоход нэлээн хугацаа шаардсан. Ажлын хэсгийн гишүүд сургалтын явцад ярилцаж, агуулгын талаар зөвлөлдөн хэлэлцсэний эцэст, сургалтын хөтөлбөрт бага зэргийн өөрчлөлт хийж, аюулгүй амьдрах ухааны талаарх загвар хичээлийг заахаар шийдсэн. Үүний үр дүнд сургалтад оролцогчид агуулгыг сайтар ойлгож чадсан ба сургалтын төгсгөлд өөрийн аймаг, дүүрэгт “Аюулгүй амьдрах ухаан” сургалтыг дэлгэрүүлэх төлөвлөгөөг гаргасан. Сургалтаар санал болгон дэвшүүлсэн төлөвлөгөөний жишээнээс дор дурдвал,

- Сургуулийн захирал, дэд захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, байгалийн ухааны багш, эрүүл мэндийн багшаас бүрдсэн “Аюулгүй амьдрах ухаан”-ы сургалтыг дэлгэрүүлэх багийг байгуулах
- Сургуульд холбогдох мэдээлэл болон сургалтын хэрэглэгдэхүүнийг байрлуулсан “аюулгүй амьдрах танхим”-ыг байгуулах
- Онцгой байдлын алба, замын цагдаагийн алба, Улаан загалмайн нийгэмлэгтэй хамтран ажиллах
- Эцэг эхийн хурал болон суралцагчийн гэрээр очих үед аюулгүй амьдрах ухааны талаар ярьж таниулах

- “Аюулгүй амьдрах ухаан” сургалтыг явуулж буй шилдэг жишээний талаарх уралдааныг зохиох
- Жилийн ажлын төлөвлөгөөнд “Аюулгүй амьдрах ухаан” сургалтыг дэлгэрүүлэх асуудлыг оруулахыг засаг даргад санал



Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Зураг II.1.14 Сургагч багшийн сургалт дээрх лекц ба воркшоп (1 дэх сургалт)

4) “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн сургалт (2 дахь сургалт)

“Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн хоёр дахь сургалт нь 2018 оны 10 сарын 8-11-ний өдөр болсон ба түүнд 21 аймаг, 9 дүүргийн боловсролын газрын сургуулийн өмнөх боловсрол хариуцсан 30 арга зүйч оролцсон.

Эхний удаагийн сургалтаас олж авсан туршлагад тулгуурлан сургалтын хөтөлбөрийг бага зэрэг өөрчлөн, ажлын хэсгийн гишүүд 5 сард туршилтын хичээл явуулж байсан, аюулгүй амьдрах ухааны сургалтыг амжилттай хэрэгжүүлж буй 61-р цэцэрлэгийн үйл ажиллагаатай танилцах аяллыг оруулсан. Эдгээр өөрчлөлтийн үр дүнд сургалтад оролцогчид аюулгүй байдал болон гамшгаас хамгаалах сургалтын талаар амьдралд хэрэглэх боломжтой, бүтээлч санааг дэвшүүлж, санал бодлоо солилцсон. Сүүлийн өдрийн воркшопын үеэр оролцогчид өөрийн хариуцсан салбарын хүрээнд аюулгүй амьдрах ухааныг дэлгэрүүлэн хөгжүүлэхийн тулд дараах саналыг гаргасан.

- Гамшгаас хамгаалах тухай хуулийн талаар орон нутгийнхаа засаг захиргаанд таниулж, төсвийн 1 хувийг гамшгийн эрсдэлийг бууруулахад зарцуулах
- Өдөр тутмын амьдралдаа аюулгүй амьдрах ухааныг хэвшүүлэх
- Орон нутгийн засаг захиргаатай хамтран гамшгаас хамгаалах дасгал сургуулилалтыг явуулах
- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр аюулгүй амьдрах ухааны талаар нэвтрүүлж дэлгэрүүлэх

- Цэцэрлэгүүдэд аюулгүй амьдрах ухааны сургалтын хэрэгжилтэд үүсэх асуудлыг шийдвэрлэхийн тулд орон нутгийн засаг захиргаа, ТББ, ОУБ, хандивлагч орны тусламжийг авах
- Одоогийн хичээл болон сургалтыг дэмжих үйл ажиллагаатай холбож аюулгүй амьдрах ухааны сургалтыг олгоход анхаарч ажиллах
- Аюулгүй амьдрах ухааны агуулга болон аргын талаар ойлголттой хүний нөөцийг нэмэгдүүлэх

СӨБ нь аюулгүй амьдрах ухаантай нягт холбоотой. Тиймээс сургалтад оролцогчид сургалтын туршид “ААУ” хөтөлбөрт үндэслэн хэрхэн сургалтаа явуулах талаар нухацтай авч хэлэлцсэн.



Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Зураг II.1.15 Сургагч багшийн сургалт дээрх лекц ба воркшоп (2 дахь сургалт)


5) “Аюулгүй амьдрах ухаан” сургагч багшийн сургалтыг дүгнэх

Ажлын хэсэг 3-1-ийн гишүүд 10 сарын 12-нд сургалтаа дүгнэж ярилцаад сургалтын үр дүнг бататган, дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсэн.

- Бага сургуулийн багш нарын нэгдсэн мэйлийн системийг ашиглан, сургалтын материалыг тараана.
- 2018 оны үлдсэн төсвийг ашиглан, сургуулийн намрын амралтаар “ААУ” сургалтын хөтөлбөрийг таниулах сургалтыг явуулна.
- БМДИ-ийн нэг жил, 5 жил, 10 жилийн туршлагатай багш нарт зориулсан үндсэн сургалт(хагас өдөр, нэг өдөр)-ын агуулгад оруулах.
- Орон нутгийн түвшинд сургагч багш бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсруулах
- Сонгогдсон сургууль, цэцэрлэгт загвар хичээл явуулах

2018 оны 9, 10 сард явагдсан сургагч багшийн сургалтыг үнэлэхийн тулд асуулга судалгаа явуулсан. Сургалтад оролцогчдын дийлэнх хувь нь сургалтын хөтөлбөр, чанар, зохион байгуулалтын талаар өндөр сэтгэгдэлтэй байсан. Түүнчлэн оролцогчдын 80% нь сургалтын агуулгад сэтгэл хангалуун

байгаа бөгөөд цаг үеэ олсон сургалт байсан тухай дурдсан байна. Сургалтад сууснаар гамшигт бэлэн байхын чухлыг, мөн гамшиг хэзээ ч тохиолдож магадгүй гэдгийг, гамшгийн үеийн хамтын хүчийн чухлыг, аюулгүй амьдрах ухааны агуулгыг бусад хичээлийн агуулгатай интеграцчилан заах тухай олон зүйлийг олж мэдсэн талаар өгүүлсэн.



Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Зураг II.1.16 Асуулга судалгааны үр дүн

Үйл ажиллагаа 3.1.4 3.1.3-ын сургалтад хамрагдсан арга зүйч, мэргэжилтнүүд багш нараар удирдуулан сургуулийн багш нарт сургалт явуулах

2018 оны 12-р сарын 27-28-ны өдрүүдэд “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн дагуу НОБГ, АХ 3-1-ийн гишүүд болон мэргэжилтний багийн дэмжлэгтэйгээр Баянзүрх дүүргийн цэцэрлэгүүдийн багш нарт заах аргын талаар сургалт явуулсан.

2019 оны 1-р сарын 16-нд Үйл ажиллагаа 3.1.3-ын сургалтад хамрагдсан арга зүйч багш нарын зүгээс БСШУСЯ-наас уламжлал болгон зохион явуулдаг 10 жил ажилласан багш нарт чиглэсэн сургалтаар “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн талаар хичээл заасан ба Мэргэжилтний баг дэмжлэг үзүүлж ажилласан.

Түүнчлэн “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн хүрээнд гамшгаас хамгаалах агуулгыг хичээлээр заахад сайн жишээ нэвтрүүлэх зорилго бүхий загвар сургуулийн үйл ажиллагааг УБ хотын 244-р цэцэрлэг, 13 болон 42-р сургуулиудад тус тус хэрэгжүүлсэн.

Хүснэгт II.1.15 Загвар сургууль цэцэрлэг дээрх үйл ажиллагаа

Зорилго	<ul style="list-style-type: none"> СӨБ болон бага, дунд боловсролд “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийн хүрээнд гамшгаас хамгаалах агуулгыг хичээлээр заахад сайн жишээ нэвтрүүлэх Сайн жишээний эцсийн хувилбараар видео хичээл боловсруулж, Багшийн гарын авлагын хавсралт материал болгон ашиглах 			
Оролцогчид	Сонгогдсон загвар сургууль, цэцэрлэгийн багш сурагчид, дүүргийн Боловсролын хэлтэс, Онцгой байдлын хэлтсийн мэргэжилтнүүд, АХЗ-1 гишүүд			
Хугацаа	2019 оны 3-р сарын 5-19-ний өдөр			
Байршил	Тус тусын сонгогдсон сургууль, цэцэрлэг			
Гол үйл ажиллагаа, огноо (оролцогчдын тоо)		244-р цэцэрлэг	13-р сургууль (бага анги)	42-р сургууль (дунд анги)
1) Багш, ажилчдад зориулсан семинар		3/5 10:00~13:00 (43 хүн)	3/7 10:10~13:10 (53 хүн)	3/6 9:30~12:30 (38 хүн)
2) Загвар хичээлийн талаарх воркшоп сургалт 1		3/11 10:00~13:00 (14 хүн)	3/12 10:15~13:10 (4 хүн)	3/11 14:00~17:00 (5 хүн)
3) Загвар хичээлийн талаарх воркшоп сургалт 2		3/13 14:00~17:00 (16 хүн)	3/14 16:00~18:00 (4 хүн)	3/13 10:00~13:00 (5 хүн)
4) “Аюулгүй амьдрах ухаан” судлагдахуун хичээл		3/15 9:30~10:30 (Хичээлийн дараах үнэлгээний уулзалт) (13 хүн)	3/19 10:15~11:40 (Хичээлийн дараах үнэлгээний уулзалт) (4 хүн)	3/18 12:20~14:00 (Хичээлийн дараах үнэлгээний уулзалт) (8 хүн)

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

	244-р цэцэрлэг	13-р сургууль (бага анги)	42-р сургууль (дунд анги)
Лекц			
Дадлага ажил			

Нээлттэй хичээл



Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Зураг II.1.17 Загвар сургууль, цэцэрлэг дээрх үйл ажиллагаа

БСШУСЯ-наас уламжлал болгон зохион явуулдаг Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын сургалтын хөтөлбөрт “Аюулгүй амьдрах ухаан” багшийн гарын авлагын агуулгыг багтаан сургалт явуулах юм.


Үйл ажиллагаа 3.2.1 Төв, орон нутгийн гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны нэгдсэн график төлөвлөгөө боловсруулах

1) Нэгдсэн график төлөвлөгөөний цар хүрээ

(a) Гамшгаас хамгаалах сургалтын зохицуулалтын асуудал

Үйл ажиллагаа 3.2.1-ийн эхэнд ЖАЙКА-гийн мэргэжилтний багийн зүгээс АХЗ-2-ын хүрээнд хэрэгжих гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны үйл ажиллагааны одоогийн байдал болон тулгарч буй гол асуудлуудыг дараах байдлаар тодорхойлсон.

- ОБЕГ болон НОБГ нь сургалт сурталчилгааны ажлын жилийн төлөвлөгөөгөө тус тусдаа боловсруулдаг. Уг төлөвлөгөө тухайн жилдээ шинэчлэгддэггүй.
- Гамшгаас хамгаалах боловсрол, сургалтад ихээхэн дэмжлэг үзүүлдэг хандивлагчдын үйл ажиллагааг ОБЕГ болон НОБГ-ын төлөвлөгөө боловсруулахад харгалзан үздэггүй.
- Хандивлагчдын гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа, сургалтын материал боловсруулахтай холбоотой ажлуудад зохицуулалт хийгддэггүйгээс зарим хандивлагчдын үйл ажиллагаа давхарддаг.
- Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны талаарх мэдээллийг олон нийтэд хангалттай хүргэж чаддаггүй.



Эх сурвалж: ЖАЙКА
Мэргэжилтний Баг
Зураг II.1.18 ОБЕГ-ын даргын тушаалаар батлагдсан үйл ажиллагааны дүрэм

Дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд АХЗ-2-ын уулзалтуудаар дараах үйл ажиллагааны талаар санал дэвшүүлсэн.

- i) Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаа явуулах голлох байгууллагуудын үйл ажиллагааны мэдээллийг нэгтгэж, сургалтын товыг байнга шинэчлэх.
- ii) Төрийн болон хандивлагч байгууллагууд нэвтрэх эрх бүхий веб хуудастай болж, гамшгаас хамгаалах боловсрол, сургалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг байршуулан удирдах. Тогтвортой ажиллуулах үүднээс веб хуудас нь энгийн систем, дизайнтай байх ба мэдээллийг шинэчлэхэд хялбар байх талаас нь бодолцох.
- iii) Жилийн төлөвлөгөөнд хандивлагчдын үйл ажиллагааг тусгаж оруулах
- iv) Төрийн болон хандивлагч байгууллагууд хоорондын мэдээлэл солилцох мэйлинг лист систем ашиглаж, ажиллуулах

2) Сургалт сурталчилгааны нэгдсэн график төлөвлөгөө хөгжүүлэх үйл ажиллагаа

(a) Үйлдлийн систем

Нэгдсэн график төлөвлөгөөг тогтвортой хэрэгжүүлэхийн тулд АХЗ-2-ын хүрээнд анхны үйлдлийн системийн төслийг гаргасан бөгөөд АХ-ын хурлаар гамшгаас хамгаалах сургалт сурталчилгаа явуулдаг байгууллагуудыг урьж оролцуулахаар болсон. АХ-ийн уулзалтын үр дүнд ОБЕГ-ын ГУСГ гол удирдлагаар хангаж, БЗХАГ-ын дэмжлэгтэй ажиллах “Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны баг” бүрдсэн ба Нэгдсэн график төлөвлөгөөний тухайд Дэлхийн зөн Монгол ОУБ-ын дэмжлэгтэйгээр ажиллана. Хүснэгт II.1.16-д үзүүлсэн Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны багийн зорилго, бүтэц, гишүүдийн үүрэг хариуцлагын талаар заасан багийн ажиллах журам ОБЕГ-ын даргын тушаалаар батлагдсан.

Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны баг байгуулагдсанаас хойш холбогдох байгууллагуудтай нэг бүрчлэн харилцах бус нэгдсэн байдлаар зохицуулалт хийх зорилготой ээлжит уулзалт зохион байгуулахад нь ОБЕГ-т ЖАЙКА мэргэжилтний багийн зүгээс дэмжлэг үзүүлж ажилласан. 2017 оны 5-р сараас хойш багийн удирдах зөвлөлийн нийт 5 уулзалт, түүнчлэн зарим нэг гишүүдтэй хэд хэдэн уулзалт хийгдсэн.

Хүснэгт II.1.16 Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны багийн зорилго ба удирдах зөвлөлийн гишүүд

Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны багийн дүрэм	
Зорилго	Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааг төлөвлөх, цогц байдлаар хэрэгжүүлэх, төрийн болон төрийн бус, олон улсын байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, үр ашгийг дээшлүүлэх, сургалт, сурталчилгааны мэдээллийг олон нийтэд нээлттэй хүргэх
Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн	<p>Дарга: ОБЕГ-ын ГУСГ-ын Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны хэлтсийн дарга</p> <p>Дэд дарга: “Дэлхийн Зөн-Монгол” ОУБ-ын Хүмүүнлэгийн онцгой байдлын хэлтэс</p> <p>Гишүүд:</p> <p>(Төрийн байгууллагаас)</p> <ul style="list-style-type: none"> - ОБЕГ-ын БТХАГ-ын төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн - НОБГ-ын орлогч, Урьдчилан сэргийлэх тасгийн ахлах мэргэжилтэн - БСШУСЯ-ны Бодлогын бодлогын газрын Насан туршийн боловсролын бодлого, төлөвлөлт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн - Одон орон геофизикийн судалгааны хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан - Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвийн багш <p>(Төрийн бус байгууллагаас)</p> <ul style="list-style-type: none"> - НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн мэргэжилтэн - МУЗН-ын Гамшгийн хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн - Японы Хүүхдийг ивээх сангийн хүмүүнлэгийн асуудал хариуцсан ажилтан

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг


(б) Сургалтын төлөвлөгөөний мэдээлэл нийтлэх веб хуудас хөгжүүлэлт

Нэгдсэн график төлөвлөгөөний мэдээлэл хуваалцах системийн үйл ажиллагаа эхлэхийн өмнө Мьянмар болон Непал улсын платформын жишээг танилцуулж, судалж үзсэн. Уулзалтуудын үр дүнд гол мэдээлэл болох “Хэзээ (хугацаа)”, “Хэн (зохион байгуулагч)”, “Хаана (байршил)” болон “Ямар үйл ажиллагаа” гэсэн гол агуулгуудаас бүрдэх бүтэцтэй байхаар тогтсон. Түүнчлэн мэдээлэл оруулах системийг холбогдох байгууллагууд мэдээллээ түвэггүй оруулах талаас нь бодолцож боловсруулсан.


Энэхүү веб хуудсыг 2019 оны 1-р сард гарын авлагын хамт боловсруулж дууссан¹. 1-р сарын 31-ний өдөр уг системийг хэрхэн ашиглах талаарх сургалт, уулзалтыг ОБЕГ-ын хурлын танхимд явуулсан. ОБЕГ, НОБГ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Японы Хүүхдийг ивээх сан, Дэлхийн Зөн-Монгол, МУЗН болон бусад хандивлагч байгууллагын төлөөлөл 21 оролцогч сургалт уулзалтад оролцсон. Түүнчлэн ОБЕГ-ын харьяа байгууллагуудад чиглэсэн онлайн сургалтад 57 ажилтан албан хаагч оролцсон.

¹ <http://ontsgoisur.gov.mn/pages/taylan-4w-programm-khangamzhiyn-taniitsuulga-garyn-avlaga> -г үзнэ үү.

Веб хуудас (<http://4w.ontsgoisur.gov.mn/>) нь 2019 оны 2-р сарын 1-ний өдрөөс туршилтын журмаар ажиллаж эхэлсэн ба хэрэглэгчдийн санал, хүсэлт гарсан тохиолдолд 2019 оны 4-р сар хүртэл боловсронгуй болгохоор төлөвлөсөн боловч томоохон засвар хийх санал гараагүй.



Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны мэдээллийн веб хуудасны эхний нүүр



Веб хуудасны системийн талаарх уулзалт



Харьяа байгууллагуудад чиглэсэн онлайн сургалт

Зураг II.1.19 Нэгдсэн график төлөвлөгөөний веб хуудас, сургалт явуулсан байдал

(в) Багийн мэйлинг лист

Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны багийн мэйлинг лист (mdptteam@googlegroups.com)-ийг сургалтын төлөвлөгөөний мэдээллийг үр дүнтэй хуваалцах, зохицуулалт хийх зорилгоор байгуулсан. Эхний үед зөвхөн ОБЕГ-ын зүгээс сургалт, уулзалтын талаарх мэдээлэл түгээхэд ашиглаж байсан бөгөөд төслийн зүгээс бусад гишүүн байгууллагуудад хандаж ОБЕГ-аас зохион байгуулж буй гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд хамтран ажиллах, бусад байгууллагатай мэдээлэл хуваалцахдаа ашиглах санал дэвшүүлсэн.

Үйл ажиллагаа 3.2.2 Гамшгаас хамгаалах боловсрол олгох сургалт, сурталчилгааны материал боловсруулж, зорилтот бүлгийн сургалтыг сонгогдсон бүс нутагт зохион байгуулах


1) Орон нутгийн гамшгаас хамгаалах сургалт сурталчилгааны материал боловсруулах

Сургалтын материал шинээр боловсруулахын өмнө орон нутгийн гамшгаас хамгаалах сургалт сурталчилгааны чиглэлээр одоо байгаа сургалтын материалыг цуглуулж, жагсаалт гаргасан (Үйл ажиллагаа 3.1.2-той хамааралтай).

Тэдгээрийн нэг нь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс боловсруулж, ОБЕГ-аас

баталсан “Иргэд”, “Сайн дурынхан”, “Ажилтан албан хаагчид”-д чиглэсэн гамшгаас хамгаалах сургалт явуулах сургалтын хөтөлбөр, сурах бичиг юм. ОБЕГ болон холбогдох байгууллагуудын гамшгаас хамгаалах сургалт сурталчилгааны ажил нь дээрх хөтөлбөртэй уялдаатай явагддаг бөгөөд төслийн багаас “иргэд”-д зориулсан сурах бичиг, сургалтын хөтөлбөрийн агуулгатай нарийвчлан танилцсан. Сурах бичигт гамшгаас хамгаалах сургалт, дадлага сургуулалтын агуулгын талаар нарийвчлан дурдсан байсан ч орон нутгийн иргэдэд чиглэсэн илүү энгийн, ойлгомжтой сургалтын материал шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн.

Дэлхийн Зөн-Монгол ОУБ болон ОБЕГ-аас хэрэгжүүлэх “Гамшигт тэсвэртэй Улаанбаатар” төслийн бүрэлдэхүүн хэсэг 3-ын үйл ажиллагаа (“Бэлэн бай!”)-ны хүрээнд орон нутгийн гамшгаас хамгаалах сургалт сурталчилгааны сургалтын багц боловсруулах ажил хийгдсэн. “Бэлэн бай!” сургалтын багц боловсруулах зорилго нь НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс боловсруулж, ОБЕГ-ын даргын баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу гамшгаас хамгаалах сургалт явуулахад шаардлагатай энгийн, ойлгомжтой сургалтын материал бий болгох явдал бөгөөд энэхүү төслийн үйл ажиллагаатай ижил зорилготой болохыг мэдсэн. Ийнхүү ижил төстэй үйл ажиллагаа гэдгийг мэдсэний дараа ОБЕГ-ын ГУСГ-аас хоёр төслийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах үүднээс гамшгаас хамгаалах сургалт сурталчилгаанд хэрэглэгдэх нэг багц материал боловсруулах хүсэлт тавьсан.



Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Зураг II.1.20 “Бэлэн бай!” хэрэглэгдэхүүний багцын хүрээнд боловсруулсан зорилтот гамшиг ба хэрэглэгдэхүүний төрлүүд

Иймээс ЖАЙКА мэргэжилтний баг нь үйл ажиллагааны давхцал үүсэхээс зайлсхийж, “Бэлэн бай!” (Хүснэгт II.1.17-г үзнэ үү)- багцын бүтэц, агуулгын талаар судалсан. Үүний үр дүнд тус төслийн хүрээнд боловсруулах сургалтын хэрэглэгдэхүүнийг “Бэлэн бай!”-ийн үйл ажиллагаатай уялдуулан боловсруулахаар болсон.

2017 оны 8-р сард болсон ОБЕГ, ЖАЙКА Мэргэжилтний баг болон Дэлхийн Зөн-Монгол ОУБ-ын хамтарсан уулзалтаар ОБЕГ-ын удирдлагын дор сургалтын материал боловсруулах ажилд оролцохоор болсон. Үр дүн 3-2-ын үйл ажиллагааны хүрээнд ийнхүү Дэлхийн Зөн-Монгол ОУБ-тай хамтран ажиллаж, 2018 оны 2-р сарын 2 өдрийн воркшоп сургалт, 2018 оны 2 ба 3-р сард явуулсан уулзалт, бусад үйл ажиллагааны үр дүнд тус төслийн гамшгаас хамгаалах сургалтын хэрэглэгдэхүүнийг 2018 оны 3-р сард боловсруулсан.

**Хүснэгт II.1.17 Сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулахад
ЖАЙКА болон бусад байгууллагын хариуцах хэсэг**

№	Агуулга	Хариуцах байгууллага
1	Гамшгийн талаарх ойлголт, осол, гамшиг, гамшгийн эрсдэл	ЖАЙКА төсөл
2	Өрхийн бэлэн байдал, гамшгийн төрөл бүрээр гамшгийн эрсдлийг бууруулах асуудал	Дэлхийн Зөн (Бэлэн бай) газар хөдлөлт ба өрхийн бэлэн байдлаас бусад
3	Эрэн хайх, аврах ажиллагаа, анхны тусламж	МУЗН
4	Олон нийтийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох	ЖАЙКА төсөл

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Тус төслөөс ОБЕГ-ын даргын А/130 тушаал болон “Бэлэн бай!” сургалтын материалтай уялдуулан төслийн хүрээнд боловсруулах хэрэглэгдэхүүний агуулгыг тодорхойлохын тулд өргөтгөсөн воркшопыг 2018 оны 2-р сард зохион байгуулсан. АХ-ийн гишүүд ихэвчлэн онолын мэдлэг олгодог “Бэлэн бай!”-гаар өгсөн мэдээллийг бататгах дадлага сургуулилтын агуулгатай байх нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрсэн. Түүнчлэн Япон дахь сургалтын үеэр үзэж танилцсан Японы иргэдийн оролцоот гамшгаас хамгаалах буухиа тэмцээн маягаар дадлага сургуулилтыг явуулах нь зүйтэй гэж үзсэн. Тиймээс АХ-ийн гишүүд ЖАЙКА, Дэлхийн Зөн, МУЗН-ийн хариуцах хэсгийг дараах хүснэгтэд үзүүлсэн байдлаар хуваарилсан. Энэхүү үйл ажиллагаа нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгын дагуу ОБЕГ-ын даргын 2016 оны 5-р сарын 10-ний өдрийн А/130 тушаалд заасан иргэдэд чиглэсэн гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны агуулгад үндэслэсэн.

Хүснэгт II.1.18 ЖАЙКА Мэргэжилтний баг ба холбогдох байгууллагуудын сургалтын материал боловсруулахад хариуцах хэсэг

№	Агуулга	Хариуцах байгууллага
1	Гамшгийн талаарх ойлголт, осол, гамшиг, гамшгийн эрсдэл “Лекц 1 цаг”	Дэлхийн Зөн ЖАЙКА төсөл (газар хөдлөлтийн хичээлд техникийн туслалцаа үзүүлэх)
2	Гамшгийн талаарх ойлголт, осол, гамшиг, гамшгийн эрсдэл “Дадлага ажил 1 цаг”	Дэлхийн Зөн ЖАЙКА төсөл
3	Өрхийн бэлэн байдал, гамшгийн төрөл бүрээр гамшгийн эрсдлийг бууруулах асуудал “Дадлага ажил 5 цаг”	ЖАЙКА төсөл
4	Эрэн хайх, аврах ажиллагаа, анхны тусламж “Лекц 1 цаг”	МУЗН
5	Эрэн хайх, аврах ажиллагаа, анхны тусламж “Дадлага ажил 1 цаг”	МУЗН ЖАЙКА төсөл
6	Олон нийтийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцох “Лекц 1 цаг”	Дэлхийн Зөн

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Сургалт нь “Хэн ч, хэзээ ч, хаана ч бэлэн” гамшгаас хамгаалах буухиа тэмцээн нэртэй бөгөөд “Бэлэн бай!” танхимын хичээлээр олж авсан мэдлэгийг бататгах дадлагын хэлбэртэй.



Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Зураг II.1.21 Сургалтын хэрэглэгдэхүүний агуулга

Сургагч багш нарын сургалт болон дунд сургуульд хэрэгжүүлж туршсаны дараа АХЗ-2-оос “Хэн ч, хэзээ ч, хаана ч бэлэн” гамшгаас хамгаалах буухиа тэмцээний гарын авлагын төслийг Монгол орны хэмжээнд ашиглах боломжтой байхаар сайжруулж эцэслэсэн. Буухиа тэмцээний гарын авлага нь буухиа

тэмцээний жишиг хөтөлбөр, өртөө тус бүрийн бэлтгэл ажил, хэрэглэгдэхүүн боловсруулах аргачлал болон өртөөнүүдийн агуулгыг тайлбарласан слайд, өртөө тус бүрийн богино танилцуулга бичлэг бүхий DVD-ээс бүрдэнэ. Гарын авлага болон танилцуулга бичлэгийг ОБЕГ-ын сургалтын вебсайт²-с татаж авах боломжтой.

ЖАЙКА Мэргэжилтний багаас гарын авлагыг хэвлэж, буухиа тэмцээний хэрэгжилтийг дэмжих зорилгоор аймгууд болон нийслэлийн 9 дүүрэгт тарааж өгсөн. Мөн түүнчлэн ОБЕГ нь МУЗН-ийн дэмжлэгтэйгээр 1,000 хувь гарын авлага хэвлүүлж, сайн дурын ажилтнууд болон холбогдох байгууллагуудад тараасан.

Сургагч багшийн сургалт болон иргэдийн воркшоп сургалтанд ашигласан сургалтын хэрэглэгдэхүүнийг НОБГ-т хүлээлгэн өгсөн бөгөөд шаардлагатай байгууллага түр авч хэрэглэх боломжтой.

2) Орон нутгийн гамшгаас хамгаалах сургалт, дадлага явуулах загвар нутгийг сонгох

Төслийн хүрээнд орон нутгийн гамшгаас хамгаалах сургалт дадлага явуулах туршилтын орон нутгийг сонгох талаар АХЗ-2-ын уулзалтаар ярилцсан. Туршилтын орон нутгийг хотын төвийн барилгажсан газрын хувьд насжилт өндөр барилга ихтэй байх, гэр хороололд газар хөдлөлтөөс бусад үер гэх мэт гамшгийн эрсдэлтэй байх, орон нутагт газар хөдлөлтийн эрсдэлтэй байх зэрэг шалгууртай байх талаар ярилцсан. Үүний дүнд Хүснэгт II.1.19-д үзүүлсэн туршилтын орон нутгийн шалгуурын талаар 2017 оны 6-р сарын ХЗХ-ны хуралд анх санал дэвшүүлж, холбогдох хүмүүстэй ярилцаж, судлан 9-р сарын эцсээр болсон Удирдах хорооны хурлаар тогтсон. Уг шалгуурын дагуу Улаанбаатар хотоос Баянгол, Баянзүрх дүүрэг, орон нутгаас Завхан аймгийг эцсийн байдлаар сонгож, 2018 оны 3-р сард хуралдсан Удирдах хороо, 2018 оны 4-р сард хуралдсан ХЗХ-ны хурлаар тус тус баталсан.

² <http://ontsgoisur.gov.mn/pages/khen-ch-khezee-ch-khaana-ch-belen>

Хүснэгт II.1.19 Орон нутгийн гамшгаас хамгаалах сургалт явуулах санал болгосон туршилтын орон нутаг

		Санал болгож буй орон нутаг	Сонгосон шалтгаан
1	УБ хот (төвийн хэсэг)	Баянгол дүүрэг	Шинэ, хуучин, өндөр нам барилга аль аль нь олон байрладаг дүүрэг. Байрлал: УБ-н баруун хэсэгт.
		Санал болгох нэмэлт хувилбар Хан-Уул дүүрэг	Үер усны эрсдэл ихтэй, зөөлөн хөрстэй газар ихтэй. Байрлал: УБ-н урд хэсэг.
2	УБ хот (Гэр хороолол)	Баянзүрх дүүрэг	Шигүү гэр хороолол ихтэй. Байрлал: УБ-н зүүн хэсэг.
		Санал болгох нэмэлт хувилбар Сонгинохайрхан дүүрэг	Дээрхтэй адил. Байрлал: УБ-н баруун зах хэсэг.
3	Хөдөө орон нутаг	Завхан аймаг	Газар хөдлөлтийн магадлал өндөр, бусад хандивлагчдын үйл ажиллагаатай давхардал бага.
		Санал болгох нэмэлт хувилбар Хөвсгөл аймаг Эрдэнэт хот	

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

3) Сургагч багшийн сургалт явуулах

Сургагч багшийн сургалтыг 2018 оны 3-р сарын 21-нд Улаанбаатар хотод, 2018 оны 3-р сарын 26-нд Завхан аймагт Дэлхийн Зөн Монгол ОУБ болон МУЗН-аас зохион байгуулсан “Бэлэн бай” сургалттай хамтарсан байдлаар хэрэгжүүлсэн. Сургалтуудад аймаг, дүүргийн гамшгаас хамгаалах сайн дурын гишүүд, хороо, сумын засаг даргын тамгын газрын ажилтнууд, орон нутгийн насан туршийн боловсролын төвийн мэргэжилтэн зэрэг нийт 75 оролцогч оролцсон.

Сургагч багшийн сургалтын дараа “Гамшгаас хамгаалах буухиа тэмцээн”-ий сургалтын хэрэглэгдэхүүнийг хэрхэн хийх, сургалтыг хэрхэн явуулах агуулгыг багтаасан буухиа тэмцээний гарын авлагын төслийг боловсруулсан.



Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Зураг II.1.22 Туршилтын орон нутагт хэрэгжүүлсэн сургагч багшийн сургалт

4) Орон нутгийн гамшгаас хамгаалах сургалт хэрэгжүүлэх

Завхан аймаг дахь гамшгаас хамгаалах сургалтыг 2018 оны 5-р сарын 12-нд Отгон сум, 2018 оны 5-р сарын 14-нд Улиастай суманд амжилттай хэрэгжүүлсэн. Мөн Улаанбаатар хотын туршилтын орон нутаг болох Баянгол дүүргийн сургалтыг 2018 оны 5-р сарын 17-нд, Баянзүрх дүүргийн сургалтыг 2018 оны 5-р сарын 20-нд амжилттай хэрэгжүүлсэн. Сургалтанд 2018 оны 3-р сарын сургагч багшийн сургалтанд хамрагдсан сургагч багш нар удирдан зохион байгуулж, буухиа тэмцээний гарын авлагын төслийн дагуу явуулсан. Сургалт тус бүрт 50 орчим орон нутгийн иргэд оролцсон ба тухайн орон нутгийн гамшгийн байдал, онцлогт нийцүүлж хэрэгжүүлсэн.



Source: JICA Expert Team

Зураг II.1.23 Туршилтын орон нутаг дахь иргэдэд чиглэсэн гамшгаас хамгаалах сургалт

Түүнчлэн ОБЕГ-ын хүсэлтээр сургагч багшийн сургалтын явуулахын өмнө буюу 2018 оны 3-р сарын 20-нд Монгол улсын Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийн хүрээнд Баянзүрх дүүргийн 87-р сургуульд Гамшгаас хамгаалах буухиа тэмцээн явуулахад сургалтын хэрэглэгдэхүүн материалыг бэлдэн дэмжлэг үзүүлж оролцсон.

5) Бусад орон нутагт түгээн дэлгэрүүлэх

Орон нутгийн иргэдэд чиглэсэн сургалт явуулсны дараа ЖАЙКА-гийн мэргэжилтний багаас буухиа тэмцээний агрын авлагыг хэвлэж нийслэлийн 9 дүүрэг, аймгуудад тараасан. Нэмэлтээр ОБЕГ нь МУЗН-ын санхүүжилтээр 1000 хувийг хэвлэж МУЗН-ын сайн дурынхан болон холбогдох байгууллагуудад тарааж өгсөн.

Буухиа тэмцээний хэрэглэгдэхүүнийг НОБГ-т хүлээлгэн өгсөн ба шаардлагатай байгууллагууд сургалт явуулахдаа авч ашиглах боломжтой. НОБГ-ын Баянгол дүүрэг сургагч багшийн сургалтын дараа уг

хэрэглэгдэхүүнийг ашиглан бие даан сургалт явуулсан. Буухиа тэмцээний хэрэглэгдэхүүнийг бэлдэх тухайд НОБГ-ын харьяа зарим дүүргийн ГУСХ-ээс дүүргийн засаг захиргаанд хандаж гамшгаас хамгаалах сургалт явуулахад зориулан хэрэглэгдэхүүн худалдаж авах талаар хүсэлт гаргасан.

Сургагч багшийн сургалт болон туршилтын орон нутаг дахь иргэдийн сургалтын дараа 21 аймаг, 9 дүүрэгт дээрх хэрэглэгдэхүүнийг ашиглан иргэдэд чиглэсэн сургалтыг илүү өргөн хүрээнд хэрэгжүүлэхийн тулд ОБЕГ болон МУЗН хамтран уралдаан зарласан.

Тус үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудыг идэвхтэй оролцуулах зорилгоор ОБЕГ-ын ГУСГ-ын дарга Батсайханаас төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагуудад 2018 оны 4-р сарын 5-ны өдөр албан бичиг (11/717 тоот) хүргүүлсэн. Уг албан бичигт орон нутгийн “Гамшгийн эрсдэлийг бууруулах зардал”-аас хөрөнгийг шийдвэрлүүлж, хэрэглэгдэхүүний багцыг 2018 оны 5-р сарын 1-ний дотор бэлтгэж, сургалтанд ашиглахыг үүрэг болгосон. ОБЕГ-ын зүгээс түүнчлэн хэрэглэгдэхүүнийг хэрхэн бэлдэх талаар мэдээлэл хүргүүлсэн.

Уг уралдааныг 2018 оны 12-р сарын сүүлээр дүгнэсэн бөгөөд 2019 оны 1-р сараас 3-р улирлын эцсийн байдлын хийгдсэн сургалтын мэдээг дараах хүснэгтэд тус тус үзүүлэв.

Хүснэгт II.1.20 Зохион байгуулсан буухиа тэмцээн болон хэрэглэгдэхүүний тоо

№	Аймаг, дүүрэг	2018 оны эцсийн байдлаар		2019 оны 1 сараас 3-р улирлын эцэс		
		Сургалтын тоо	Хамрагдсан хүн	Сургалтын тоо	Хамрагдсан хүн	Хэрэглэгдэхүүний багц
1	Архангай	25	1,279	11	1,717	1
2	Баянхонгор	6	500	1	12	1
3	Баян-Өлгий	6	900	8	511	1
4	Булган	4	58	12	58	1
5	Говь-Алтай	5	450	6	9,484	1
6	Говьсүмбэр	57	5,878	4	247	1
7	Дархан-Уул	78	4,838	17	1,341	1
8	Дорноговь	80	6,200	16	1,707	1
9	Дорнод	6	378	18	906	1
10	Дундговь	45	606	12	900	1
11	Завхан	6	1,076	32	10,011	1
12	Орхон	10	341	27	929	1
13	Өмнөговь	43	1,543	4	104	1
14	Өвөрхангай	3	230	28	7,639	1

15	Сүхбаатар	15	1,350	38	1,174	1
16	Сэлэнгэ	4	1,200	27	1,729	5
17	Төв	1	40	33	1,142	1
18	Увс	5	306	2	223	1
19	Ховд	8	756	23	2,376	1
20	Хөвсгөл	6	756	6	347	1
21	Хэнтий	10	570	12	3,360	1
22	Нийслэл	100	6,347	229	27,466	9
	Нийт	523	35,602	566	73,383	34

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Үйл ажиллагаа 3.2.3 НИГХСАЗТ-д гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн нөхцөл байдлыг биеэр мэдрүүлэх сургалт, сурталчилгааны хөтөлбөр боловсруулах, сургалт зохион байгуулах

Юуны түрүүнд НИГХСАЗТ-ийн хөтөлбөр, тоног төхөөрөмжийн одоогийн байдалтай танилцсан. НИГХСАЗТ нь 2016 оны 10-р сард албан ёсоор үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд Хятад, Солонгос зэрэг улсад үйлдвэрлэгдсэн газар хөдлөлтийг биеэр мэдрүүлэх тавцан, гамшгаас хамгаалах сургалтын төхөөрөмж зэргийг ашиглан сургалтын үйл ажиллагаагаа явуулж байв.



Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Зураг II.1.24 НИГХСАЗТ-ийн сургалтын хөтөлбөртэй танилцсан байдал

АХЗ-2-ын үйл ажиллагааны хүрээнд төвийн сургалтын агуулга, хөтөлбөртэй танилцаж, одоогийн нөхцөл байдал ба тулгарч буй асуудлуудын талаар ярилцсан. Хэлэлцсэн гол асуудлууд нь дараах байдалтай байна.

- Сургалтын материал, хэрэглэгдэхүүн дутмаг байснаас 2016 оны 10-р сард НИГХСАЗТ-ийн сургалтын хөтөлбөрийг хэсэгчлэн боловсруулж батлуулсан.
- Сургалтанд ихэвчлэн сургуулийн сурагчдыг хамруулж байгаа бөгөөд сургуульдаа автобусгүй сургуулийн хүүхдүүд НИГХСАЗТ-д ирэх боломжоор дутмаг.
- Сургуулийн хүүхдүүд биеэр мэдрэн, хүрэлцэж суралцах боломж бүхий үзүүлэн таниулах материалыг нэмэгдүүлэх шаардлагатай.
- Газар хөдлөлтийг биеэр мэдрэх тавцанд суухын өмнө үзүүлэх видео бичлэгийн газар хөдлөлтийн өмнөх анхааруулгын хэсгийг өөрчлөх шаардлагатай. Учир нь одоогоор газар хөдлөлтийг урьдчилан мэдэх боломжгүй бөгөөд ихэнх тохиолдолд газар хөдлөлт гэнэт болдог.

- Одоогийн сургалтын хөтөлбөрийг илүү баяжуулах үүднээс НИГХСАЗТ-д сайн дурын ажилтнуудыг ажиллуулах боломжийн талаар судлах зэрэг саналыг Япон дахь сургалтаар олж авсан мэдлэгтээ үндэслэн дэвшүүлсэн.

Дээрх асуудлуудад үндэслэн сургалтын төвийн хөтөлбөрийг боловсронгуй болгох уулзалтуудыг 2017 оны 5, 6-р сард зохион байгуулсан. Японы гамшгаас хамгаалах сургалтын төвүүдийн сургалтын хөтөлбөр, агуулгыг танилцуулсны дараа хөтөлбөр нь бүхэлдээ гамшгийн талаар биеэр мэдэрч суралцах боломжтой байхаар сайжруулж ажилласан. Утаат орчноос дүрвэх сургуулилтын үед хүүхэд цээжлэхэд хялбар “О-Ха-Ши-Мо” буюу “Түлхэхгүй, гүйхгүй, ярихгүй, буцаж очихгүй” хэллэг зэрэг Японы холбогдох жишээг танилцуулсан.

2017 оны Япон дахь сургалтын дараа АХЗ-2-ын гишүүд НИГХСАЗТ-ийн үзүүлэн материалыг Японд сурч мэдсэн мэдлэгтээ тулгуурлан сайжруулах талаар хэд хэдэн уулзалт болон 2018 оны 2-р сарын 2 өдрийн воркшопын үеэр ярилцсан. Мөн АХ-ийн гишүүд НИГХСАЗТ-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллах хүсэлтэй Дэлхийн Зөн-Монгол ОУБ-тай үйл ажиллагааны давхардлаас сэргийлэх үүднээс хамтарсан уулзалт хийж, зохицуулалт хийж ажилласан. Үүний үр дүнд ЖАЙКА-гийн төслийн зүгээс НИГХСАЗТ-ийн үзүүлэн материалын агуулгыг сайжруулахтай холбоотой дараах ажлуудыг хийхээр шийдсэн.

- i) Газар хөдлөлтийг биеэр мэдрэх танхимын үзүүлэн материал
- ii) Газар хөдлөлтийн тэсвэржилт, хүчитгэлийн талаар суралцах барилгын макет
- iii) Хүүхдийн өрөөний гамшгаас хамгаалах сургалтын хэрэглэгдэхүүн

1) Газар хөдлөлтийг биеэр мэдрэх танхимын үзүүлэн материал

Ажлын хэсэг 3-2-ын гишүүдээс НИГХСАЗТ-ийн нэг багшийг үзүүлэн самбар боловсруулах ажилд томилсон. 2018 оны 9-р сард хэд хэдэн удаагийн уулзалтын дараа дараах хүснэгтэд үзүүлсний дагуу боловсруулах самбарын талаар тогтов.

Хүснэгт II.1.21 Самбарын агуулга


1) Анхаарах агуулга бүхий самбар	8) Монгол улсад өмнө болж байсан хүчтэй газар хөдлөлтийн тоо баримт, гэрэл зураг
2) Газар хөдлөлт гэж юу вэ? газар хөдлөлтийн талаарх ойлголт	9) Улаанбаатар хот орчимд болох магадлалтай 3 газар хөдлөлтийн
3) Дэлхийн газар хөдлөлтийн тоо баримт, дэлхийн газрын зураг дээр	

4) Японы Хёого мужийн өмнөд хэсгийн (Кобэгийн) газар хөдлөлт	төсөөллийн тоо баримт, газрын зураг дээрх тэмдэглэгээ
5) Японы Кумамотогийн газар хөдлөлт	10) Гэр доторх тавилгын хүчитгэлийн талаар тайлбарласан самбар
6) Японы Нийгата мужийн Чюүэцү газар хөдлөлт	11) Барилгын хүчитгэлийн талаар тайлбарласан самбар
7) Монгол улсад өмнө болж байсан хүчтэй газар хөдлөлтүүдийг газрын зургаар үзүүлэх	*4)-6) нь газар хөдлөлтийг биеэр мэдрэх тавцанд мэдрэх боломжтой чичиргээ

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Төслийн багаас 2018 оны 9-11-р саруудад болсон уулзалтаар үзүүлэн самбарын агуулгын талаар техникийн зөвлөгөө өгч, мэдээлэл, материал, тоо баримтаар хангасан. Түүнчлэн, самбарт ашиглагдах мэдээлэл, тоо баримтын талаар ООГФХ болон бусад холбогдох байгууллага хооронд зохицуулалт хийж ажилласан.

Үзүүлэн самбар боловсруулах ажил 2019 оны 3-р сард эцэслэн дууссан ба НИГХСАЗТ-ийн газар хөдлөлтийг биеэр мэдрэх танхимд үзүүлэн самбар, барилгын газар хөдлөлтийн тэсвэржилт, хүчитгэлийн талаар суралцах макетыг дараах зурагт үзүүлсэн байдлаар байрлуулсан.



Эх сурвалж: ЖАЙКА төслийн мэргэжилтний баг

Зураг II.1.25 Газар хөдлөлтийг биеэр мэдрэх танхимд байрлуулсан үзүүлэн самбар, макетуудын байрлал

Түүнчлэн газар хөдлөлтийн магнитудын хүчийн талаар ойлголт өгөх самбарыг газар хөдлөлтийг биеэр мэдрэх танхимд нэмэлтээр байрлуулсан.



Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Зураг II.1.26 Газар хөдлөлтийг биеэр мэдрэх танхимд байрлуулсан үзүүлэн самбар, макетууд

2) Газар хөдлөлтийн тэсвэржилтийн талаар суралцах барилгын макет (тоосгон ба угсармал барилга)

Ажлын хэсэг 3-2-ын гишүүд нь НИГХСАЗТ-ийн нэг багшийг барилгын макет боловсруулах ажилд томилсон. 2018 оны 5-р сарын 3-ны өдөр барилгын макетыг хэрхэн хийх талаар хялбар воркшопыг АХ2-ын ЖАЙКА-гийн мэргэжилтний дэмжлэгтэйгээр явуулсан ба 2018 оны 6-11-р сар хүртэл техникийн зөвлөгөө өгөх уулзалт хурлыг зохион байгуулсан.

АХ-ын гишүүд барилгын макетын дизайн ба дүр зургийг гаргасны дараа Монголын модон эдлэлийн мужааны тусламжтайгаар дор үзүүлсэн макетуудыг бүтээсэн.




Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Зураг II.1.27 Барилгын макет (зүүн: тоосгон хийц/ баруун: угсармал хийц)

3) Сургалтын хэрэглэгдэхүүн: Хүүхдийн өрөөний ширээний театр

НИГХСАЗТ-ийн нэг багш хүүхдийн өрөө хариуцсан багшаар томилогдсон. Тэрээр СӨБ-ийн арга зүйч нарт зориулсан сургалтад хамрагдаж, хүүхдэд зориулсан сургалтын материал хэрэглэгдэхүүн боловсруулах арга зүйн талаар ойлголт мэдлэгээ гүнзгийрүүлсэн. Ажлын хэсэг 3-2-ын хурлаар мөн асуудлын талаар ярилцаж, боловсруулах сургалтын материалын агуулгыг тогтсон.

Ажлын хэсгийн гишүүдтэй ярилцаж, Дэлхийн Зөн-Монгол ОУБ-тай зохицуулалт хийсний үндсэн дээр хүүхдийн өрөөнд ашиглах гамшгаас хамгаалах сургалтын материал болох ширээний театр (камишибай)-г боловсруулсан. 2019 оны 4-р сарын 24-ний өдөр явуулсан цэцэрлэгийн хүүхдэд зориулсан гамшгаас хамгаалах загвар хичээлд уг ширээний театрыг хүүхдэд уншиж өгч, сургалтанд ашигласан. Модон тайз бүхий ширээний театрыг НИГХСАЗТ-д байрлуулах ба хэвлэмэл ширээний театрыг ОБЕГ, НОБГ, БСШУСЯ, БХ, БМДИ болон АХЗ.1-ын загвар хичээлийн үйл ажиллагаанд оролцсон цэцэрлэгүүдэд хүлээлгэн өгсөн.



Хүүхдэд зориулсан гамшгаас хамгаалах сургалтын материал:
Ширээний театр

Ширээний театр ашиглаж
явуулсан хичээл

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

Зураг II.1.28 Хүүхдийн өрөөний ширээний театр

II.2 Төслийн зорилтын хүрээнд хүрсэн үр дүн

II.2.1 Үр дүн ба шалгуур үзүүлэлтүүд

(1) Үр дүн 1

Төслийн төлөвлөлтийн матрицын (ТТМ) дагуу Үр дүн 1-ийн гүйцэтгэлийг дараах гурван шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

1.1 Боловсруулсан заавар, дүрмийн тоо.

Үйл ажиллагаа 1.1.1-д заасны дагуу “Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний заавар”, “Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар” ба “Гамшгийн мэдээллийн сангийн заавар” гэсэн гурван (3) төрлийн зааврыг Үр дүн 1-ийн хүрээнд боловсруулахаар шийдсэн. “Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”-ын хувьд “Улсын”, “Улсын албадын”, “Орон нутгийн” гэсэн гурван (3) засаг захиргааны төвшний

зааврыг боловсруулахаар шийдсэн. Ингэснээр, эцсийн байдлаар доор үзүүлсэн таван (5) зааврыг боловсруулав.

- ✓ Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний заавар
- ✓ Улсын Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар
- ✓ Улсын албадын Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар
- ✓ Орон нутгийн Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар
- ✓ Гамшгаас хамгаалах орон зайн мэдээллийн системийн үйл ажиллагааны заавар

Түүнчлэн, А/Х 1 нь дараах баримт бичгийг тухайн Зааврын хавсралт болгон боловсруулсан болно. Үүнд:

- ✓ Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний техникийн зааварчилгаа
- ✓ Газар хөдлөлтийн хохирлын үнэлгээнд эксел программ ашиглах гарын авлага
- ✓ Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах гарын авлага

А/Х 1 нь нийт есөн (8) заавар болон гарын авлага боловсруулав. Иймээс гүйцэтгэл өндөр гэж дүгнэсэн.

1.2 Боловсруулсан санамж бичгийн төслийн тоо болон санамж бичгийн талаар санал солилцсон, холбогдох сургалтанд оролцсон байгууллагууд

А/Х 1 нь есөн (9) санамж бичгийн төсөл боловсруулав. Төсөл эхлэх үед дөрвөн (4) салбарын санамж бичиг боловсруулах төлөвлөгөөтэй байв. Боловсруулсан санамж бичгийн тооноос үзвэл тус үйл ажиллагааны гүйцэтгэл өндөр гэж дүгнэв.

Санамж бичигтэй холбоотой сургалтын тухайд, Эрүүл мэндийн яам, Нэгдсэн эмнэлэг, Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэгдсэн холбоо, Монголын эмийн үйлдвэрлэл, хангамж, үйлчилгээний байгууллагууд, ажилтны “Эм” холбоо, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдврийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Зам тээврийн хөгжлийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, ОБЕГ болон НОБГ-аас нийт 38 төлөөлөгч оролцов. Нийт 50 хүн урьснаас 38 хүн оролцсон

байна. Сургалтад оролцсон хүний тооноос үзэхэд сургалтын үйл ажиллагааны гүйцэтгэл хангалттай өндөр байгаагүйг харуулж байна. Хэдийгээр оролцсон хүний тоо их байгаагүй боловч ОБЕГ-тай санамж бичиг байгуулах байгууллага бүгд оролцсон байна. Үүнээс үзэхэд, сургалтын гүйцэтгэл өндөр гэж дүгнэв.

1.3 Гамшгаас хамгаалах Цагаан ном

“Монгол Улсын гамшгаас хамгаалах Цагаан ном 2017”-ыг монгол, англи хэл дээр 2018 оны 12-р сард 300 хувь хэвлүүлэв.

Үүнээс өмнө, 2018 оны 7-р сард УБ хотод зохион байгуулагдсан Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын бага хуралд зориулж А/Х 1-ийн гишүүд Цагаан номын англи хувилбарын хураангуй товхимолыг бэлтгэв. Уг товхимолыг 1,000 ширхэгээр хэвлэж бага хурлын оролцогчдод тараасан байна.

Мөн, А/Х 1-ийн гишүүд “Цагаан ном боловсруулах гарын авлага”-ыг боловсруулав.

Цагаан номын 2018 оны хувилбар хараахан хэвлэгдэн гараагүй байгаа боловч Ажлын хэсэг Цагаан номын агуулгыг боловсруулж дууссан бөгөөд Цагаан номын бүтцийг 2019 оны 10-р сарын ОБЕГ-ын Даргын зөвлөлийн хурлаар батлуулсан. Одоо Цагаан номын агуулгыг эцэслэн хянах ажлыг ОБЕГ-ын ГУСГ гүйцэтгэж байна. Цагаан ном 2019 оны 12-р сард хэвлэгдэн гарах төлөвтэй байна.

(2) Үр дүн 2

Үр дүн 2-ын гүйцэтгэлийг Дараах хоёр шалгуур үзүүлэлтээр дүгнэхээр төсөл төлөвлөлтийн матрицад тусгасан.

2.1. Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний Барилгын дүрэм: Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний тухай сургалтад хамрагдсан хүмүүсийн тоо

БД-үүдийн төсөл нь БХБЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр дэмжигдсэний дараа АХ-2-с 2018 оны 6-р сарын 04-06-ны өдрүүдэд Барилгын үнэлгээний тухай, 07-ны өдөр Дэд бүтэц, ИШС-ний үнэлгээний тухай сургалтуудыг зохион байгуулж барилгын сургалтад 110 хүн, ИШС-ний сургалтад 70 хүн тус тус хамрагдсан нь төслийн зүгээс анх төлөвлөснөөс олон хүн байв. Дээрх төлөвлөгөөт сургалтуудаас гадна Монголын барилгын инженерүүдийн холбооны хүсэлтээр Эрдэнэт хотод 2018 оны 9-р сарын 08-ны

өдөр барилгын үнэлгээний тухай сургалтыг зохион байгуулж 23 инженер хамрагдсан. Энэхүү сургалт нь Монголын барилгын инженерүүдийн холбоотой хамтран тус холбооноос тогтмол зохион байгуулдаг барилгын салбарын инженерүүдэд кредит олгох мэргэшүүлэх сургалтын нэг болгох эхлэлийг тависан бөгөөд барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ, хүчитгэлийн аргачлалыг нэвтрүүлэх, түгээхэд үр дүнтэй болохыг харуулсан.

2018 оны 11-р сарын 12-13-ны хооронд барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний биет судалгаанд ашиглагддаг үл эвдэх аргын багажны тухай сургалтыг зохион байгуулж 64 хүн оролцсон.

Барилгын дүрэмүүд хэвлэгдсэнээс хойш үнэлгээний аргачлалыг нэвтрүүлэх, түгээх зорилгоор өмнө нь дурдсан Сургагч багшийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд нийт 53 хүн хамрагдсан. Мөн МБИХ болон АХ-2-оос хамтарч хэд хэдэн удаагийн сургалтыг хувийн хэвшлийн ААН-үүдийн инженерүүдэд зориулж зохион байгуулсан бөгөөд нийт 68 хүн хамрагдсан.

Үнэлгээний аргачлалтай холбоотой сургалтуудад анх төслийн зүгээс төлөвлөснөөс олон хүн хамрагдсан тул гүйцтгэлийн түвшинг өндөр гэж дүгнэхээр байна.

2.2. Барилгын хүчитгэлийн Барилгын дүрэм: Барилгын хүчитгэлийн аргачлалын тухай сургалтад хамрагдсан хүмүүсийн тоо

Барилгын хүчитгэлийн аргачлалын тухай сургалтын хөтөлбөр агуулгад цутгамал төмөр бетон, угсармал болон өрөгт бүтээцийн барилгуудыг хамруулсан тул тус тусад нь агуулга хөтөлбөр бэлтгэх шаардлагагүй болсон. 2018 оны 05-р сарын 01-03-ны хооронд Барилгын хүчитгэлийн аргачлалын тухай 3-н өдрийн сургалтыг зохион байгуулж 65 хүн хамрагдсан нь анх төслийн зүгээс төлөвлөснөөс олон байсан тул гүйцэтгэлийн түвшин өндөр байна.

(3) Үр дүн 3

Төслийн төлөвлөлтийн матрицын (ТТМ) дагуу Үр дүн 3-ын гүйцэтгэлийг дараах гурван шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ.

3.1 Төслийн хүрээнд гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр зохион байгуулагдсан сургалтын тоо

Хэвлэлийн эх бэлтгэлд хугацаа шаардагдсантай холбогдуулан, Ажлын хэсэг

3-ын тухайд “Аюулгүй амьдрах ухаан” хөтөлбөрийн багшийн гарын авлага 10-р сард хэвлэгдэж, 2019 оны 11-р сард сургууль, цэцэрлэгүүдэд тараагдсан. Сургууль, цэцэрлэг дэх аюулгүй амьдрах ухааны сургалт 2019 оны хичээлийн жилийн 2-р улирлаас хэрэгжиж эхэлнэ. Тиймээс одоогийн байдлаар төслийн үйл ажиллагаанд үндэслэн хийгдсэн гамшгаас хамгаалах хичээлийн бодит тоог гаргах боломжгүй. Нөгөө талаар, сайдын тушаалаар “Аюулгүй амьдрах ухаан” хөтөлбөрийг бүх цэцэрлэг, сургууль хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн тул бодитоор хэрэгжээд явна гэж үзэж байна. Түүнчлэн сургалтын орчныг бүрдүүлэхэд шаардагдах төсвийг шийдвэрлэх, мэргэжлийн байгууллагын хамтын ажиллагааг хангах, ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, багш ажилтнуудад сургалт зохион байгуулах зэрэг агуулгыг багтаасан “Аюулгүй амьдрах ухаан” хөтөлбөрийн цаашдын хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх тушаал гарахаар бэлтгэж байна. Энэхүү тушаал нь сургуулийн гамшгийн эрсдэлийг бууруулах сургалт цаашид хэрэгжих баталгаа болох юм.

3.2 Сургалтын төвөөр үйлчлүүлсэн хүний тоо

Ажлын хэсэг 3 нь 2019 оны 3-р сард Нийслэлийн Иргэдийн Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвийн сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулж дууссан бөгөөд төвийн сургалтын хөтөлбөрийн тухайд “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөртэй уялдуулан боловсронгуй болгох ажил хийгдэж, 2019 оны 7-р сард НОБГ-ын даргын тушаалаар батлагдсан.

НИГХСАЗТ-ийн Газар хөдлөлтийг биеэр мэдрэх танхимын газар хөдлөлтийг биеэр мэдрэх төхөөрөмжийг 2019 оны 3-р сарын 20-ны өдөр хүлээлгэн өгснөөс хойш уг төхөөрөмж болон газар хөдлөлтийн талаарх мэдээлэл бүхий үзүүлэн самбар, газар хөдлөлтийн тэсвэржилтийн талаар суралцах барилгын макет зэрэг сургалтын материалуудыг газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах сургалтанд ашиглах боломжтой болсон.

Газар хөдлөлтийг биеэр мэдрэх тавцанг суурилуулснаас хойш 2019 оны 9-р сарын 17-ны өдөр хүртэлх хугацаанд Газар хөдлөлтийг биеэр мэдрэх танхимын сургалтын хөтөлбөрт хамрагдаж НИГХСАЗТ-д зочилсон хүний тоо 16,820 орчимд хүрсэн. Сургалтын төвд зочилж, сургалтанд хамрагдагсдын задаргааг дор үзүүлэв.

Хүснэгт II.2.1

Ангилал	Сургалтанд хамрагдсан хүний тоо
	2019 оны 03.23-09.17 хүртэл
Төрийн албан хаагч	4,008
Хувийн хэвшлийн ажилтан	5,054
Иргэд	4,372
СӨБ, бага, дунд, ахлах ангийн сурагч	9,041
ИДС-ын оюутан	1,835
Сургууль, ИДС-ын багш	427
Нийт	24,737

Эх сурвалж: НИГХСАЗТ

(4) Шалгуур үзүүлэлтүүд

Төслийн үр дүнг илтгэх шалгуур үзүүлэлтүүдийг Хүснэгт II.2.2.-т тоймлон үзүүлэв.

Хүснэгт II.2.2 Төслийн үр дүн ба шалгуур үзүүлэлт

Үр дүн	Бодит үзүүлэлтүүд	Гарсан үр дүн	
1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хэрэглэгдэх мэдээлэл цуглуулах чадавхыг бэхжүүлж, холбогдох байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах.	1.1 Шинэчлэн баталсан Гамшгаас хамгаалах тухай хуулийн заалтуудыг тусгаж гамшгаас хамгаалах тогтолцоог сайжруулах	<ul style="list-style-type: none"> Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний заавар Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний заавар (“Улс”, “Улсын алба”, “Орон нутаг” зэргийн 3 заавар) Гамшгийн орон зайн мэдээллийн сангийн удирдлага, ашиглалтын заавар Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөлтийн гарын авлага Гамшгаас хамгаалах санамж бичгийг эцэслэх гарын авлага Гамшгаас хамгаалах Цагаан номыг боловсруулах гарын авлага 	<ul style="list-style-type: none"> Нийт боловсруулсан заавар болон үйл ажиллагааны дүрэм, журмын тоо. 8 / 8 (боловсруулахаар төлөвлөсөн) (Нийт 8 зааврын 5 нь батлагдсан.)
	1.2 Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх	<ul style="list-style-type: none"> Төрийн болон холбогдох бусад байгууллагуудын гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хамтран ажиллах санамж бичгүүд (нийт 9 санамж бичиг байгуулахаар төлөвлөсөн) Холбогдох байгууллагуудын гамшгаас хамгаалах орон зайн мэдээлэл солилцох санамж бичиг (нийт 2 санамж бичиг байгуулахаар төлөвлөсөн) 	<ul style="list-style-type: none"> Нийт боловсруулсан санамж бичгийн төсөл 11 / 11 (боловсруулахаар төлөвлөсөн) (6 санамж бичигт албан ёсоор гарын үсэг зурсан.) Санамж бичигтэй холбоотой сургалтанд оролцсон оролцогчдын тоо : 38 оролцогчид (2018 оны 4-р сарын 8)

**Монгол Улсын Газар Хөдлөлтийн Гамшгаас
Хамгаалах Чадавхыг Бэхжүүлэх төсөл
Төслийн Төгсгөлийн Тайлан**

	<p>1.3 Улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулахад хэрэгжүүлэх хяналтын болон мэдээлэл цуглуулах аргачлалыг сайжруулах</p>	<ul style="list-style-type: none"> · Туршилтын аймаг, дүүргүүдэд боловсруулах газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө (2 аймаг болон УБ хотын 2 дүүрэг) · 2017, 2018 оны Гамшгаас хамгаалах Цагаан ном · Гамшгийн орон зайн мэдээллийн санг хамруулсан гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд ашиглах орон зайн мэдээллийн систем 	<ul style="list-style-type: none"> · Туршилтын орон нутгийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагаа (2 аймаг болон УБ хотын 2 дүүрэг) · Гамшгаас хамгаалах Цагаан ном 1 (батлагдсан) / 2 (боловсруулахаар төлөвлөсөн)
<p>2. Төрийн захиргааны албан хаагчдын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ, барилгын хүчитгэл хийх чадварыг бэхжүүлэх.</p>	<p>2.1 Барилга, дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлалыг боловсруулж, үнэлгээний сургалт зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> · Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний заавар (нийт 3 заавар: цутгамал төмөр бетон, угсармал том хавтгаалжин болон өрөгт бүтээцтэй барилгууд) · Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний заавар · Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх гарын авлага 	<ul style="list-style-type: none"> · Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний заавар 4 (батлагдсан) / 4 (боловсруулахаар төлөвлөсөн) · Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний сургалтын оролцогчдын тоо 267 оролцогч (2018 оны 6-р сарын 4-7, 11-р сарын 12-13); Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний багажийг ашиглах сургалт 31 оролцогч (2019 оны 3-р сарын 28); Заавруудын танилцуулга: 21 оролцогч (2019 оны 5-р сарын 6-31); Сургагч багш нарын сургалт
	<p>2.2 Барилгын хүчитгэлийн зааврыг боловсруулж, хүчитгэлийн сургалт зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> · Барилгын хүчитгэлийн заавар (нийт 3 заавар: цутгамал төмөр бетон, угсармал том хавтгаалжин болон өрөгт бүтээцтэй барилгууд) · Барилгын хүчитгэлийн засвар ажлын туршилтын зураг төсөл (нийт 5 төрлийн барилгууд) · Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх гарын авлага 	<ul style="list-style-type: none"> · Барилгын хүчитгэлийн заавар 3 (батлагдсан) / 3 (боловсруулахаар төлөвлөсөн) · Барилгын хүчитгэлийн нийт сургалтын тоо : 107 оролцогч (2019 оны 5-р сар – 9-р сар)
<p>3. Гамшгаас хамгаалах боловсрол, сургалт, сурталчилгааны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх.</p>	<p>3.1 Сургууль, цэцэрлэгийн гамшгаас хамгаалах боловсрол, сургалтын материалын зааврыг боловсруулж, багш нарыг бэлтгэх сургалт зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> · “Аюулгүй амьдрах ухааны боловсролын хөтөлбөр”-ийн заавар · “Аюулгүй амьдрах ухааны боловсролын хөтөлбөр”-ийн зааврын дагуу хичээл заах багш нарын гарын авлага 	<ul style="list-style-type: none"> · Төслийн үйл ажиллагааны дагуу сургуульд зохион байгуулсан гамшгаас хамгаалах хичээлүүдийн тоо Гамшгаас хамгаалах хичээлүүдийг 2019 оны хичээлийн жилийн 2-р улирлаас эхлэн сургууль, цэцэрлэгүүдэд заана

**Монгол Улсын Газар Хөдлөлтийн Гамшгаас
Хамгаалах Чадавхыг Бэхжүүлэх төсөл
Төслийн Төгсгөлийн Тайлан**

3.2 Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны материалыг боловсруулж иргэдэд сургалт зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> · Олон нийтийн оролцоотой гамшгаас хамгаалах үйл ажиллагааны сургалтын материал · Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн гамшгаас урьдчилан сэргийлэх, газар хөдлөлтийн загварчлал, биеэр мэдрүүлэх сургалтын материал · Гамшгаас хамгаалах сургалтын цагийн хуваарийг олон нийтэд сурталчлах цахим хуудас 	<ul style="list-style-type: none"> · Сургалтын төвд ирсэн нийт хүний тоо 2019 оны 3-р сарын 23-аас 9-р сарын 17-ны хооронд нийт 24,737 хүн (9,041 сурагч ба 15,696 иргэд ирсэн байна.) (16,820 хүн Газар хөдлөлтийг биеэр мэдрэх танхимд ирсэн байна.)
--	--	---

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

II.2.2 Төслийн зорилт ба шалгуур үзүүлэлтүүд

2019 оны 6-р сарын 5-нд зохион байгуулсан 8-р ХЗХ-ны хурлын үеэр шинэчлэн тогтоосон Төслийн бодит үзүүлэлтүүдийн дагуу “Газар хөдлөлтийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаагаар дамжуулан Онцгой байдлын ерөнхий газрын чадавхыг бэхжүүлэх” хэмээх Төслийн зорилтод хэр бодитойгоор хүрсэн байдлыг Хүснэгт II.2.3-т тоймлон харуулав.

Хүснэгт II.2.3 Төслийн зорилт, үр дүн ба үзүүлэлтүүд

Төслийн зорилго	Бодит үзүүлэлтүүд	Гарсан үр дүн
Газар хөдлөлтийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаагаар дамжуулан Онцгой байдлын ерөнхий газрын чадавхыг бэхжүүлэх.	<p>Баталсан заавар, дүрэм, журмын тоо /</p> <p>Төслийн хүрээнд боловсруулсан зааврын дагуу боловсруулсан эсвэл шинэчилсэн Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний тоо</p>	<p>ҮР ДҮН 1-ийн үйл ажиллагаа: 7 (батлагдсан) / 8 (боловсруулахаар төлөвлөсөн)</p> <p>ҮР ДҮН 2-ын үйл ажиллагаа: 7 (батлагдсан) / 7 боловсруулахаар төлөвлөсөн)</p> <p>ҮР ДҮН 3-ын үйл ажиллагаа: 2 (батлагдсан) / 2 (боловсруулахаар төлөвлөсөн)</p> <p>Төслийн үйл ажиллагааны хүрээнд боловсруулсан заавруудын дагуу шинээр боловсруулсан, эсвэл шинэчлэн боловсруулсан Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний тоо:</p> <p>· 2 (батлагдсан) / 5 (боловсруулахаар төлөвлөсөн: Улсын, 2 аймгийн, 2 дүүргийн)</p>
	Баталсан заавар, дүрэм, журмын дагуу ОБЕГ-т дараах Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах тогтолцоог бүрдүүлсэн байна:	<ul style="list-style-type: none"> · Орон нутгийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулах, шинэчлэх; · Гамшгаас хамгаалах Цагаан ном боловсруулах · Гамшгийн мэдээллийг цуглуулах, удирдах · Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний ажлыг хэрэгжүүлэх · Гамшгаас хамгаалах боловсрол, сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг дэмжих

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

II.3 Төслийн төлөвлөлтийн матрицад (ТТМ) орсон өөрчлөлтүүд

Хүснэгт II.3.1.-т харуулсан байдлаар ХЗХ-ны хурлын үеэр төслийн төлөвлөлтийн матрицад өөрчлөлт оруулсан.

Хүснэгт II.3.1 ТТМ-д орсон өөрчлөлтүүд

Эх баримт бичиг	Баталсан өдөр	Шинэчилсэн агуулга
8-р ХЗХ-ны хурлын тэмдэглэл	2019 оны 6-р сарын 5	Төслийн ерөнхий зорилгод хүрсэн эсэхийг шалгах бодит үзүүлэлтүүд -Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах -Цагаан ном боловсруулах тогтолцоог бий болгох -Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний зааврыг ашиглах -Газар хөдлөлтийн үнэлгээ, хүчитгэлийн инженерүүдийг үргэлжлүүлэн бэлтгэх -Сургуулиудад гамшгаас хамгаалах боловсролын зааврыг мөрдөх -Баталсан зааврын тоо -Төлөвлөгөөний боловсруулалт/шинэчлэл -Цагаан ном боловсруулах -Гамшгийн мэдээллийг цуглуулах, удирдах - Гамшгаас хамгаалах боловсрол, сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг дэмжих

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

II.4 Бусад

II.4.1 Байгаль орчны болон нийгмийн асуудлууд (байх тохиолдолд)

Байгаль орчны болон нийгмийн асуудлууд нь энэхүү Төслийн хамрах хүрээнээс гадуурх асуудлууд боловч гамшгаас хамгаалах үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөлд анхаарах нь чухал.

II.4.2 Жендерийн эрх тэгш байдал/Энхийг дэмжих/Ядуурлыг бууруулахтай холбоотой асуудлууд (байх тохиолдолд)

Төслийн хүрээнд боловсруулсан зааврын дагуу гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үед, ялангуяа түр хорогдох байрны болон боловсролын үйл ажиллагаанд жендерийн асуудлыг авч үзэх шаардлагатай. Улмаар, бүх иргэдийг гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээллээр тогтмол хангаж байгаа эсэхэд анхаарах шаардлагатай.

III. Хамтарсан хяналтын үр дүн

III.1 DAC үнэлгээний үзүүлэлтүүдэд суурилсан хяналтын үр дүн

(1) Ач холбогдол

“Ач холбогдол” гэдэг үзүүлэлт нь Төслийн төгсгөлийн үед Төсөл хэрэгжүүлэгч орны Засгийн газрын хөгжил, салбарын бодлого болон хөгжлийн шаардлагатай хэр нийцэж байгааг илэрхийлнэ.

Энэхүү Төсөл өндөр ач холбогдолтой. Төсөл нь Гамшгаас хамгаалах тухай хуулийг гамшгийн өмнө авах арга хэмжээ болон эрсдэл бууруулах үйл ажиллагаанд чиглүүлж шинэчлэн найруулах бэлтгэл ажлыг хангаж байх үед эхэлсэн. Хуулийн шинэчилсэн найруулга нь 2017 оны 2-р сард хүчин төгөлдөр болсон бөгөөд шинэчилсэн найруулгын агуулгад эрсдэлийн үнэлгээ, гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах, гамшгаас хамгаалах үйл ажиллагааны хяналт, удирдлага, гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа зохион байгуулах, гамшгийн мэдээллийн санг бүрдүүлэх зэрэг гамшгийн өмнө авах арга хэмжээнүүд багтсан. ОБЕГ нь эдгээр гамшгийн өмнөх үйл ажиллагааг шуурхай хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд энэхүү Төсөл нь эдгээр үйл ажиллагаатай холбоотой юм.

Япон улсын гадаад туслалцааны бодлогын хувьд энэхүү Төсөл нь Японы туршлага дээр суурилж олон нийтийн гамшгаас урьдчилэн сэргийлэх үйл ажиллагааг дэмжих замаар аюулгүй хот, суурин газрууд бий болгох зорилттой нийцэж байна.

(2) Үр ашиг

“Үр ашиг” гэдэг үзүүлэлт нь Төслийн төгсгөлийн үед Төслийн зорилго болон үр дүнгүүд биелсэн эсэхийг илэрхийлнэ.

Төслийн үр ашиг өндөр байна. II-р Хэсгийн, 2-2-т заасны дагуу Бодит үзүүлэлтүүдээс харахаад Төслийн зориолго ерөнхийдөө биелсэн боловч Төслийн зарим үйл ажиллагаа дутуу гүйцэтгэлтэй байна. Үр дүн 1-тэй холбоотой "Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний заавар", "Гамшгаас хамгаалах мэдээллийн сангийн заавар", "Гамшгаас хамгаалах улсын албадын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар", "Аймаг / сумын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар" болон "Нийслэл / дүүргийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар"-ыг холбогдох А/Х боловсруулан батлуулсан. Гэхдээ, "Улсын газар

хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар"-ыг батлуулаагүй байгаа хэдий ч А/Х энэхүү зааврын төслийг боловсруулан ОБЕГ-ын Даргын зөвлөлд хэлэлцүүлэхээр 2019 оны 8-р сард хүргүүлсэн байна. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны холбогдох байгууллагуудын зөвшөөрлийг авахад нилээн хэдэн сар болдог учир “Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний заавар”-ыг хараахан батлуулаагүй байна. Холбогдох байгууллагуудтай хийгдэх ажлаа зохицуулсны эцэст хэдэн сарын дараа заавар батлагдах төлөвтэй байна. Зааврыг батлуулах ажлыг удаашруулж байгаа гадны хүчин зүйл бол гамшгаас хамгаалах холбогдох байгууллагуудын шуурхай бус үйл ажиллагаа байна.

(3) Ашигтай ажиллагаа

“Ашигтай ажиллагаа”-г Төслийн хугацаан дахь төлөвлөсөн зардлыг бодит зардалтай харьцуулж дүгнэнэ.

Ашигтай ажиллагаа боломжийн хэмжээнд байна. Төслийн хугацаан дахь бодит зардал нь төсөвлөсөн хэмжээнээс хэтрээгүй байна. Гэхдээ, төсөвд 14.8 сая япон иенийг доорх хүснэгтэд үзүүлсэнчлэн нэмсэн бөгөөд Япон дахь 2 дугаар сургалт эсвэл 3 дахь орны сургалтын нэмэлт төсөв болгож тусад нь төлөвлөсөн байсан тул анх төлөвлөж байснаар Монголын талын хүсэлтийн дагуу зарцуулсан болно.

Төслийн бодит хэрэгжилтийн хугацаа буюу 2016 оны 11-р сарын 23-ны өдрөөс 2019 оны 11-р сарын 22-ны өдөр хүртэлх хугацаа нь төлөвлөсөн хугацаатай тэнцүү байна.

Хүснэгт III.1.1 Нэмэлт төсвийн агуулга

Хугацаа	Дүн (япон иенээр)	Шалтгаан
2017 оны 10-р сар (Япон дахь 2-р сургалтын өмнө)	14.85 сая	Япон дахь 2-р сургалтад оролцогчдын тоо нэмэгдсэн

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

(4) Нөлөө

“Нөлөө”-г Төслийн төгсгөлийн дараах үнэлгээний үеийн Төслийн ерөнхий зорилгын биелэлтээр дүгнэнэ. Иймээс үүнийг Төслийн төгсгөлийн үед урдчилсан дүгнэлт эсвэл нөлөөний төсөөлөл хэмээн тайлбарлана.

Дор дурдсан шалтгаануудын улмаас Төслийн нөлөө өндөр байна гэж дүгнэв. Хүснэгт II.2.2-т үзүүлсэн Төслийн зорилтуудад ерөнхийдөө хүрсэн бөгөөд эдгээр үр дүн нь Төслийн ерөнхий зорилгод хүрэхэд чиглэсэн гамшгаас

хамгаалахтай холбоотой бодлогыг холбогдох байгууллагууд өрнүүлэхэд үлэмж хувь нэмэр оруулсан тул ийм дүгнэлт гаргасан болно. Цаашид гарч болох нөлөөллийн талаар доор дурдав.

1) Ерөнхий зорилгод хүрэх хэтийн төлөв

Төслөөс II-р Хэсэг, 2-1-т заасан үр дүнгүүд гарах бөгөөд тэдгээр нь ОБЕГ болон холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг дэмжинэ. Хүснэгт III.1.2-т үйл ажиллагааны Бодит үзүүлэлтүүд, тэдгээрийн холбогдох Төслийн Үр дүн болон хэтийн төлөвийг харуулсан байна.

Хүснэгт III.1.2 Ерөнхий зорилго, Бодит үзүүлэлтүүд ба хэтийн төлөв

Ерөнхий зорилго		
Газар хөдлөлтийн эрсдэл буурах.		
Бодит үзүүлэлтүүд	Холбогдох Үр дүн	Хэтийн төлөв
1. Төслийн дагуу боловсруулсан зааврыг ашиглан орон нутгийн түвшинд гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах ажлыг үргэлжлүүлэх.	<ul style="list-style-type: none"> ✓ Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний заавар ✓ Орон нутгийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар 	Зааврын дагуу боловсруулах газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулах ажлыг Аймгийн болон Нийслэлийн дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах ажилтай нэгтгэн ОБЕГ-ын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд оруулж гүйцэтгэнэ гэж үзэж байна.
2. Төслийн дагуу бий болгосон тогтолцоогоор дамжуулан Гамшгаас хамгаалах Цагаан номыг жил бүр боловсруулах.	<ul style="list-style-type: none"> ✓ Гамшгаас хамгаалах Цагаан номын гарын авлага 	Цагаан номыг жил бүр ОБЕГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөнд оруулж тасралтгүй боловсруулна.
3. Төслийн дагуу боловсруулсан зааврыг ашиглан улс даяар олон нийтийн барилга байгууламжинд газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ хийх.	<ul style="list-style-type: none"> ✓ Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний заавар 	Олон нийтийн барилга, байгууламжийн газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээг Хот байгуулалт, хөгжлийн газар, БХБЯ болон МХЕГ зааврын дагуу хийх төлөвлөгөөтэй байгаа. ОБЕГ болон бусад байгууллагуудад газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээний багажийг хүлээн өгснөөр үнэлгээний нарийвчлал болон чанар дээшилнэ.
4. Төслийн дагуу боловсруулсан зааврыг ашиглан улс даяар дэд бүтэц, инженерийн шугам сүлжээнд газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ хийх.	<ul style="list-style-type: none"> ✓ Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний заавар 	Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээг МХЕГ хийнэ гэж үзэж байгаа. ОБЕГ болон бусад байгууллагуудад газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээний багажийг хүлээн өгснөөр үнэлгээний нарийвчлал болон чанар дээшилнэ.

*Монгол Улсын Газар Хөдлөлтийн Гамшгаас
Хамгаалах Чадавхыг Бэхжүүлэх төсөл
Төслийн Төгсгөлийн Тайлан*

<p>5. Төслийн дагуу бий болгосон тогтолцоогоор дамжуулан барилгын хүчитгэлээр мэргэшсэн инженерүүдийг сурган бэлтгэх үйл ажиллагааг үргэлжлүүлэх.</p> <p>6. Төслийн дагуу боловсруулсан зааврыг ашиглан улс даяар сургуулийн гамшгаас хамгаалах боловсролын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.</p> <p>7. Төслийн дагуу бий болгосон тогтолцоогоор дамжуулан улс даяар ОБЕГ-ын санаачлагаар зохион байгуулах олон нийтийн гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны үйл ажиллагааг үргэлжлүүлэх.</p>	<p>✓ Төслийн хэрэгжилтийн хугацаанд холбогдох А/Х газар хөдлөлтийн үнэлгээний инженерүүдийг бэлтгэхэд хүрээнд 3 удаа технологи дамжуулах ажлыг гүйцэтгэжээ.</p> <p>✓ Аюулгүй амьдрах ухаан хөтөлбөр</p> <p>✓ Аюулгүй амьдрах ухаан хөтөлбөрийн гарын авлага</p> <p>✓ Багш нарт зориулсан сургалт зохион байгуулах</p> <p>✓ Олон нийтэд зориулсан гамшгаас хамгаалах сургалтын материал</p> <p>✓ Онцгой байдлын газрууд, МУЗН-ийн сайн дурын ажилтнууд зэрэгт технологи дамжуулах</p> <p>✓ Сургалтын хуваарийг нийтлэх цахим хуудсыг боловсруулах.</p>	<p>БХБЯ, МБИХ нь Төсөл хэрэгжүүлэх хугацаанд сургалтууд зохион байгуулсан бөгөөд цаашид зааврын дагуу барилгын хүчитгэлийн инженерүүдийг үргэлжлүүлэн сурган бэлтгэх төлөвлөгөөтэй байгаа.</p> <p>БССШУЯ нь Багшийн мэргэжил дээшлүүлэх институттай хамтран “Аюулгүй амьдрах ухаан” хөтөлбөрийн агуулгыг 2019 оноос эхлэн багш нарын ерөнхий сургалтын хөтөлбөрт оруулсан байна. Зарим аймаг/дүүргүүд “Аюулгүй амьдрах ухаан” хөтөлбөрийг өөрсдөө бие даан зохион байгуулна гэж үзэж болно.</p> <p>ОБЕГ-ын хүсэлтийн дагуу, дүүрэг бүрийн онцгой байдлын газрууд Төслийн дагуу боловсруулсан олон нийтийн гамшгаас хамгаалах сургалтуудыг тасралтгүй зохион байгуулж ирсэн. Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны үйл ажиллагааны мэдээлэл нийтлэх цахим хуудсыг онцгой байдлын газрууд тасралтгүй ашиглаж иржээ.</p>
---	---	--

Эх сурвалж: ЖАЙКА Мэргэжилтний Баг

2) Ерөнхий зорилго, Төслийн зорилт хоорондын хамаарал

ОБЕГ-ын чадавх бэхжсэнээр гамшгийн эрсдэл буурах учир Ерөнхий зорилго нь Төслийн зорилтоос хазайхгүй байгаа.

3) Төслийн үр дүнгийн цаашдын нөлөө

Ихэнх улс орнуудын засгийн газар нь газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг анх удаа боловсруулж байна. Газар хөдлөлтийн эрсдэлийн үнэлгээний зааварт газар хөдлөлтийн эрсдэлийг үнэлэх хялбаршуулсан аргачлалыг тусгаж үзүүлсэн бөгөөд үүгээр хохирлын төрөлжсөн тоон мэдээллийг тооцож гаргах боломжтой байгаа юм. Энэ нь газар хөдлөлтийн гамшиг болон хариу арга хэмжээ, мөн иргэд газар хөдлөлтийн гамшгийн сонор сэрэмжтэй байх хэрэгцээ шаардлагын талаар гамшгаас урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий бие бүрэлдэхүүний ойлголт мэдлэгийг гүнзгийрүүлэх юм. Засгийн газрын зүгээс гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулснаар гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хувийн хэвшилд

таниулан сурталчлах боломжийг бий болгоно.

Гамшгаас хамгаалах Цагаан номыг хэвлүүлж өргөн цар хүрээгээр олон нийтэд түгээснээр гамшгийн эрсдэлийг бууруулах талаарх ойлголт ухамсар дээшлэх юм.

МБИХ нь газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний талаарх мэдлэгийг өөрийн гишүүн инженерүүдэд олгодог бөгөөд ойрын ирээдүйд барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээний ажлыг эрчимжүүлнэ. Ингэснээр, газар хөдлөлтийн улмаас барилгын нуралтын эрсдэл буурах төлөвтэй байна.

Улмаар, олон нийтийн гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны үйл ажиллагааны үр дүнд шинэ “гамшгаас хамгаалах соёл” бий болно гэж үзэж байна.

(5) Тогтвортой байдал

“Тогтвортой байдал”-г Төслийн үр дүнгийн цаашдын нөлөөний тогтвортой үргэлжлэх байдлаар дүгнэнэ.

Дор дурдсан хүчин зүйлсийн үндсэн дээр Төслийн тогтвортой байдлыг өндөр гэж үзэж байна.

1) Төр засгийн болон ажлын зохион байгуулалтын тогтвортой байдал

Төслийн хүрээнд боловсруулсан заавар, санамж бичиг, бүтэц, зохион байгуулалтын тогтолцоо зэрэг үр дүнгүүдийн хэрэглээг хэвшил болгох замаар төр засгийн болон ажлын зохион байгуулалтын тогтвортой байдлыг хангахыг эрмэлзэж байна. Энэхүү ажлыг аливаа тогтоол, тушаал эсвэл хуулийн хүчинтэй бичиг баримтаар дамжуулан хэвшил болгосноор Төслийн цаашдын үйл ажиллагааны тогтвортой байдал болон хүний нөөцийг хангахад дэмжлэг үзүүлнэ.

2018 оны Цагаан номыг эцэслэх ажил 2019 оны 8-р сарын байдлаар хойшлуулагдсан байна. Цагаан номыг бэлтгэх ажил нь хараахан үйл ажиллагааны хэвшил болоогүй бөгөөд Цагаан номыг цаг тухайд нь нийтлэхэд энэхүү ажлыг тодорхой зохион байгуулалттай хэвшил болгох шаардлагатай.

2) Бүтэц, зохион байгуулалтын тогтвортой байдал

Төслийн үйл ажиллагааг гүйцэтгэх А/Х-үүдийн гишүүдийг ОБЕГ болон холбогдох бусад байгууллагуудаас томилсон. Төсөл хэрэгжих үед Х/А талын албан тушаалтнууд болон А/Х-ийн гишүүд өөр Төсөлтэй

хамааралгүй газар, хэлтэс рүү шилжих тохиолдол нилээд их гарсан тул зарим ажлын гүйцэтгэл удааширсан байна. Бүтэц, зохион байгуулалтын тогтвортой байдлыг хангахын тулд Төслийн үйл ажиллагааг холбогдох газар, хэлтсийн ажлын удирдамжинд оруулсанаар албан тушаалтнууд өөр газар, хэлтэс рүү шилжсэн ч хариуцаж байсан ажлыг нь амжилттай гүйцэтгэх боломжтой болно.

Үр дүн 3-ын хувьд, Төслийн баг нь гамшгаас хамгаалах үйл ажиллагаа явуулдаг ивээн тэтгэгч байгууллагуудын төсөв болон хүний нөөцийг хамгийн үр ашигтайгаар ашиглах үүднээс эдгээр байгууллагуудтай хамтран ажиллах бүтэц, зохион байгуулалтын талаар эхлээд судалсан. Энэхүү хамтран ажиллах бүтэц, зохион байгуулалтыг ОБЕГ-ын дарга журам болгон баталснаар бусад байгууллагуудтай хамтын ажиллагаа өргөжих боломжтой байна, жишээлбэл ОБЕГ МУЗН-ээс хөрөнгө босгож Үр дүн 3-2-н сургалтын материалыг хэвлэж, туршилтын дүүрэг/аймгуудад хэрэгжүүлэх үйл ажиллагааг дэмжих тэмцээн зохион байгуулах боломжтой.

3) Техникийн тогтвортой байдал

Төслийн үр нөлөөг бусад газар нутагт хүргэхийн тулд Үр дүн бүрийн хүрээнд заавар, сургалтын материал боловсруулсан. Техникийн тогтвортой байдлыг хангах үүднээс шаардлагатай үед технологи дамжуулах сургалт зохион байгуулж, Х/А талуудын албан тушаалтнуудыг илтгэгч/зохицуулагчаар ажиллуулахад хичээн зүтгэсэн. Гэвч А/Х-ийн гишүүдийн тоо болон үйл ажиллагаанд хуваарилсан төсөв хязгаарлагдмал байсан учир туршилтын үйл ажиллагааг туршилтын аймгуудаас өөр газар нутагт хэрэгжүүлэх хүндрэлтэй байсан.

Ялангуяа Үр дүн 2-ын стратеги төлөвлөгөөнд төрийн байгууллагуудаас гадна МБИХ зэрэг бусад мэргэжлийн байгууллагуудыг оролцуулж газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ болон хүчитгэлийн ач холбогдлыг сурталчлах үйл ажиллагаа багтсан.

4) Санхүүгийн тогтвортой байдал

Төслийн үр дүнг баталж, хуулийн хүчинтэй болгосноор Төслийн санхүүгийн тогтвортой байдал хангагдана. Улмаар, Төслийн хүрээнд гамшгаас хамгаалах үйл ажиллагаатай холбогдох бусад төрийн байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх тал дээр анхаарсан. Ингэснээр гамшгаас хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх гол байгууллага болох ОБЕГ-ын

чадавхийг бэхжүүлэхэд болон шаардлагатай төсөв хөрөнгийг бусад төрийн байгууллагуудтай хамтран шийдвэрлэхэд чухал хувь нэмэр болох юм.

ОБЕГ-ын бий болгосон хамтын ажиллагааны тогтолцоо болон хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, баталсан эрх зүйн актууд нь ОБЕГ-ын үйл ажиллагаанд хандивлагчид хөрөнгийн тал дээр дэмжлэг үзүүлэхэд илүү таатай үр нөлөөг үзүүлэх тул Төслийн хүрээнд боловсруулсан хандивлагчид болон холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах тогтолцоо нь олон нийтийн гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүгийн тогтвортой байдлыг хангана.

III.2 Хэрэгжүүлэлт болон үр дүнд нөлөөлөх гол хүчин зүйлс

Дор дурдсан зүйлс нь Төслийн үйл ажиллагаанд Үр дүн тус бүр дээр сөргөөр нөлөөлсөн асуудлыг тайлбарлав. Улс төрийн хувьд сөрөг нөлөө байсангүй.

(1) Үр дүн 1

1) Хариуцаж байгаа мэргэжилтэн олон удаа солигдсон, Заавар боловсруулах ажил хойшлогдсон байдал

Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавартай холбогдуулан хоёр төрлийн заавар, тухайлбал “Аймаг / сумын” болон “Нийслэл / дүүргийн” заавруудыг боловсруулахаар анх төлөвлөж байсан боловч Монголын талын хүсэлтийн дагуу дээрх дээр “Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар” болон “Улсын албаны газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар” болох хоёр төрлийн зааврыг нэмж боловсруулахаар болсон. Эдгээр зааврыг боловсруулах ажилд зориулж 2017 оны дунд үед А/Х-т хоёр гишүүнийг сонгож томилсон болно.

Гэвч, дээр дурдсан ажлын хэсгийн хоёр гишүүн 2018 онд шилжсэн бөгөөд хэдэн сарын туршид оронд нь хүн томилогдоогүй. Шинээр гишүүдийг санал болгож байсан боловч, тэд нар мөн өөр газар томилогдон шилжиж байв. Үүний улмаас заавар боловсруулах ажил илт удааширсан болно.

Үүнээс гадна, А/Х-ийн гишүүдийн хувьд Төслийн ажил нь өдөр тутмын үндсэн ажил дээр нь нэмэлтээр даалгаж буй ажил юм. ОБЕГ нь онцгой байдал хариуцсан төрийн байгууллага бөгөөд тушаалаар ажилладаг нягт

зохион байгуулалттай. Иймээс, А/Х-ийн гишүүд нэмэлт байдлаар Төслийн ажлыг гүйцэтгэх үүрэг авсан байсан боловч удаашралтай байх хандлагатай байсан. Энэ нь ажил удаашрах бас нэг шалтгаан байв.

2) Гамшгийн өмнөх үр дүнтэй хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагыг ойлгох

Монгол Улсын хувьд барилга байгууламж, дэд бүтэц болон инженерийн шугам сүлжээ нь хамгаас илүү эмзэг бүрэлдүүлэх хэсэг тул “Гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн гамшгийн өмнөх хөрөнгө оруулалт” гэсэн үзэл баримтлалыг А/Х-ийн үр дүнд нэгтгэж тусгах нь зайлшгүй шаардлагатай юм. Гамшгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн гамшгийн өмнөх хөрөнгө оруулалтын явцад болзошгүй “далд эрсдэл” буюу “үлдэж буй эрсдэл”-ийг тооцож авч үзэхдээ бүтцийн болон бүтцийн бус арга хэмжээг зохистой байдлаар хослуулах нь нэн чухал юм. Мөн, эдийн засгийн хохирол ихээр үүсч болзошгүй бөгөөд шуурхай арга хэмжээ авах шаардлагатай салбаруудыг эрэмблэх нь зүйтэй. Ялангуяа, бүтцийн арга хэмжээг хэрэгжүүлж дуусгахад хэдэн жилийн урт цаг хугацаа шаардагддаг тул тухайн ажлын цаг хугацааны шат дарааллыг төлөвлөгөөнд тусгах шаардлагатай.

3) Цагаан Ном 2018-ыг боловсруулах ажил

Цагаан ном 2018-ыг боловсруулах Ажлын хэсэг байгуулагдаж боловсруулах ажлыг эхлүүлсэн хэдий ч Цагаан ном 2018-ыг хэвлүүлж гаргах ажил нь 2019 оны 11-р сарын байдлаар дуусаагүй байгаа бөгөөд 2019 оны 12-р сард хэвлүүлж гаргах төлөвтэй байна. Цагаан номыг зохих цаг хугацаанд нь (2-р улиралд багтаан) хэвлүүлж гаргахын тулд Цагаан ном боловсруулах ажлыг зохих журам, дүрэмд тусгаж зохицуулах шаардлагатай байна.

4) Гамшгийн орон зайн мэдээллийн системийн удирдлагын хүний нөөцийн хангалттай байдлыг бий болгох

Гамшгийн орон зайн мэдээллийн системийн удирдлагын хувьд тулгарч буй нэгэн бэрхшээл бол хүний нөөцийн дутагдал байна. ГОЗМТХ нь орон зайн мэдээллийн санг ашиглах, удирдах үүрэгтэй боловч одоогийн байдлаар тус хэлтэст хэлтсийн даргын хамт нийт 4 хүн ажиллаж байна. Мөн, 2019 оны 11-р сарын байдлаар, голлох боловсон хүчин болох системийн инженерээр

ганц л хүн ажиллаж байна. Гол үүрэг хариуцаж буй албан тушаалтан хэлтсээс гарах тохиолдолд орон зайн мэдээллийн сангийн тогтвортой үйл ажиллагааг хангахад хүндрэлтэй болно. Энэ нь маш том эрсдэл бөгөөд ОБЕГ-ын тал ГОЗМТХ-т нэмж хэдэн системийн инженер томилох тухай хүсэлтийг ЖМБ-ийн зүгээс гаргаж байна.

(2) Үр дүн 2

1) Аргачлалуудыг Монголын Барилгын дүрэм болгох явц

Аргачлалуудыг практик хэрэглээтэй, үлдэцтэй болгох үүднээс АХ-2-с БХБЯ-ны удирдлаган дор Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөх Барилгын дүрэм болгохоор шийдвэрлэсэн. Учир нь өмнөх төслийн хүрээнд боловсруулсан “Дунд-өндөр давхарын барилгуудыг газар хөдлөлтөд тэсвэртэй барих гарын авлага” нь практик хэрглээнд төдийлэн нэвтэрч чадаагүй. Гэвч Барилгын дүрэм болгон батлуулах явцад цаг хугацаа их шаардагдсан гэдгийг Төслийн зүгээс ойлгосон.

Ажлыг хурдавчилж Төслийн төлөвлөгөөт хугацаанд багтаахын тулд АХ-2 болон Төслийн мэргэжилтний баг нь Техникийн даалгаврыг хамтран боловсруулах, Зөвлөх үйлчилгээний баг болон Мэргэжлийн зөвлөлд тайлбарлах ажлуудыг хийх шаардлагатай болсон. Мөн АХ-2 нь Зөвлөх үйлчилгээний багийн олон удаагийн уулзалтын дараах өөрчлөлтүүдийг тусгаж БД-үүдийн төслийн анхны хувилбарыг боловсруулсан.

2) Ажлын хэсгийн ахлагч болон гишүүдийн олон удаагийн өөрчлөлт

Төсөл хэрэгжих хугацаанд АХ-2-ын ахлагч 3 удаа солигдсон нь АХ-2-ын гишүүдэд үүрэг хариуцлага оногдуулахад хүндрэлтэй болгосон. Мөн Төслийн хугацаанд Ажлын хэсгийн гишүүдэд ч олон удаагийн өөрчлөлт орсон нь технологи дамжуулалт хийхэд хүндрэлтэй болгосон.

Эдгээр асуудлыг шийдвэрлэх үүднээс Төслийн мэргэжилтний багаас ажлын хэсгийн шинэ гишүүддээ зориулж боловсруулж байгаа Барилгын дүрэм дэх аргачлалуудыг танилцуулах семинаруудыг зохион байгуулсан.

3) Технологи дамжуулалатад ашиглагдах хэрэглэгдэхүүн

Барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ, хүчитгэл нь Монголын инженер, мэргэжилтнүүдийн хувьд шинэ технологи тул төсөл хэрэгжих хязгаарлагдмал хугацаанд Монгол талын мэргэжилтнүүд аргачлалуудыг бүрэн ойлгож авах хүндрэлтэй байсан.

Тиймээс Төслийн мэргэжилтний баг болон ажлын хэсгээс үнэлгээний аргачлалыг ойлгоход хялбар болгох үүднээс Микрософт Эксел програмчлалыг бэлдсэн. Энэхүү хэргэлэгдэхүүнийг сургалт, семинаруудад ашигласан бөгөөд сургалтад хамрагдагсдаас өндөр үнэлгээ авсан.

(3) Үр дүн 3

1) Техник хамтын ажиллагааны төслийн үйл ажиллагааг илүү сайн ойлгох

Энэхүү төсөл нь ОБЕГ-ын техник хамтын ажиллагааны анхны төсөл юм. Төслийн баг болон Монголын тал юу хийх ёстой талаар зарим нэг эндүүрэл гарч байсан. ОБЕГ-ын хэрэгжүүлж ирсэн гадаадын тусламжийн төслийн ихэнх нь төслийн гол үйл ажиллагааг тухайн төслийн баг хийж гүйцэтгэж ирсэн бөгөөд үйл ажиллагаанд ОБЕГ-ын оролцоо хязгаарлагдмал байсан. Ийм нөхцөл байдлын улмаас төслийн холбогдох байгууллагын газар, хэлтсийн дарга нар төслийн үр дүнд хүрэхэд зарцуулах хугацааг тооцоолоход хүндрэлтэй байсан ба хамтран ажиллагчид нь үндсэн ажил үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан цаг завгүй байх тохиолдол гарч байсан. Төсөл хамтран хэрэгжүүлэгч байгууллагын алба хаагчид төслийн үйл ажиллагаа болон өөрийн үндсэн ажил үүргийн аль нэгийг гүйцэтгэхээс өөр аргагүй байдалтай тулгарах тохиолдол гарч байсан.

Монголын талын хамтран ажиллагсдыг төслийн үйл ажиллагаанд илүү таатай байдлаар оролцуулан ажиллуулахын тулд Төслийн багаас тэдний удирдлагуудад зохих цаг хугацаанд нь тогтмол тайлбар өгөх, үйл ажиллагааг тайлагнах, зөвлөлдөх гэх мэт үйл ажиллагааг зохион байгуулах шаардлагатай байсан. Түүнчлэн төслийн зохион байгуулалтын талаар илүү сайн ойлголт өгөхийн тулд Төслийн үйл ажиллагааны процедурын талаар хамтран ажиллагчдад нэг бус удаа тайлбарлаж ирсэн.

2) АХ-ийн гишүүдийн боловсруулалтын ажил удааширсан тухай

АХ 3-1-ын гишүүд үе үе орон нутагт томилолтоор ажиллах болон гишүүдийн хувийн шалтгааны улмаас Багшийн гарын авлага боловсруулах ажил тодорхой хугацаанд удааширсан. Багшийн гарын авлагыг эцэслэн боловсруулахад шаардлагатай хугацааг төлөвлөх үүднээс БСШУСЯ нь яамны 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд багшийн гарын авлага боловсруулах ажлыг тусгасан бөгөөд 2019 оны 5-р сард Багшийн гарын авлагыг эцсийн байдлаар боловсруулж дууссан.

3) Веб хуудас боловсруулахад бусад төсөлтэй зохицуулалт хийх

Нэгдсэн график төлөвлөгөө байрлуулан ажиллуулах ажил ОБЕГ ба бусад хандивлагч хоорондын зохицуулалт үе үе өөрчлөгдөж байсантай холбогдуулан хугацаанаасаа хоцорсон. ADPC-ын веб хуудсыг хандивлагчдын мэдээллийг хуваалцах зорилгоор ашиглахад техникийн хүндрэл гарсан бөгөөд ОБЕГ нь Дэлхийн зөн байгууллагын санхүүжилтээр шинэ сервертэй болсон. Энэ талаар шинэ сервертэй болсны дараа мэдээлэл авсан ба анхны агуулгад өөрчлөлт оруулах шаардлагатай болсон. Гамшгаас хамгаалах сургалт явуулах байгууллагуудтай мэдээлэл солилцох зорилго ба зорилтод хүрэхийн тулд серверт веб хуудас байрлуулах, боловсруулах холбогдох байгууллагуудтай зохицуулалт хийх шаардлага тулгарсан.

Холбогдох байгууллагуудын веб платформын систем ялгаатай гэдгийг тодруулсны дараа ОБЕГ болон ЖАЙКА-гийн мэргэжилтний багаас холбогдох байгууллагуудтай нэгдсэн график төлөвлөгөөний үйл ажиллагааны талаар ярилцаж, зохицуулалт хийсэн. Үүний үр дүнд холбогдох байгууллагууд мэдээлэл хуваалцах талаар ойлголттой болсон.

(4) Бүх үр дүнд хамаарах зүйл

1) Холбогдох байгууллага хоорондын хамтын ажиллагаа

Төсөл эхлэхээс өмнө ОБЕГ болон холбогдох байгууллагуудын хоорондын уялдаа холбоо хангалтгүй гэсэн асуудал байсан. Тухайлбал, бусад хандивлагчдын үйл ажиллагаатай давхцаж байгааг Төслийн зүгээс олж тогтоосон. Засаг захиргааны байгууллага, мэргэжлийн байгууллага, хандивлагч зэрэг холбогдох байгууллагуудтай уялдаа холбоогоо бэхжүүлэх нь Монгол Улс дахь гамшгаас хамгаалах гол байгууллага болох ОБЕГ-ын хувьд тэргүүн ээлжийн асуудал юм.

Төсөл нь байгууллага хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааны цар хүрээг АХ-ийн үйл ажиллагаагаар дамжуулан бий болгохыг хичээсэн бөгөөд холбогдох байгууллагын албан тушаалтныг ХЗХ-ны гишүүнээр томилсон. Ийнхүү холбогдох байгууллагуудад төслийн явцын талаарх мэдээллийг цаг тухайд нь хүргэх зорилгоор ОБЕГ-тай тогтмол уулзалт хийх боломжтой болсон. Уг зохион байгуулалт нь ОБЕГ болон холбогдох байгууллагууд нь ажлын үр дүнг илүү оновчтой хуваарилах, зардлыг хуваалцахад хувь нэмэр оруулсан.

2) Сургалтын төвийн уснаас хамгаалах арга хэмжээ

Төсөл нь газар хөдлөлтийн танхимын сургалтын хөтөлбөрийг сайжруулах зорилгоор НИГХСАЗТ-д газар хөдлөлтийн чичирхийллийг биеэр мэдрэх тавцанг суурилуулж, хэмжээсийн загвар, үзүүлэн самбар гэх зэрэг сургалтын хэрэглэгдэхүүнийг хүлээлгэн өгч дэмжиж ажилласан. Энэ жил Улаанбаатар хотод хүчтэй аадар бороо орсны улмаас НИГХСАЗТ-ийн зоорийн давхарт ус нэвтэрч, чичирхийлэх тавцан суурилуулах ажил хойшлогдож, зарим сургалтуудыг зохион байгуулахад боломжгүй байдалд хүргэсэн. Төсөл дуусах үед уг асуудлыг шийдвэрлэхэд ОБЕГ-аас хүний нөөц, төсөв хуваарилалт болон шуурхай ажиллагаа гэх зэргийг цаг тухайд нь зохион байгуулах шаардлагатай байсан.

III.3 Төслийн эрсдэлийн удирдлагын үнэлгээний үр дүн

Өмнөх хэсэгт дурдсан хүчин зүйлсийн тухайд, аливаа нэгэн сөрөг тохиолдол гарах болгонд ЖМБ нэн даруй Төслийн захирал болон/эсвэл Төслийн менежертэй уулзаж Төслийн хэрэгжилтэнд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлэх арга хэмжээний талаар зөвлөлдөж ирсэн.

А/Х-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт, үйл ажиллагааны саатал зэрэг асуудлуудыг Төслийн захирал болон/эсвэл Төслийн менежерийн удирдлагын дагуу ОБЕГ, БХБЯ болон бусад Х/А талын гишүүд цаг тухайд нь зохицуулахад хичээл, зүтгэл гаргаж ирсэн.

Нэг зааврыг Төслийн хугацаанд батлуулаагүй боловч ерөнхийдөө бусад эрсдэлүүдээс сэргийлж чадсан байна.

III.4 Сургамж

(1) Төслийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэх үүднээс зохих үүрэг, хариуцлагатай албан тушаалтнуудыг томилох

А/Х 1-ийн гишүүд ОБЕГ-ын албан тушаалтнууд байсан бөгөөд тэдгээрийн өдөр тутмын ажлын ачааллаас шалтгаалан заавар боловсруулах болон туршилтын газар нутгийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд маш их зүтгэл чармайлт, дэмжлэг шаардагдсан. Мөн түүнчлэн, Япон дахь 2-р сургалтанд явсан А/Х 1-ийн арван гурван (13) гишүүнээс найман (8) гишүүн нь А/Х-ээс шилжсэн эсвэл гарсан бөгөөд энэ нь Төслийн үйл явцад саад учруулсан. Эдгээр асуудлуудаас урьдчилан сэргийлэх үүднээс ОБЕГ зохих үүрэг, хариуцлагатай албан тушаалтнуудыг томилох нь чухал.

(2) Мэдлэг, туршлага хуваалцах

Төслийн хүрээнд технологи дамжуулах үйл ажиллагааг (нэгт) сурах, (хоёрт) зохион байгуулалтанд оруулах, (гуравт) боловсруулах гэсэн гурван (3) үе шатад хуваасан. Төсөл хэрэгжих хугацаанд А/Х-ийн гишүүд өөрсдийн үүрэд, даалгавартаа анхаарч ажилласан учир техникийн мэдлэг өргөжүүлэх үйл ажиллагаа хязгаарлагдмал байсан. А/Х 2 болон А/Х 3-ын үйл ажиллагааны хүрээнд технологи дамжуулах ажлыг тодорхой хэмжээн гүйцэтгэсэн боловч Төслийн Үр дүнгүүдийг зохих хэмжээнд өргөжүүлэхэд илүү мэдлэг хуваалцах шаардлагатай.

(3) Зохих төсвийн хөрөнгийн хуваарилалт

Төслийн хамрах хүрээнд заавар болон гарын авлага боловсруулах, туршилтын орон нутагт үйл ажиллагаа явуулах зэрэг ажлууд багтсан. Туршилтын орон нутгийн үйл ажиллагааг улс даяар хэрэгжүүлэхэд аймгийн түвшинд холбогдох төсвийг батлах шаардлагатай. ОБЕГ нь орон нутгийн онцгой байдлын газар, хэлтсүүдийн хэрэгжүүлэх орон нутгийн гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд төсвийн хөрөнгийг хуваарилахад дэмжлэг үзүүлнэ гэж үзэж байгаа.

Мөн түүнчлэн, Төслийн хүрээнд Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвд газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ болон хүчитгэлийн тоног төхөөрөмж, бусад материал хэрэглэгдэхүүнийг нийлүүлсэн. Газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ, хүчитгэл болон гамшгаас хамгаалах боловсролын үйл ажиллагааны тогтмол хэрэгжилтийг хангах үүднээс ОБЕГ дээр дурдсан тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа болон засвар үйлчилгээний төсвийг батлуулахыг санал болгож байна.

Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн зоорийн давхарт хур борооны улмаас ус нэвчсэнээс шалтгаалан чичирхийллийн тавцанг суурилуулах ажил нь удааширсан бөгөөд суурилуулж дууссаны дараа мөн ус нэвчиж сургалтын үйл ажиллагаа саатсан. Чичирхийллийн тавцангийн аюулгүй ажиллагааг хангах үүднээс Японы тал нь уснаас хамгаалах барилгын засварын ажил гэх зэрэг шаардлагатай арга хэмжээ авахыг удаа дараа ОБЕГ-т хүсэлт тавьсан.

IV. Төсөл хэрэгжиж дууссаны дараа ерөнхий зорилгод хүрэх

IV.1 Ерөнхий зорилгод хүрэх ирээдүйн төлөв байдал

Төслийн ерөнхий зорилгыг “Газар хөдлөлтийн эрсдэл буурна” гэж тодорхойлсон. Төслийн Үр дүн бүрийг Монгол улс даяар дэлгэрүүлж, тогтмол хэрэгжүүлснээр Төслийн ерөнхий зорилгод хүрнэ. Ерөнхий зорилгод хүрэх ирээдүйн төлөв байдлыг III (4) Төслийн нөлөөний Хүснэгт III.1.2.-д хураангуй байдлаар харуулав.

Ерөнхий зорилгод хүрэх ирээдүйн төлөв байдлыг үр дүн тус бүрээр доор дурдав.

(1) Үр дүн 1

Төслийн үйл ажиллагааны хүрээнд боловсруулсан заавруудыг ашиглан Орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагаа үргэлжлэн явагдана.

А/Х-ийн гишүүд газар хөдлөлтийн гамшийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулах талаар холбогдох сургалт-воркшопоор дамжуулан суралцсан бөгөөд орон нутгийн засаг захиргаанд танилцуулан батлуулах чадавхитай болсон. Иймээс, орон нутгийн газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах тухай ОБЕГ-ын тушаал гарвал бэлтгэл ажлууд хийгдэж эхэлнэ.

Сургалт-воркшоп зохион байгуулах аргачлал, шат дарааллыг сайн мэдэх А/Х-ийн гишүүдийн тоо цөөн байгаа бөгөөд эдгээр гишүүд өөр газар томилогдон шилжих тохиолдолд сургалт-воркшопыг зохион байгуулах боломжгүй болох эрсдэлтэй. ОБЕГ нь өөрийн холбогдох мэргэжилтнүүдэд мэдлэг туршлагыг дамжуулах үүднээс туршилтын орон нутгаас бусад орон нутагт газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах ажлыг яаралтай зохион байгуулах шаардлагатай юм.

“Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө”-г шинэчлэн боловсруулах ажлын тухайд, ОБЕГ нь “Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”-т тулгуурлан төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, улсын хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж гамшгийн эрсдэлийг бууруулахад хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

ОБЕГ-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд Цагаан ном боловсруулах ажил нь тодорхой тусгагдсан байгаа бөгөөд Цагаан ном 2018-ыг боловсруулах ажил эхэлсэн хэдий ч 2019 оны 11-р сарын

байдлаар харахан хэвлэгдэж гараагүй байгааг Төслийн зүгээс ажиглалт хийв. Цагаан ном нь гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөхөд шаардлагатай үндсэн мэдээллийг агуулж байдаг тул жил бүр тогтмол тодотгол хийж боловсруулан гаргаж байх нь зүйтэй гэж үзэж байна.

(2) Үр дүн 2

МХЕГ-аас боловсруулсан Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ олгох, паспортжуулах журамд төслөөс шинээр боловсруулсан Барилгын дүрмүүд дэх үнэлгээний аргачлалуудыг ашиглахаар тусгагдсан.

Нийслэлийн хот байгуулалт хөгжлийн газар нь барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээг хийж барилгын паспортжуулалтыг хийдэг. Цаашид шинээр боловсруулагдсан Барилгын дүрэм дэх аргачлалыг үйл ажиллагаандаа ашиглахаар байна.

ОБЕГ нь иргэдийн амь нас, эд хөрөнгийг хамгаалах үүднээс гамшгийн үед эрсдэлд орж болзошгүй сургууль, эмнэлэг болон орон сууц гэх зэрэг барилгын эрсдэлийн үнэлгээг хийнэ. Төслөөс шинээр боловсруулсан Барилгын дүрмүүд дэх газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээний аргачлалууд нь энэхүү ажлыг хэрэгжүүлэх, улмаар хүчитгэх болон шинээр барих гэх зэрэг шаардлагатай арга хэмжээ авахад хувь нэмэр оруулна.

Барилгын хүчитгэлийн аргачлалын тухай сургалтын хөтөлбөр нь Монголын барилгын инженерийн холбооноос тогтмол зохион байгуулагддаг кредит олгох сургалтын нэг болсон. Барилгын салбарын ажилтнуудын мэргэшлийн зэрэг авахад шаардлагатай кредитийг энэхүү сургалтаар авах боломжтой болсон бөгөөд хүчитгэлийн аргачлалын тухай тус сургалт нь тогтмол үргэлжилнэ.

(3) Үр дүн 3

БСШУС сайдын 2018 оны 4 сарын 6-ны өдрийн А/181 тоот тушаалаар батлагдсан “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөр нь сургуулийн боловсролд хамаарал бүхий этгээдүүдийн, гамшгаас хамгаалах агуулгыг багтаасан аюулгүй амьдрах ухааны сургалтыг явуулах үүрэг хариуцлагын талаар тодорхой заасан. Мөн тус хөтөлбөр нь шинээр хичээл нэмэх боломжгүй байгаа өнөөгийн сургуулийн боловсролын нөхцөл байдлыг сайтар бодолцон боловсруулагдсан бөгөөд, одоо байгаа үндсэн хичээл, сургалт дэмжих үйл ажиллагааны агуулгад аюулгүй амьдрах ухааны агуулгыг нэмж оруулан интеграци хэлбэрээр явагдах юм. Түүнчлэн, тус төслийн хүрээнд зохион байгуулагдсан “ААУ” сургалтын хөтөлбөрийг

хэрэгжүүлэх сургагч багшийн сургалтад 21 аймаг 9 дүүргийн арга зүйч нар хамрагдсан бөгөөд, сургалтын үр дүнд сургуулийн гамшгаас хамгаалах боловсрол чухал шаардлагатай болох талаар улсын боловсролын байгууллагын гол субъектүүд сайтар ойлголттой болсон. Энэ утгаараа дээрх зорилт Монголд биелэгдсэн гэж үзэж байна.

Нөгөө талаар, хөтөлбөрийн хэрэгжилтийг улам хангаж ажиллахын тулд “ААУ” хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшийн гарын авлагыг сайжруулж явах шаардлагатай. Гарын авлага нь туршилтын цөөн тооны сургууль цэцэрлэг дээрх үйл ажиллагаагаар дамжуулж боловсруулагдсан тул, орон даяарх сургуулийн сургалтын үйл ажиллагааг тусгаж баяжуулж явбал зүйтэй. Мөн төслийн хязгаарлагдмал хугацаанаас хамаараад, гамшгийн төрлийг бүхэлд нь хамрах боломжгүй байсан учир, гарын авлагын агуулга нь зарим гамшгийн төрөл болон ахуйн эрсдэлийг оруулаагүй. Цаашид сургууль дээр явагдах аюулгүй амьдрах ухааны сургалтаар олж авсан мэдлэг туршлагад үндэслэн гарын авлагыг баяжуулж, сайжруулаад явах шаардлага буй.

Ажлын хэсэг дээр “ААУ” хөтөлбөрийг хэрэгжилтийг хангахад дараах хэдэн арга хэмжээг авах талаар ярилцсан. 1) Боловсролын үнэлгээний төвийн бага сургуулийн 3-р ангийн анги дэвших шалгалтад аюулгүй амьдрах ухааны агуулгыг оруулах, 2) 5-р ангийн эрүүл мэнд, аюулгүй амьдрах ухаан гэсэн дүгнэхэд хүндрэлтэй сургалтын агуулгыг нийлүүлээд мэдлэгийн түвшин тогтоох шалгалт авах, 3) Сургуулийн өөрийн үнэлгээний шалгах хуудсанд аюулгүй амьдрах ухааны асуултыг оруулах. Эдгээр үйл ажиллагааны үр дүнд, нийт улсын хэмжээнд “ААУ” хөтөлбөрийг тасралтгүй хэрэгжүүлэх нөхцөл бололцоо хангагдана.

Төслийн үйл ажиллагааны үр дүнд бий болсон тогтолцоонд үндэслэн, ОБЕГ-ын удирдлага дор гамшгаас хамгаалах боловсрол, сургалт сурталчилгааг орон даяар хэрэгжүүлнэ.

“Гамшгаас хамгаалах буухиа тэмцээн: Хэн ч, хэзээ ч, хаана ч бэлэн” гарын авлагыг Монголд хэрэгжиж байгаа гамшгаас хамгаалах боловсрол, сургалт сурталчилгааны хөтөлбөртэй танилцаж, МУЗН, Дэлхийн зөн Монгол ОУБ зэрэг голлох байгууллагуудтай ярилцаж зөвлөлдсөний үндсэн дээр боловсруулан гаргасан. Мөн 2018 оны 4 сард ОБЕГ-ын Гамшгаас урьдчилан сэргийлэх, сургалт сурталчилгааны газрын даргаас аймаг, хотын ОБГ руу явуулсан тушаалаар тус хөтөлбөрийн дагуу орон даяар буухиа тэмцээн явагдсан бөгөөд 2019 онд ч үргэлжлэн явагдаж байгаа.

Түүнчлэн, “Гамшгаас хамгаалах сургалт сурталчилгааны баг”-ийн үйл ажиллагааг цогц байдлаар таниулах веб хуудсыг бүтээж, багийн хийж буй ажлыг мэдэх боломж олгосон. Энэ утгаараа дээрх зорилт хангагдана гэж үзэж байна.

Нөгөөтэйгүүр, “Гамшгаас хамгаалах буухиа тэмцээн: Хэн ч, хэзээ ч, хаана ч бэлэн” гарын авлага нь насанд хүрэгчдэд зориулан, гадаа хийгдэх үйл ажиллагаанд голлон боловсруулагдсан. Гарын авлагын агуулгын талаар, цаашид оролцогчийн хүртээмжийг нэмэгдүүлэх, гамшгийн төрлийг нэмэгдүүлэх, хүйтэн үед зохиогдох боломжийг хангах зэрэг асуудлыг шийдэх байдлаар илүү өргөн хүрээнд зохион байгуулахад анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

Мөн, төслийн үйл ажиллагааны хүрээнд Гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвийн сургалтын хөтөлбөрийг сайжруулсан бөгөөд, цаашид тус сургалтын төв нь гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны ажилд чухал байр суурьтай оролцож явна. Өнөөдрийн байдлаар, сургалтын төв нь нийслэлд л байгаа бөгөөд хөдөө орон нутгийн иргэдэд ийм төвөөр үйлчлүүлэх боломж муу байна. Монголын 4 бүс бүрт нэг, нэг сургалтын төвийг байгуулбал, гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааны ажлыг илүү өргөн хүрээнд явуулах боломжтой болох юм.

Төслийн хүрээнд ЖМБ нь газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээний багаж болон газар хөдлөлтийг биеэр мэдрэх танхимд суурилуулах чичирхийллийн тавцан, хүүхдийн танхимд зориулсан хэрэглэгдэхүүнийг нийлүүлэхэд дэмжлэг үзүүлж ажилласан. Дээр дурдсан тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүний зохистой ашиглалт болон засвар үйлчилгээтэй холбоотойгоор шаардлагатай хүний нөөц, хөрөнгө төсвөөр хангах нь Ерөнхий зорилгод хүрэхэд зайлшгүй шаардлагатай зүйл юм.

IV.2 Ерөнхий зорилгод хүрэх Монголын талын үйл ажиллагааны төлөвлөгөө болон түүний хэрэгжилтийн бүтэц

Туршилтын үйл ажиллагааг туршилтын газар нутгаас бусад газар нутагт хэрэгжүүлэх нь ерөнхий зорилгод хүрэхэд зайлшгүй шаардлагатай. Иймээс, орон нутгийн засаг захиргааны оролцоо, дэмжлэг нэн чухал болно. Улсын хэмжээн дэх Х/А тал нь орон нутгийн засаг захиргааг хамруулсан хамтын ажиллагааны тогтолцоог бий болгоно. Үр дүн бүрийн үйл ажиллагааны хэрэгжилтийн бүтцийг дор дурдсан байдлаар тайлбарлав.

(1) Үр дүн 1

ОБЕГ болон нийслэл, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтсүүд өөрийн бүс нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулах, сурталчлах, хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд гол үүргийг гүйцэтгэнэ. Ойрын жилүүдэд аймгийн түвшинд гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг сум, багийн түвшинд ОБЕГ удирдлагаар хангаж хэрэгжүүлэх нь зайлшгүй шаардлагатай.

(2) Үр дүн 2

Газар хөдөлт тэсвэрлэлтийн үнэлгээ болон хүчитгэлийн ажлын хяналтын тогтолцоог ОБЕГ бий болгоно гэж үзэж байгаа. Энэхүү хяналтын тогтолцоо нь гамшгаас хамгаалах төлөвлөгөөний боловсруулалт болон хэрэгжилтийн үйл ажиллагааны хяналтанд дэмжлэг үзүүлнэ.

(3) Үр дүн 3

Гамшгаас хамгаалах боловсролын хувьд, ОБЕГ болон НОБГ Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвд практикт суурилсан сургалтаар дамжуулан гамшгаас хамгаалах боловсролыг тогтмол дэмждэг. Гамшгаас хамгаалах боловсролын агуулгыг сайжруулахад ч ОБЕГ-ын зүгээс техникийн дэмжлэг үзүүлэх боломжтой гэж үзэж байгаа.

Олон нийтийн гамшгаас хамгаалах боловсролын хувьд ОБЕГ, НОБГ болон орон нутгийн онцгой байдлын газар, хэлтсүүд ивээн тэтгэгч байгууллагуудтай тогтмол хамтран ажилладаг бөгөөд олон нийтийн гамшгаас хамгаалах боловсролын оролцогч талуудын хоорондын зохицуулалтын үүргийг гүйцэтгэдэг.

IV.3 Монголын талд өгөх санал зөвлөмж

(1) Төслийн үйл ажиллагааг Х/А талын ажлын ерөнхий үүрэг, хариуцлагад тусгах

Төсөл хэрэгжих хугацаанд А/Х-үүдийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлтүүд орсон учраас зарим үйл ажиллагаа саатах эсвэл хойшлогдох тохиолдол гарсан. Үүний шалтгааны нэг хэсэг нь аливаа ажлыг тухайн албан тушаалын үүрэг хариуцлага биш, тухайн хүний үүрэг хариуцлага болгох хандлага юм. Цагаан номыг хэвлүүлэн нийтлэх болон холбогдох байгууллагуудтай санамж бичиг байгуулах зэрэг Төслийн зарим ажил ОБЕГ-ын үндсэн үүрэг биш байсан хэдий ч улсын гамшгаас хамгаалах тогтолцоонд шаардлагатай ажил байсан. Төслийн үр нөлөөний тогтвортой

байдлыг хангах үүднээс холбогдох газар/хэлтсийн ажлын удирдамжинд шаардлагатай үүрэг, хариуцлага бүрийг албан ёсоор тусгахыг санал болгож байна.

(2) Төслийн үр нөлөөг улс даяар дэлгэрүүлэх

Төслийн зорилт нь ОБЕГ-ын чадавхыг бэхжүүлэх бөгөөд Төслийн хүрээнд шууд орон нутгийн түвшинд техникийн туслалцаа үзүүлэхгүй. ОБЕГ болон холбогдох байгууллагуудад технологи дамжуулсны дараа туршилтын газар нутаг дахь үйл ажиллагааг ОБЕГ гүйцэтгэхээр төлөвлөсөн. Төсөл хэрэгжих хугацаанд технологи дамжуулах сургалт болон ХЗХ-ны хурлаар дамжуулан ОБЕГ, нийслэл, орон нутгийн онцгой байдлын газар, хэлтсүүд болон холбогдох бусад байгууллагуудын ажлын хоорондын уялдаа холбоог дэмжсэн.

ОБЕГ нь Монгол улсад гамшгаас хамгаалах голлох үүрэг гүйцэтгэх байгууллага учраас бусад оролцогч талуудтай хамтарч Төслийн гурван Үр дүнг ОБЕГ-ын бодлого, төлөвлөлтийн тогтолцоонд тусгаж, Монгол улс даяар дэлгэрүүлэх ажлыг манлайлан гүйцэтгэх шаардлагатай.

(3) Гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг төсөвлөх

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг улс орон даяар дэлгэрүүлэхэд ОБЕГ нь аймгийн түвшинд шаардлагатай хөрөнгийг төсөвт тусгуулахад дэмжлэг үзүүлж, хяналт тавихыг санал болгож байна.

Мөн ОБЕГ нь Төслийн хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээнд шаардлагатай төсөв хөрөнгийг хангахыг санал болгож байна.

III.4 Сургамж хэсэгт дурдсанчлан, гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс НИГХСАЗТ-ийн зоорийн давхарт ус нэвтрэхээс хамгаалахад шаардлагатай хөрөнгийг төсөвлүүлэх ажлыг яаралтай хийх шаардлагатай.

2019 оны 11-р сарын байдлаар, ус нэвтрэхээс хамгаалах ажил бүрэн хийгдэж дуусаагүй байгаа бөгөөд ирээдүйд тоног төхөөрөмж бороо, үерийн усанд гэмтэх эрсдэл байна. Иймээс шаардлагатай арга хэмжээг нэн даруй авахыг санал болгож байна.

IV.4 Төслийн төгсгөлөөс Төслийн дараах үнэлгээ хүртэлх хугацааны хяналтын төлөвлөгөө

2019 оны 11-р сарын байдлаар батлуулах ажил нь үргэлжлэн явагдаж байгаа “Улсын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө

боловсруулах заавар"-ыг батлуулах ажил болон ОБЕГ-ын Гамшгийн эрсдэлийн удирдлагын газар Төслийн гурван Үр дүнгийн үйл ажиллагааны явц, тэдгээрийн үр өгөөжийг нягтлахад тогтмол хяналт тавьж байгаа үйл явцад ОБЕГ хяналт үнэлгээ хийж, Төслийн хүрээнд боловсруулсан Заавруудын дагуу сургалтууд тасралтгүй зохион байгуулагдаж байгаад хяналт тавина. Үүнтэй холбоотойгоор ЖАЙКА-ын Монгол дахь төлөөлөгчийн газар болон ОБЕГ нь улиралд нэг удаа уулзалт зохион байгуулна.

Хавсралт 1: Төслийн үр дүн

(Томилсон мэргэжилтнүүдийн жагсаалт, Х/А талуудын жагсаалт, Зохион байгуулсан сургалтуудын жагсаалт, г.м.)

Хавсралт 2: Төслийн хүрээнд боловсруулсан баримт бичгийн жагсаалт (тайлан, заавар, гарын авлага, г.м.)

Хавсралт 3: Төслийн төлөвлөлтийн матриц (боловсруулсан бүх хувилбарууд)

Хавсралт 4: Хэлэлцүүлгийн тэмдэглэл, Хурлын тэмдэглэл, ХЗХ-ны хурлын тэмдэглэл (хуулбар) (*)

Хавсралт 5: Хяналтын хуудас (хуулбар) (*)

(Жич: Хавсралт 4 болон Хавсралт 5-г дотоодын ашиглалтанд зориулсан болно.)

Тусад нь гаргах: Төслийн хүрээнд боловсруулсан баримт бичгийн хуулбарууд

- Аймгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөө (Дархан-Уул аймаг)
- Гамшгаас хамгаалах төлөвлөгөө шинэчлэн боловсруулах гарын авлага
- Цагаан ном
- Цагаан ном боловсруулах гарын авлага
- Олон улсын хурал зөвлөгөөнд зориулсан таниулан сурталчлах материал
 - 2018 оны Гамшгийн эрсдэлийг бууруулах Азийн сайд нарын бага хуралд тараасан төслийн танилцуулга
 - Монгол Улсын өрөгт бүтээцтэй барилгын газар хөдлөлт тэсвэрлэлтийн үнэлгээ ба хүчитгэлийн зураг төслийн стандарт, Европын газар хөдлөлтийн инженерчлэлийн 16-р хурал, 2018 он

- Монгол Улсад хуучин барилгын газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ болон хүчитгэлийн стандарт боловсруулах ажил, Азийн газар хөдлөлтийн инженерчлэлийн 7-р хурал, 2018 он
- Монгол Улсад хуучин барилгын газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ болон хүчитгэлийн стандарт боловсруулах ажил, “Хот суурин газрын гамшгийг даван туулах чадварыг бэхжүүлэх нь” олон улсын эрдэм шинжилгээний хурал, 2019 он